



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Боржигон
Мөнхцэцэг МИШЭЭЛ

**ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МОНГОЛ УЛСАД ТУЛГАМДАЖ
БУЙ АСУУДАЛ**



Мэргэжлийн индекс
042101

Эрх зүйн бакалаврын зэрэг
Горилсон дипломын Төсөл

Удирдсан:
С.Батхүлэг /Ph.D/

Улаанбаатар. 2026 он



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Боржигон
Мөнхцэцэг МИШЭЭЛ

ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МОНГОЛ УЛСАД ТУЛГАМДАЖ
БУЙ АСУУДАЛ



Мэргэжлийн индекс
042101

Эрх зүйн бакалаврын зэрэг
Горилсон дипломын Төсөл

Удирдагч: С.Батхүлэг \Ph.D\

Шүүмжлэгч: Л.Хаш \Ph.D\

Улаанбаатар, 2026 он

ГАРЧГИЙН ТОВЬЁГ

МЭДЭГДЭЛ	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iii
ABSTRACT	iv
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	v
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	vi
ОРШИЛ	1
Сэдэв сонгосон үндэслэл	1
Судалгааны зорилго	2
Судалгааны зорилт	2
Судалгааны объект, хүрээ.....	2
Судалгааны арга зүй.....	3
Судалгааны шинэлэг тал.....	3
Судалгааны ач холбогдол	4
I БҮЛЭГ. ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС БА ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МЕХАНИЗМ	5
1.1. Олон улсын гэмт хэрэг.....	5
1.2. ОУЭШ-ийн онцлог	6
1.3. Олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжил.....	8
1.3.1.Нюрнбергийн Олон Улсын Шүүх (1945-1946).....	11
1.3.2 Нюрнбергийн дараах олон улсын эрүүгийн шүүхүүдийн хөгжил	13
1.3.3 Олон улсын эрүүгийн шүүхийн үүсэл, зорилго	15
1.4. Олон улсын эрүүгийн шүүхийн бүтэц, зохион байгуулалт.....	16
1.5 Олон улсын эрүүгийн шүүхийн харьяалал	18
1.6. ОУЭШ-ийн шүүн шийдвэрлэх гэмт хэргүүд.....	19

1.6.1 Төрлөөр устгах гэмт хэрэг	20
1.6.2 Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг	20
1.6.3 Дайны гэмт хэрэг	21
1.6.4 Түрэмгийллийн гэмт хэрэг	22
1.7. ОУЭШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	22
1.7.1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчмууд	22
1.7.2. ОУЭШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат	25
1.7.3 Ял шийтгэл ба хохирол барагдуулах тогтолцоо	26
1.8 Олон улсын эрүүгийн эрх зүйн хариуцлагын онолын үндэслэл, ач холбогдол	27
II БҮЛЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН	
ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН	31
2.1 Монгол Улс Ромын дүрэмд нэгдсэн нь ба үндэсний эрх зүйн тогтолцоонд үзүүлсэн нөлөө	31
2.2. ОУЭШ-ийн үүргийг хэрэгжүүлэх Монгол Улсын эрх зүйн зохицуулалт	33
2.2.1. Монгол Улсын Үндсэн хууль дахь зохицуулалт	33
2.2.2 Монгол Улсын Эрүүгийн хууль дахь зохицуулалт	35
2.2.3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дахь зохицуулалт	37
2.2.4 Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээний зохицуулалт	41
2.3. Монгол Улсад тулгарч буй эрх зүйн болон институцийн хүндрэлүүд	44
2.3.1. Материаллаг эрх зүйн зохицуулалтын хүндрэл	44
2.3.2. Процессын эрх зүйн зохицуулалтын хүндрэл	45
2.3.3. Институцийн болон хэрэгжилтийн хүндрэл	45
2.3.4. ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүрэг ба Монгол–Оросын гэрээний хүрээн дэх эрх зүйн дилемма	46
III БҮЛЭГ. МОНГОЛ УЛСАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ БА ХАРЬЦУУЛСАН	
ШИНЖИЛГЭЭ	48
3.1. ОУЭШ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд тулгардаг олон улсын эрх зүйн асуудлууд	48
3.1.1. Төрийн өндөр албан тушаалтны дархан эрхийн асуудал	48

3.1.2. Ромын дүрмийн 27 ба 98 дугаар зүйлийн зөрчилдөөн.....	50
3.1.3. Нөхөх зарчмын (Complementarity Principle) практик хүндрэл.....	52
3.2. ОУЭШ-ийн практик кейсүүдийн харьцуулсан шинжилгээ	55
3.2.1. Доминик Онгвены хэрэг	55
3.2.2. Омар Аль-Баширын хэрэг.....	56
3.2.3. Жан-Пьер Бембагийн хэрэг	57
3.2.4. Ахмад Аль-Махдийн хэрэг	58
3.3. Монгол Улсын нөхцөл байдал	59
3.3.1. Монгол Улсын эрх зүйн орчны үнэлгээ	59
3.3.2. В.В.Путинтай холбоотой 2024 оны тохиолдол.....	61
3.3.3. Монгол-Оросын эрх зүйн туслалцааны гэрээ ба Ромын дүрмийн үүргийн харьцуулалт	63
3.4. Харьцуулсан дүгнэлт.....	66
ДҮГНЭЛТ.....	69
САНАЛ	71
НОМ ЗҮЙ.....	72

МЭДЭГДЭЛ

дипломын төслийг өөрийн оюуны бүтээл болохыг баталгаажуулж, зохиогчийн эрхийн аливаа зөрчилгүй болохыг баталж байна. Энэхүү дипломын төслийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг би дангаар эзэмшинэ.

Санхүү, Эдийн Засгийн Их Сургуулийн (СЭЗИС) энэхүү бүтээлийг сургалт, судалгаа, ашгийн бус зорилгоор, зохиогчийн эрхийн зөрчлөөс сэргийлэх үүднээс олон улсын Creative Commons Attribution-NonCommercial-NoDerivatives (CC BY-NC-ND) лицензийн дагуу ашиглах эрхтэй.

Нэр: М.Мишээл

Гарын үсэг:

Огноо: 2026/06/10

ТАЛАРХАЛ

Энэхүү бакалаврын дипломын ажлыг гүйцэтгэх явцад үнэтэй зөвлөгөө, чиглэл өгч, мэдлэг туршлагаасаа харамгүй хуваалцан, тууштай дэмжиж ажилласан удирдагч С.Батхүлэг багш болон СЭЗИС-ийн Хууль зүйн сургуулийн багш нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье. Судалгааны арга зүйг зөв тодорхойлох, агуулгыг гүнзгийрүүлэн боловсруулахад өгч байсан зөвлөмжүүд нь энэхүү ажлыг амжилттай гүйцэтгэхэд чухал нөлөө үзүүлсэнд талархал илэрхийлье.

ТОВЧ ХУРААНГУЙ

Энэхүү дипломын ажил нь Олон улсын эрүүгийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, эрүүгийн хариуцлагын тогтолцооны эрх зүйн үндсийг судалж, тэдгээрийг Монгол Улсын эрүүгийн эрх зүйн зохицуулалт болон олон улсын эрх зүйн үүрэгтэй харьцуулан шинжлэхэд чиглэнэ. Олон улсын эрүүгийн шүүх нь хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, түрэмгийллийн гэмт хэрэг болон геноцид зэрэг олон улсын хамтын нийгэмлэгийн ашиг сонирхолд ноцтой хохирол учруулах гэмт хэргийг мөрдөн шалгах, гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэхүү тогтолцооны эрх зүйн суурийг Ромын дүрэм бүрдүүлдэг бөгөөд Монгол Улс уг дүрэмд нэгдэн орсноор дотоодын хууль тогтоомжоо олон улсын эрүүгийн эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх үүрэг хүлээсэн.

Судалгааны хүрээнд Олон улсын эрүүгийн шүүхийн харьяалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим, эрүүгийн хариуцлагын тогтолцоог шинжилж, Монгол Улсын Эрүүгийн хууль болон Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд байгуулсан эрх зүйн туслалцааны гэрээний холбогдох зохицуулалттай харьцуулан судлав. Судалгаанд түүхчилсэн, харьцуулсан эрх зүй, системчилсэн шинжилгээний аргыг ашигласан болно.

Судалгааны үр дүнд Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид Ромын дүрмийн харьяалах үндсэн гэмт хэргүүдийн эрх зүйн зохицуулалтыг тусгасан хэдий ч, олон улсын эрүүгийн эрх зүйн зарим зарчим, тухайлбал хөөн хэлэлцэх хугацааг үл хэрэглэх болон албан тушаалын дархан эрхийг үл харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлаар цаашид боловсронгуй болгох шаардлага байгааг тогтоосон. Мөн олон улсын эрүүгийн эрх зүйн хүрээнд хүлээсэн үүрэг болон хоёр талт эрх зүйн туслалцааны гэрээний хэрэгжилтийн уялдаа холбоог боловсронгуй болгох шаардлагатай талаар дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Түлхүүр үгс: *Олон Улсын Эрүүгийн Шүүх, Ромын дүрэм, эрүүгийн хариуцлага, олон улсын эрүүгийн эрх зүй, харьцуулсан эрх зүй, эрх зүйн туслалцаа.*

ABSTRACT

This thesis examines the legal foundations of the International Criminal Court's (ICC) judicial proceedings and criminal responsibility system, and comparatively analyzes them in relation to Mongolia's criminal law framework and its international legal obligations. The International Criminal Court serves as a permanent international judicial institution responsible for investigating and prosecuting individuals accused of the most serious crimes of concern to the international community, including genocide, crimes against humanity, war crimes, and the crime of aggression. The legal basis of the Court is established by the Rome Statute, to which Mongolia is a State Party. Consequently, Mongolia has undertaken obligations to harmonize its domestic legislation with internationally recognized principles and norms of international criminal law.

This study examines the jurisdiction of the International Criminal Court, its fundamental procedural principles, and its system of criminal responsibility. Furthermore, it compares the relevant provisions of the Criminal Code of Mongolia with the legal framework governing mutual legal assistance between Mongolia and the Russian Federation. Historical, comparative legal, and systematic research methods were employed throughout the study.

The findings indicate that while Mongolia has incorporated the core crimes under the jurisdiction of the Rome Statute into its domestic criminal legislation, certain aspects of international criminal law require further development. In particular, issues related to the non-applicability of statutes of limitations and criminal responsibility irrespective of official capacity warrant closer alignment with international standards. The study also identifies the need to strengthen the coherence between Mongolia's obligations under international criminal law and the implementation of bilateral agreements on legal assistance. Based on these findings, several conclusions and recommendations are proposed for improving the relevant legal framework.

Keywords: *International Criminal Court, Rome Statute, Criminal Responsibility, International Criminal Law, Comparative Law, Mutual Legal Assistance.*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1	ОУЭШ-ийн байгууллагын бүтэц.....	27
Хүснэгт 1.2	ОУЭШ-ийн харьяалал үүсэх үндэслэл.....	29
Хүснэгт 1.3	Нөхөх зарчмын хэрэгжилт.....	30
Хүснэгт 1.4	ОУЭШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат.....	37
Хүснэгт 1.5	ОУЭШ-ийн ял шийтгэлийн үндсэн хэлбэрүүд.....	37
Хүснэгт 2.1	Ромын дүрэм ба Монгол Улсын Эрүүгийн хуулийн харьцуулалт.....	45
Хүснэгт 2.2	Олон улсын эрүүгийн эрх зүйн үндсэн баримт бичгүүд.....	53
Хүснэгт 3.1	ОУЭШ-ийн практик кейсүүдийн харьцуулсан шинжилгээ.....	75

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Тайлбар
ОУЭШ	Олон Улсын Эрүүгийн Шүүх
ОУЦШ	Олон Улсын Цэргийн Шүүх
Ромын дүрэм	1998 оны Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ICTY	Югославын Олон улсын эрүүгийн шүүх
ICTR	Руандагийн Олон улсын эрүүгийн шүүх
ASP	Оролцогч Талуудын Ассамблей
ICC-02/04-01/15	Доминик Онгвений хэргийн дугаар
ICC-02/05-01/09	Омар аль-Баширын хэргийн дугаар
ICC-01/05-01/08	Жан-Пьер Бембагийн хэргийн дугаар
ICC-01/12-01/15	Ахмад аль-Факи аль-Махдигийн хэргийн дугаар
SS	Шутцштаффель (Нацистын хамгаалалтын отряд)
ECCC	Камбожийн Онцгой Танхимууд
НҮБ-ын АЗ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл
SCSL	Сьерра-Леонегийн Тусгай Шүүх
LRA	Эзний Эсэргүүцлийн Арми (Уганда)
Pre-Trial Chamber	Урьдчилан шүүх хуралдаан

ОРШИЛ

Сэдэв сонгосон үндэслэл

Дэлхий дахинд өрнөж буй гэмт хэргийн шинж чанар улам бүр даяаршин, бусад улс орны хэмжээ хязгаарыг давсан гэмт хэрэг улам олширч буйд үндэслэн тэдгээрийг таслан зогсоох, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх олон улсын арга барил өдгөө улам нэмэгдсээр байна. Энэхүү хүрээнд Олон Улсын Эрүүгийн Шүүх 1998 онд байгуулагдан, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг дайны гэмт хэрэг, геноцид¹, зэрэг онцгой зөрчилд хариуцлага тооцох чухал үүргийг гүйцэтгэж байгаа билээ.

Гэвч ОУЭШ нь өөрийн гэсэн албадлагын механизмгүй тул гаргасан шийдвэрийн хэрэгжилт нь гишүүн орнуудын хамтын ажиллагаанаас шууд хамааралтай байдаг. Манай улс Ромын дүрэмд 2000 онд нэгдэн орсон ч шийдвэр хэрэгжүүлэлт, тогтолцоо бүрэн практикт төлөвшөөгүй, тэр дундаа баривчилгаа, шилжүүлэн өгөх журам, эрх бүхий байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоо хангалтгүй байгаагаас үүдэлтэй ноцтой хүндрэл учирч болзошгүй байгаа билээ.

2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин Монгол Улсад албан ёсны айлчлалаар ирсэн. Гэтэл 2023 оны 03 дугаар сард В.Путиныг ОУЭШ-ээс Украин дахь дайны хэргүүдтэй холбоотойгоор баривчлах шийдвэр гаргасан байсан. Монгол Улс нь Ромын дүрмийн гишүүн орон тул тус шийдвэрийг хэрэгжүүлж В.Путиныг баривчлан Гаг руу шилжүүлэх үүрэгтэй байсан боловч тус шийдвэрийг хэрэгжүүлээгүй билээ.

Үүнээс улбаатай 2024 оны 10 дугаар сарын 24-нд ОУЭШ-ын Урьдчилан шүүх хуралдааны II-р танхим /Pre-Trial Chamber II/ албан ёсны шийдвэр гаргаж:

- *“Монгол улс Ромын дүрмийг зөрчиж, ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путиныг баривчлах шийдвэрийг биелүүлээгүй.”*

хэмээн тогтоосон. Энэхүү шийдвэрийг ОУЭШ-ийн бүх гишүүн орнуудад мэдэгдсэн байна. Энэ нь Монгол улсын олон улсад эзлэх байр суурь, нэр хүндэд ноцтой цохилт болсон ч, эдийн засаг, аюулгүй байдалд шууд томоохон хохирол учраагүй.

¹ Геноцид- төрлөөр устгах гэмт хэрэг буюу үндэстэн, угсаатны бүлэг, арьсны өнгө, эсвэл шашин шүтлэгийн тодорхой нэгэн бүлгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн устгах зорилготойгоор үйлдэгдсэн санаатай үйлдэл юм.

ОУЭШ-ийн шийдвэрийг гишүүн улсууддаа бодитойгоор хэрэгжүүлэх асуудал өнөөг хүртэл шийдэгдээгүй, тулгамдсан сорилт хэвээр байсаар байна. Монгол улсад энэхүү чиглэлээр хийгдсэн судалгаа тун ховор. Тэр дундаа ОУЭШ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд дотоодын хууль эрх зүйн орчин ямархуу нөхцөлд байгааг, практик дахь саад бэрхшээлүүдийг нарийвчлан шинжилсэн эрдэм шинжилгээний ажил бараг байхгүй билээ.

Иймд энэхүү эрдмийн ажлын судалгааныхаа хүрээнд Монгол Улсад ОУЭШ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэх орчныг бүх талаас нь судалж, одоогийн тогтолцооны давуу тал, дутагдал, зөрчилтэй асуудлуудыг тодорхойлон илрүүлж, шийдвэрлэх боломжуудыг санал болгох нь миний судалгааны ажлын гол ач холбогдол юм.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь ОУЭШ-ийн шийдвэрийг Монгол Улсад хэрэгжүүлэх эрх зүйн орчин, практик дахь бэрхшээлүүдийг нарийвчлан тодорхойлон, эдгээр асуудлыг шийдвэрлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох боломжит арга замыг дэвшүүлэхэд оршино.

Судалгааны зорилт

/Судалгааны зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэв./

1. ОУЭШ-ийн үүсэл, хөгжил, эрх зүйн үндсийг судлах;
2. Олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжилд ОУЭШ-ийн шийдвэрийн хэрэгжилтийн үүрэг, ач холбогдлыг шинжлэх;
3. Ромын дүрмийн хүрээнд улс орнуудын хүлээх үүрэг, хамтын ажиллагааны механизмыг тодорхойлох;
4. Монгол Улсын дотоод хууль эрх зүйн орчинд ОУЭШ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл, механизм, зөрчлийг тодруулах;
5. Практик хэрэгжилтийн явцад тулгарч буй саад бэрхшээлүүдийг олж илрүүлэн, түүний шалтгааныг нь шинжлэх;
6. Олон улсын туршлагад тулгуурлан ОУЭШ-ийн шийдвэрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд Монгол Улсын хууль эрх зүйн орчныг сайжруулах, боловсронгуй болгох арга зам, санал зөвлөмж боловсруулах.

Судалгааны объект, хүрээ

Судалгааны объект нь ОУЭШ-ээс гаргасан шийдвэр, тушаал, хүсэлтүүдийг гишүүн орнууддаа хэрэгжүүлэх механизмууд, эдгээрийг Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн

тусгаж, хэрэгжүүлж буй байдал болон дотоод хууль эрх зүйн орчин юм. Судалгааны хүрээ нь 1998 оны Ромын дүрэм, ОУЭШ-ийн гаргасан практик шийдвэрүүд, Монгол Улсын дотоод хууль тогтоомжууд, түүнчлэн сонгосон гадаад улсуудын туршлага, хууль эрх зүйн шийдлээр хязгаарлагдана.

Судалгааны арга зүй

Уг судалгаандаа түүхчлэх арга, хууль эрх зүйн шинжилгээ, харьцуулсан судалгаа, системчилсэн анализ зэрэг аргуудыг голлон ашиглав. Эдгээр аргууд нь судалгааны зорилгод бүрэн нийцэж, ОУЭШ-ийн шийдвэрийн хэрэгжилтийн эрх зүйн механизмыг онол, практикийн түвшинд цогцоор шинжлэх боломжийг бүрдүүлсэн хэмээн үзэж байна. Судалгааны эх сурвалжууд нь дараах албан ёсны баримт бичиг, хууль тогтоомж, эрдэм шинжилгээний бүтээлүүд байв:

1. ОУЭШ-ийн албан ёсны баримт бичиг, шийдвэрүүд, дүрэм, журам;
2. 1998 оны Ромын дүрэм болон түүнтэй холбоотой бусад олон улсын баримт бичиг, олон улсын гэрээ, конвенц;
3. Монгол Улсын Үндсэн хууль, эрүүгийн хууль тогтоомж, шүүхийн байгууллагын тухай хууль болон холбогдох бусад хууль эрх зүйн акт;
4. ОУЭШ-ийн хэрэгжилт, олон улсын эрүүгийн эрх зүй, Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх холбогдох эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны ажил.

Судалгааны шинэлэг тал

Монгол Улсад олон улсын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний бодит хэрэгжилт болон шүүх эрх мэдлийн тогтолцоог үнэлэх, ОУЭШ-ийг олон улсын харилцааны субъектийн нэг мөн гэж үзсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажил одоогоор маш цөөн байдгаас, мөн өнөөгийн дэлхийн улс төрийн, эдийн засгийн байр байдлаас үүдэн ОУЭШ нь ямар үүрэг гүйцэтгэж байгаа, хэрхэн үр дүнтэй ажиллаж байгааг бодитойгоор дүгнэх шаардлага өдөр ирэх тусам нэмэгдсээр байгаа билээ.

Иймд уг судалгаа нь зөвхөн олон улсын болон Монгол улсын эрх зүйн хүрээнд хязгаарлагдахгүйгээр, өөр өргөн, шинэлэг үзэл баримтлалыг гаргаж ирж чадна хэмээн үзэж байна.

Судалгааны ач холбогдол

Энэхүү судалгааны ажлын ач холбогдол нь онолын, практикийн болон бодлогын гэсэн гурван үндсэн чиглэлд илэрнэ хэмээн үзэж байна. Үүнд:

Нэгдүгээрт, онолын ач холбогдол:

ОУЭШ-ийн шийдвэрийн хэрэгжилтийг шинжилж, олон улсын шударга ёсны зарчим, түүний давуу тал, сул талуудыг тодорхойлоход хувь нэмэр оруулна. Ингэснээр олон улсын болон үндэсний эрх зүйн харилцан хамаарлыг гүнзгийрүүлэн ойлгоход дэмжлэг болно.

Хоёрдугаарт, практик ач холбогдол:

Монгол Улсад ОУЭШ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бодит хүндрэл, сул талыг олж илрүүлснээр хууль тогтоомж болон тогтолцооны зохицуулалтыг сайжруулахад чиглэсэн санал, гарц боловсруулах боломж бүрдэнэ. Энэ нь шүүхийн байгууллага, прокурор, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Гуравдугаарт, бодлогын ач холбогдол:

Энэхүү судалгааны үр дүн нь Монгол Улсын олон улсын эрх зүйн үүргийн хэрэгжилтийг сайжруулах, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, ирээдүйд эрх зүйн шинэчлэл, өөрчлөлт боловсруулахад бодлогын түвшинд ашиглагдах боломжтой.

I БҮЛЭГ. ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС БА ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МЕХАНИЗМ

1.1. Олон улсын гэмт хэрэг

Олон улсын гэмт хэргийг хүн төрөлхтний нийтлэг ашиг сонирхол, энх тайван, хүмүүнлэгийн үнэт зүйлсийг хүнд ноцтойгоор зөрчсөн, олон улсын эрх зүйн үндсэн зарчмуудыг эвдсэн гэмт хэргүүд гэж ойлгож болно. Хуульч Д.Мөнхтуяа 2000 онд “Олон улсын эрүүгийн эрх зүйн зарим асуудал” номдоо “энх амгалан байдлыг хангах, хувь хүний болон олон улсын хамтын нийгэмлэгийн амин чухал ашиг сонирхлыг хамгаалахад үндэс суурь болох олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээнүүдийг хүн төрөлхтний соёл иргэншилд онцгой аюултайгаар зөрчсөн хэргийг олон улсын гэмт хэрэг гэнэ.” хэмээн томъёолжээ.

Ийм учраас олон улсын гэмт хэргийн гол субъектүүд нь төрийн өндөр албан тушаалтнууд, төрийн тогтолцоо, бодлого хэрэгжүүлэгчид байна. Эдгээр субъектүүдийн үйлдэл нь зөвхөн хувь хүн рүү бус, олон улсын хамтын нийгэмлэгийн аюулгүй байдал руу шууд заналхийлдэг.

Олон улсын гэмт хэргийг 1945 онд анх удаа Олон улсын цэргийн шүүхийн (Нюрнбергийн) дүрэм болон Алс Дорнодын дүрэмд зааж өгсөн. Эдгээр дүрмийн 6 дугаар зүйлд олон улсын гэмт хэргийг гурван үндсэн бүлэгт хуваасан байна:

1. Энх тайвны эсрэг гэмт хэрэг
2. Цэргийн гэмт хэрэг
3. Хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг

Үүнээс хойш олон улсын эрх зүйд:

1948 он- “Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай” конвенцоор төрлөөр устгах гэмт хэргийг;

1968 он- “Дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэх тухай” конвенцоор хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг тус тус олон улсын гэмт хэрэгт албан ёсоор оруулсан байна.

Харин орчин үеийн олон улсын эрүүгийн эрх зүйн хамгийн чухал баримт бичиг бол 1998 оны Ромын дүрэм бөгөөд уг дүрэмд олон улсын гэмт хэргийг дөрвөн том бүлэгт хуваасан байна:

1. Төрлөөр устгах гэмт хэрэг

2. Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг

3. Дайны гэмт хэрэг

4. Түрэмгийллийн гэмт хэрэг. Ийнхүү олон улсын гэмт хэргийн ойлголт түүхэн хөгжлийн явцдаа улам нарийсаж, өнөөгийн ОУЭШ-ийн ажиллагааны үндэс суурь болжээ.

1.2. ОУЭШ-ийн онцлог

Олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжил нь хүн төрөлхтний шударга ёс, хариуцлага хүлээх ухамсар аажмаар бэхжиж буй бодит жишээ бөгөөд ОУЭШ нь 2002 оноос ажиллаж эхэлснээс хойш уг хөгжлийн хамгийн чухал суурь болж, богино хугацаанд дэлхийн хамгийн хүнд, харгис гэмт хэргүүдэд хариуцлага тооцох тогтолцоог үүсгэсэн.

ОУЭШ-ийн гол онцлог нь бусад улс орнуудын шүүх байгууллагуудын оронд орж ажилладаггүй бөгөөд тухайн гэмт хэргийг шалгаж, шийтгэх чадамжгүй тохиолдолд л оролцдог буюу дотоодын эрх зүйн тогтолцоог солих бус дэмжих чиглэлээр оролцдог. Мөн бүх нийтэд үйлчлэх шүүх эрх мэдлийн зарчмыг хөгжүүлснээр гэмт этгээдийг өөр улсад ч, өөрийн улс дотроо ч хариуцлагаас мултрах боломжийг байхгүй болгосон. Үүнтэй холбоотой жишээ дурдвал:

1. Чили улсын дарангуйлагч Аугусто Пиночетийн (1915-2006) хэрэг юм. Тэрээр Чилийн цэргийн генерал бөгөөд 1973 оны 9-р сарын төрийн эргэлтийн үеэр Ерөнхийлөгч Сальвадор Альендэг унагааж, 1973 оноос 1990 он хүртэл 17 жил Чили улсыг захирч дарангуйлсан билээ. Түүний үед албан ёсны тоогоор 3000 гаруй хүн амь үрэгдсэн хэмээн тооцогддог.

Баривчлах үйл явц: 1998 оны 10-р сарын 16-ны өдөр Пиночет Их Британи улсын Лондон хотноо нурууны мэс засал хийлгэхээр очсон бөгөөд тухайн үеийн Испани улсын шүүгч Балтасар Гарсон нь Пиночетийг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, геноцид, хүний эрхийн ноцтой зөрчлүүдэд үндэслэн баривчлах шийдвэр гаргуулсан байна. Лондоны цагдаа нар түүнийг тухайн өдрийн шөнө нь баривчилсан нь дэлхий даяар томоохон дуулиан тарьсан байна. Энэхүү жишээ нь дэлхий дахинаа анх удаа төрийн тэргүүнийг гадаад улсад баривчилсан хэрэг байсан.

2. “Африкийн Пиночет” буюу Хиссене Хабрегийн (1942-2021) жишээ. Тэрээр 1982-оос 1990 оны хооронд Чадын ерөнхийлөгч байсан бөгөөд энэхүү хугацаандаа 40,000 гаруй хүнийг улс төрийн шалтгаанаар хэрцгийгээр амийг нь хороосон. 2000 онд анх удаа ОУЭШ-ээс түүнд

хэрэг үүсгэж, хэрэг нь 10 гаруй жил үргэлжилсээр 2016 оны 05-р сарын 30-нд түүнд насан туршийн хорих оноосон байна.

3. Монгол улсын газар нутаг дээр тохиолдсон ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путиныг баривчлах хүсэлт. 2023 оны 03 дугаар сард ОУЭШ-ээс түүнд болон Мария Львова-Белова /ОХУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх хүүхдийн эрхийн комиссар/ нарт Украин улсаас ОХУ руу хүүхэд хууль бусаар нүүлгэн шилжүүлсэнтэй холбоотой баривчлах шийдвэр гарсан. 2024 оны 09-р сарын 03-нд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путиныг Монгол улс руу айлчлал хийх үед манай орон хамтын ажиллагааны үүргээ зөрчиж, тухайн баривчлах ажиллагааг хийгээгүй байна. Энэ нь манай улс анх удаа ОУЭШ-ийн шийдвэрийг хэрэгжүүлээгүй буюу амжилтгүй шүүхийн тохиолдол болов.

1998 оны Ромын Дүрэм нь олон улсын эрүүгийн гэмт хэргийн хүрээг нэлээдгүй өргөтгөсөн буюу төрлөөр устгах (геноцид), хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны болон түрэмгийллийн гэмт хэргийг тодорхойлж, зэвсэгт мөргөлдөөн, төрийн бодлогын хүрээнд үйлдэгддэг гэмт хэргүүдийг олон улсын хэмжээнд хариуцлага хүлээлгэх боломжийг нээсэн. Түүнчлэн насанд хүрээгүй хүүхдийг цэргийн албанд татахыг гэмт хэрэгт тооцсон нь мөн маш чухал шинэчлэл байв. Өмнө нь насанд хүрээгүй хүүхдийг цэрэгт татахыг зөвхөн хүний эрхийн зөрчил гэж үздэг байсан бол Ромын дүрэмд насанд хүрээгүй хүүхдийг үндэсний зэвсэгт хүчинд албадан татах, элсүүлэх эсвэл зэвсэгт бүлэглэлд албадан элсүүлэх, тэдгээрийг зэвсэгт мөргөлдөөнд идэвхтэй оролцуулах нь дайны гэмт хэрэг юм хэмээн тодорхойлсон. Үүнтэй холбоотой хамгийн алдартай хэрэг нь Доминик Онгвены хэрэг юм. Тэрээр өөрөө бага насандаа цэргийн албанд татагдаж, цаашлан цэргийн командлагч болсон ба өөрөө насанд хүрэн олон зуун хүүхдийг цэрэгт татаж, байлдаанд ашигласан байна. Иймээс 2021 онд түүнд ОУЭШ-ээс бүх насаар нь хорих ял оноожээ.

ОУЭШ-ийн бас нэг томоохон онцлог нь хохирогчдын оролцоог хүлээн зөвшөөрсөн явдал байв. Хохирогчид нь зөвхөн гэрч бус, шүүхийн процесс-д идэвхтэй оролцож, өөрсдийн зовлон, хохирлын талаар шууд тайлбарлах, нотлох баримт гаргах эрхтэй хэмээн үзсэн. Энэ нь уламжлалт шүүхээс ялгарч, хохирогчдын эрхийг хамгаалж, шударга ёсыг бий болгоход чухал ач холбогдолтой.

Хэдийгээр өнөөг хүртэл улс төрийн саад бэрхшээл, зарим томоохон орнуудын Ромын Дүрэмд нэгдээгүй байдал зэрэг хүндрэлүүд учирсаар байгаа ч ОУЭШ-ийн “ялаас мултрах, ял

шийтгэлгүй үлдэх” тохиолдлыг бууруулж, олон улсад хариуцлагын соёлыг бага багаар бэхжүүлсээр байна.

Үүнээс харвал ОУЭШ-ийг дэлхий дахинаа үйлдэгдсэн аймшигт гэмт хэрэг гарсан үед авагдах эцсийн арга хэмжээ гэж ойлгож болно. Дотоодын шүүхүүд ажиллах чадваргүй, боломжгүй үед хохирогчдод шударга ёсыг олгох, энх тайвныг бэхжүүлэх үүрэгтэй.

1.3. Олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжил

Олон улсын эрх зүй нь хүн төрөлхтний түүхэнд харьцангуй сүүлд бүрэлдэн тогтсон эрх зүйн салбар бөгөөд улс орнуудын хоорондох хамтын ажиллагааг эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэх чухал механизм болжээ. Улс орнууд ихэнх тохиолдолд гэмт хэрэгтэй тэмцэхэд дотоодын хууль эрх зүйн системээрээ дамжуулж арга хэмжээ авдаг. Гэвч зарим нэг онцгой тохиолдлын гэмт хэргүүдийг, тэр дундаа олон улсын шинж чанартай, хил дамнасан, эсвэл хүн төрөлхтний ашиг сонирхлыг хөндсөн гэмт хэргийн хувьд ганц тэр улсынхаа хүчээр шийдвэрлэх боломжгүй байдаг.

Олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжил нь “ял шийтгэлгүй байдал” (impunity)-ыг арилгах, олон улсын шударга ёсыг бэхжүүлэхэд чиглэгдсэн удаан хугацааны тэмцлийн үр дүн юм. XX зууны эхээр Нюрнберг, Токиогийн олон улсын цэргийн шүүхүүд (1945-1946) анх удаа төрийн өндөр албан тушаалтнуудыг олон улсын гэмт хэрэгт хариуцлага тооцуулжээ. Үүний дараа 1948 оны Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх конвенц, 1949 оны Женевийн конвенцууд зэрэг баримт бичиг гарч, олон улсын эрүүгийн эрх зүйн суурь тавигдаж эхэлсэн.

Орчин үед гэмт хэргийн шинж чанар эрс өөрчлөгдөж, глобалчлал, шинжлэх ухаан технологийн хөгжил, хил дамнасан үйл ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотойгоор терроризм, кибер гэмт хэрэг, хүний наймаа, цөмийн болон химийн зэвсэг тархах аюул зэрэг шинэ сорилтууд тулгарч эхэллээ. Нэг улс өөрөө энэ төрлийн гэмт хэрэгтэй ганцаараа тэмцэхэд хангалтгүй болсон цаг тул улс орнуудын хамтын ажиллагаа, олон улсын эрх зүйн механизмын зайлшгүй шаардлага үүссэн. (М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, 1999).

1998 онд Ромын дүрэм батлагдан, 2002 онд Олон улсын эрүүгийн шүүх (ОУЭШ) байгуулагдсанаар олон улсын эрүүгийн эрх зүй шинэ шатанд гарч, олон улсын гэмт хэрэгт хариуцлага тооцох байнгын, бие даасан шүүхийн тогтолцоог бий болгосон анхны томоохон алхам байв.

Түүхэн замнал:

1. Эртний үе:

- МЭӨ 1296 (ойролцоогоор МЭӨ 1259) он- III Хаттусили (Хеттийн хаан) болон II Рамсес (Египетийн фараон)-ын хооронд байгуулсан Кадешгийн гэрээ. Энэ нь дэлхийн хамгийн эртний мэдэгдэж буй энх тайвны гэрээ бөгөөд гэмт этгээдийг шилжүүлэх (extradition) тухай заалт агуулснаараа онцлог юм.
- МЭӨ 431-404 он- Пелопоннесийн дайны үед Афины болон Спартагийн хооронд гэмт хэрэгтнийг шилжүүлэх тухай гэрээ байгуулагдсан буюу энэ үед олон улсын харилцаанд “гэмт этгээдийг өөр улсад нуугдахгүй” байх зарчим анх удаа гарсан байна.

2. XIX зуун- Боолчлол, боолын худалдаатай тэмцэх үе:

- 1802 оны Амьены гэрээ- Англи, Францын хооронд байгуулагдсан, боолын худалдааг хязгаарлах анхны оролдлого.
- 1815 оны Венийн Конгресс- Наполеоны дайны дараа Европын их гүрнүүд боолын худалдааг “хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг” гэж үзэх эхлэлийг тавьсан.
- 1818 оны Аахены конгресс- Боолын худалдааг дарангуйлах тухай шийдвэрүүдийг баталгаажуулсан.
- 1841 оны Лондоны гэрээ- Боолын худалдаатай тэмцэхэд зориулсан олон улсын анхны томоохон гэрээ.
- 1862 оны Англи, АНУ-ын гэрээ- Боолын худалдааг хориглох тухай хоёр талын гэрээ.
- 1885 оны Берлиний Конференцийн Ерөнхий акт- Африкийг хувааж байх үед боолын худалдааг хориглох заалт оруулсан.
- 1890 оны Брюсселийн бага хурал- Боолын худалдааг олон улсын хэмжээнд дарах тухай конвенц.
- 1899 оны Лондоны олон улсын конгресс- Боолын худалдаа, хүний наймаатай тэмцэх чиглэлээр ахиц гаргасан. Энэ үе нь орчин үеийн олон улсын эрүүгийн эрх зүйн практик дахь хамтын ажиллагааны эхлэл болсон.

3. Дэлхийн I дайны дараах үе:

- 1919 оны Версалийн энх тайвны гэрээ- Германы эзэн хаан II Вильгельмийг олон улсын хүнд гэмт хэрэг үйлдсэн хэмээн шүүхэд татахыг оролдсон анхны томоохон оролдлого байв. Гэвч Нидерланд улс гэмт хэрэгтнийг шилжүүлээгүй тул шүүх хурал болж чадаагүй.

4. Дэлхийн II дайны дараах үе:

- 1945 он- Нюрнбергийн Олон улсын цэргийн шүүхээр Нацист Герман улсын 24 гол удирдагчийг шүүж, “хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг”, “энх тайвны эсрэг гэмт хэрэг” гэх ойлголтуудыг анх удаа хуульчилсан байна.
- 1946 он- Токиогийн Олон улсын цэргийн шүүх Япон улсын 28 гол удирдагчийг шүүж, “дайны гэмт хэрэг”, “хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг”-ээр шийтгэсэн байна.
- 1993 он- Югославын Олон улсын эрүүгийн шүүх (ICTY) нь Босни, Херцеговин, Косовогийн дайны үеийн гэмт хэргүүдийг шүүсэн.
- 1994 он- Руандагийн Олон улсын эрүүгийн шүүх (ICTR) “Руандагийн геноцид” буюу төрлөөр устгах гэмт хэрэг (800,000 гаруй хүн алагдсан)-ийг шүүсэн. Эдгээр шүүхүүд нь орчин үеийн олон улсын эрүүгийн эрх зүйн гол үндэс суурийг тавьсан.

5. Орчин үе:

- 1998 оны 07-р сарын 17-нд ОУЭШ-ийн Ромын Дүрэм-ийг 120 улс дэмжиж баталсан. Үүндээ 4 том гэмт хэргийг (төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг, дайны, түрэмгийллийн гэмт хэргүүд) тодорхойлсон.
- 2002 оны 07-р сарын 01-нд Олон улсын эрүүгийн шүүх (ОУЭШ/ICC) албан ёсоор байгуулагдсан буюу анхны байнгын, бие даасан ОУЭШ (Нидерланд, Гааг хотноо байрладаг) юм. Яг одоогийн цаг үе нь олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн оргил үе бөгөөд өмнөх бүх цаг үеийн тусгай шүүхүүдийн туршлагад тулгуурласан байнгын механизм бүрдэж чадсан.

Дэлхийн II дайны харгислалын дараа олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжил шинэ шатанд гарч, 1945 онд Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) байгуулагдсан өдрөөс ОУЭШ-тэй холбоотой асуудлуудыг хэлэлцэж эхэлсэн. Тэр дундаа Нюрнбергийн болон Токиогийн тусгай шүүхүүдийн туршлага дээр тулгуурлан байнгын механизмын шаардлага бий гэдгийг улам бататгасан. Тус хөгжлийн оргил цэг нь 1998 оны Ромын Дүрэм батлагдсан, 2002 онд ОУЭШ байгуулагдсан явдал юм.

Олон улсын эрүүгийн эрх зүй нь олон улсын эрх зүйн салбарын нэг хэсэг болохын хувьд XIX зууны сүүл үеэс бүрэлдэн тогтсон харьцангуй залуу салбар юм. Гэвч түүний зарим үндсэн институт, Голчлон гэмт хэрэгтнийг шилжүүлэх журам нь олон улсын эрүүгийн эрх зүйн анхны практик илрэлүүдийн нэг бөгөөд энэ салбарын үүсэл, хөгжлийн суурь болж өгсөн гэж үзэх үндэс бий (Д.Мөнхтуяа, 2000).

1.3.1.Нюрнбергийн Олон Улсын Шүүх (1945-1946)

Орчин үеийн олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн эхлэл нь Нюрнбергийн олон улсын цэргийн шүүхтэй салшгүй холбоотой юм. Дэлхийн II дайны дараа холбоотон гүрнүүд болох АНУ, Их Британи, Франц болон Зөвлөлт Холбоот Улс 1945 оны 08 дугаар сарын 08-ны өдөр Лондонгийн хэлэлцээр байгуулж, түүнд хавсаргасан Нюрнбергийн дүрмээр Олон улсын цэргийн шүүх (International Military Tribunal)-ийг байгуулсан байна. Энэхүү дүрэм нь олон улсын эрүүгийн шүүхийн байгууллагын бүтэц, харьяалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тодорхойлсон анхны олон улсын эрх зүйн баримт бичигт тооцогддог (London Agreement, 1945).

Нюрнбергийн шүүхийн үндсэн зорилго нь Европын орнуудын дайны гол гэмт хэрэгтнүүдийг мөрдөн шалгаж, олон улсын эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд оршиж байв. Шүүх ажиллагаа 1945 оны 11 дүгээр сарын 20-ноос 1946 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл Германы Нюрнберг хотод үргэлжилсэн бөгөөд нийт 24 өндөр албан тушаалтанд яллах дүгнэлт үйлдсэн байна. Тэдгээрийн дотор Германн Геринг, Рудольф Гесс, Иоахим фон Риббентроп зэрэг Нацист Германы төр, цэрэг, улс төрийн удирдлагын төлөөлөгчид багтаж байв. Шүүхийн эцсийн шийдвэрээр 19 шүүгдэгчид ял оногдуулж, үүнээс 12 хүнд цаазаар авах ял оноосон байна (History.com Editors, 2010).

Нюрнбергийн дүрэм нь олон улсын гэмт хэргийг анх удаа системтэйгээр ангилан тодорхойлсон бөгөөд дараах гурван үндсэн төрлийн гэмт хэргийг шүүхийн харьяалалд хамруулсан. Үүнд:

- энх тайвны эсрэг гэмт хэрэг буюу түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, эхлүүлэх болон явуулахтай холбоотой үйлдэл;
- дайны гэмт хэрэг буюу дайны хууль, ёс заншил, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл;
- хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг буюу энгийн иргэдийн эсрэг аллага, устгал, боолчлол, албадан шилжүүлэлт, хавчлага болон бусад хүмүүнлэг бус үйлдэл юм. Эдгээр ангилал нь хожим олон улсын эрүүгийн эрх зүйн суурь ойлголт болж хөгжсөн бөгөөд Ромын дүрэмд тусгагдсан геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, түрэмгийллийн гэмт хэргийн эрх зүйн үндэс болсон байна.

Нюрнбергийн шүүхийн хамгийн том ололт нь олон улсын гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хувь хүний эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчмыг бодитойгоор хэрэгжүүлсэн явдал юм. Үүнээс

өмнө олон улсын эрх зүй нь голчлон улс хоорондын харилцааг зохицуулдаг байсан бөгөөд хувь хүн олон улсын эрх зүйн шууд субъект гэж үзэгддэггүй байв. Харин Нюрнбергийн шүүхээс “олон улсын эрх зүйг хийсвэр байгууллага бус, хүн өөрөө зөрчдөг бөгөөд иймээс хувь хүн хариуцлага хүлээх ёстой” гэсэн үзэл баримтлалыг тогтоосон нь олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжилд томоохон өөрчлөлт авчирсан.

Түүнчлэн Нюрнбергийн шүүх нь төрийн өндөр албан тушаалтан, төрийн тэргүүн байх нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэсэн зарчмыг бий болгосон. Өөрөөр хэлбэл, төрийн бүрэн эрхт байдал болон албан тушаалын халдашгүй байдлыг олон улсын ноцтой гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд хэрэглэхгүй байж болохыг анх удаа практикт харуулсан байна. Энэхүү зарчим нь өнөөгийн ОУЭШ-ийн Ромын дүрмийн 27 дугаар зүйлд тусгагдсан бөгөөд төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн болон бусад өндөр албан тушаалтнууд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөхгүй байх эрх зүйн үндэс болж байна.

Нюрнбергийн шүүхээс мөн “дээд шатны удирдлагын тушаалыг биелүүлсэн” гэх үндэслэл нь эрүүгийн хариуцлагаас бүрэн чөлөөлөхгүй гэсэн зарчмыг тогтоосон. Энэ нь олон улсын эрүүгийн эрх зүйн хүрээнд хувь хүний ухамсарт үйл ажиллагаа, ёс суртахууны сонголт чухал ач холбогдолтой болохыг хүлээн зөвшөөрсөн хэрэг байв. Дараа нь энэхүү зарчим Нюрнбергийн зарчмууд болон Ромын дүрмийн зохицуулалтад тусгалаа олсон байдаг.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 1946 онд Нюрнбергийн дүрэм болон шүүхийн шийдвэрээр хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрх зүйн зарчмуудыг баталгаажуулж, улмаар НҮБ-ын Олон улсын эрх зүйн хороо 1950 онд Нюрнбергийн зарчмуудыг томъёолсон байна. Эдгээр зарчим нь олон улсын эрүүгийн хариуцлага, шударга шүүхээр шүүлгэх эрх, олон улсын гэмт хэргийн ангилал зэрэг асуудлын эрх зүйн суурийг бүрдүүлжээ. Улмаар хуучин Югославын олон улсын эрүүгийн трибунал² (ICTY), Руандагийн олон улсын эрүүгийн трибунал (ICTR), цаашлаад 1998 оны Ромын дүрэм болон Олон улсын эрүүгийн шүүх байгуулагдах онол, эрх зүйн үндэс нь Нюрнбергийн шүүхийн туршлага дээр тулгуурлан хөгжсөн гэж үздэг (НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 95(I) тогтоол, 1946; НҮБ-ын Олон улсын эрх зүйн хороо, 1950).

Иймээс Нюрнбергийн олон улсын цэргийн шүүх нь олон улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд анхны бодит шүүх ажиллагаа төдийгүй хувь хүний олон улсын эрүүгийн хариуцлага, төрийн албан тушаалтны халдашгүй байдлыг хязгаарлах зарчим, ял шийтгэлгүй үлдэхийн

² Трибунал- тусгайлан байгуулсан шүүх байгууллага

эсрэг олон улсын хамтын ажиллагааны үзэл санааг төлөвшүүлсэн түүхэн ач холбогдол бүхий институт хэмээн дүгнэж болно.

1.3.2 Нюрнбергийн дараах олон улсын эрүүгийн шүүхүүдийн хөгжил

Нюрнберг болон Токиогийн шүүхүүдийн үйл ажиллагаа дууссаны дараа олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжил тодорхой хугацаанд саарсан боловч ХХ зууны төгсгөлд болсон зэвсэгт мөргөлдөөн, геноцидын гэмт хэргүүд олон улсын хамтын нийгэмлэгийг дахин идэвхтэй арга хэмжээ авахад хүргэсэн. Ийнхүү НҮБ болон тухайн улсын Засгийн газрын хамтын ажиллагааны хүрээнд түр (ad hoc) болон холимог (hybrid) бүтэцтэй олон улсын эрүүгийн шүүхүүд байгуулагдсан бөгөөд эдгээр нь орчин үеийн Олон улсын эрүүгийн шүүх байгуулагдах эрх зүйн үндэс суурийг бүрдүүлсэн гэж үздэг (Cassese, 2008).

1. Токиогийн олон улсын цэргийн шүүх

Дэлхийн II дайны дараа Японы улс төр, цэргийн удирдлагыг шүүх зорилгоор Алс Дорнодын олон улсын цэргийн шүүх (International Military Tribunal for the Far East) байгуулагдсан. Тус шүүх 1946-1948 оны хооронд үйл ажиллагаа явуулж, Японы удирдагчдыг түрэмгий дайн төлөвлөсөн, дайны гэмт хэрэг үйлдсэн, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт оролцсон үндэслэлээр ялласан байна. Энэхүү шүүх нь Нюрнбергийн шүүхийн зарчмуудыг Азийн бүс нутагт хэрэгжүүлсэн анхны тохиолдол болсон байна (Totani, 2008).

2. Хуучин Югославын олон улсын эрүүгийн трибунал (ICTY)

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл 1993 онд хуучин Югославын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн ноцтой гэмт хэргүүдийг шалгах зорилгоор ICTY-г байгуулсан. Тус трибунал нь геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон Женевийн конвенцын ноцтой зөрчлийг шүүн шийдвэрлэсэн анхны НҮБ-ын эрүүгийн шүүх болсон юм.

ICTY нь 161 хүнийг яллагдагчаар татаж, олон улсын эрүүгийн эрх зүйн практикт томоохон хувь нэмэр оруулсан. Ялангуяа бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэргийн бүрэлдэхүүнд хамруулан тайлбарласан нь олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн чухал алхам болсон (Cassese, 2008).

3. Руандагийн олон улсын эрүүгийн трибунал (ICTR)

1994 онд Руанда улсад болсон геноцидын үеэр ойролцоогоор 800,000 гаруй тутси үндэстэн³ болон геноцидыг эсэргүүцсэн хуту үндэстнүүд⁴ амь үрэгдсэн байдаг. Үүний дараа НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс ICTR-ийг байгуулж, геноцид болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн.

ICTR-ийн хамгийн том эрх зүйн ач холбогдол нь 1948 оны Геноцидын конвенцыг шүүхийн практикт анх удаа иж бүрэн хэрэглэсэн явдал юм. Мөн бэлгийн хүчирхийллийг геноцид үйлдэх хэрэгсэл байж болохыг хүлээн зөвшөөрсөн анхны олон улсын шүүх болсон (Schabas, 2017).

4. Сьерра-Леоны тусгай шүүх (SCSL)

Сьерра-Леоны иргэний дайны үеэр үйлдэгдсэн олон улсын гэмт хэргүүдийг шалгах зорилгоор 2002 онд НҮБ болон Сьерра-Леоны Засгийн газрын хамтарсан гэрээгээр байгуулагдсан. Энэхүү шүүх нь хүүхэд цэрэг ашиглах, энгийн иргэдийн эсрэг системтэй хүчирхийлэл үйлдэх зэрэг хэргүүдийг шийдвэрлэсэн.

Тус шүүхийн хамгийн онцлох шийдвэр нь Либерийн Ерөнхийлөгч асан Чарльз Тейлорт ял оноосон явдал бөгөөд Нюрнбергийн шүүхээс хойш төрийн тэргүүн байсан этгээдийг олон улсын эрүүгийн шүүхээр ялласан цөөн тохиолдлын нэг болсон (SCSL Case Law Report, 2014).

5. Камбожийн шүүх дэх Онцгой танхимууд (ECCC)

Камбож улсын шүүхийн тогтолцооны хүрээнд НҮБ-ын оролцоотой байгуулагдсан энэхүү холимог бүтэцтэй шүүх нь Улаан Кхмерийн дэглэмийн⁵ үед үйлдэгдсэн геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон бусад ноцтой гэмт хэргийг шүүн шийдвэрлэсэн.

ECCC нь олон улсын болон үндэсний шүүгчдийн хамтарсан бүрэлдэхүүнтэй байсан нь олон улсын эрүүгийн шүүхийн үйл ажиллагааг үндэсний эрх зүйн тогтолцоотой уялдуулах шинэ загвар болсон гэж үздэг (Hafetz, 2018).

Дээрх түр болон холимог бүтэцтэй шүүхүүд нь олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн чухал үе шат болсон бөгөөд Нюрнбергийн зарчмуудыг орчин үеийн нөхцөлд хэрэгжүүлж, олон улсын гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх практикийг хөгжүүлсэн. Түүнчлэн эдгээр

³ Тутси- Руанда, Бурунди, Конго зэрэг Төв Африкийн улсуудад амьдардаг томоохон үндэстэн. Руандагийн нийт хүн амын 14-15%-ийг эзэлдэг.

⁴ Хуту- Руанда, Бурундид амьдардаг хамгийн том үндэстэн. Руандагийн нийт хүн амын 84-85%-ийг эзэлдэг.

⁵ Улаан Кхмерийн дэглэм- 1975-1979 оны хооронд Камбож улсыг (тухайн үеийн нэрээр Ардчилсан Камбож) дарангуйлж, хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн аймшигт, сохор туйлшрал бүхий геноцидуудын нэгийг үйлдсэн коммунист дэглэм.

шүүхүүдийн үйл ажиллагаанаас үүдэн түр хугацааны бус, байнгын ажиллагаатай ОУЭШ байгуулах шаардлага улам тодорхой болсон бөгөөд энэхүү хэрэгцээ нь 1998 оны Ромын дүрэм батлагдаж, 2002 онд Олон улсын эрүүгийн шүүх байгуулагдах эрх зүйн үндэс болсон байна (Schabas, 2020).

1.3.3 Олон улсын эрүүгийн шүүхийн үүсэл, зорилго

Олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн түүх нь олон улсын хамтын нийгэмлэг хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд хариуцлага хүлээлгэх байнгын механизмыг бий болгох эрмэлзэлтэй нягт холбоотой байдаг. Нюрнбергийн болон Токиогийн олон улсын цэргийн шүүхүүд, түүнчлэн хуучин Югославын олон улсын эрүүгийн трибунал (ICTY), Руандагийн олон улсын эрүүгийн трибунал (ICTR) зэрэг түр шинжтэй шүүхүүд нь олон улсын эрүүгийн хариуцлагын зарчмыг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан боловч зөвхөн тодорхой мөргөлдөөн, тодорхой цаг хугацааны хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байв. Иймээс олон улсын хэмжээнд хамгийн хүнд гэмт хэргүүдийг тасралтгүй мөрдөн шалгаж, шүүн шийдвэрлэх байнгын шүүх байгуулах шаардлага улам бүр нэмэгдсэн (Cassese, 2008).

Байнгын олон улсын эрүүгийн шүүх байгуулах санаачилга Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүрээнд олон арван жилийн турш хэлэлцэгдсэн боловч Хүйтэн дайны үеийн улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан бодит үр дүнд хүрч чадаагүй. Харин 1989 онд Тринидад ба Тобаго улс олон улсын хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор байнгын эрүүгийн шүүх байгуулах саналыг НҮБ-д гаргаснаар энэхүү асуудал дахин идэвхтэй яригдаж эхэлсэн. Улмаар 1990-ээд онд хуучин Югослав болон Руандад болсон ноцтой зэвсэгт мөргөлдөөн, геноцидын гэмт хэргүүд нь байнгын олон улсын эрүүгийн шүүх байгуулах шаардлагыг улам тодорхой болгосон (Dempsey, 1998).

Үүний үр дүнд НҮБ-ын Олон улсын эрх зүйн хороо болон Бэлтгэл хорооноос олон жилийн турш боловсруулсан төслийн үндсэн дээр 1998 оны 6 дугаар сарын 15-наас 7 дугаар сарын 17-ны хооронд Италийн Ром хотноо болсон Дипломат бага хурлаар Олон улсын эрүүгийн шүүх байгуулах тухай Ромын дүрмийг баталсан байна. Уг дүрэмд оролцсон улсуудын 120 нь дэмжиж, 7 улс эсэргүүцэн, 21 улс түдгэлзсэн санал өгсөнөөр Ромын дүрэм батлагдсан бөгөөд энэ нь олон улсын эрүүгийн эрх зүйн түүхэн томоохон ололт болсон гэж үздэг (Schabas, 2020).

Ромын дүрэмд заасан нөхцөл хангагдаж, шаардлагатай тооны улс соёрхон баталсны дараа Олон улсын эрүүгийн шүүх 2002 оны 7 дугаар сарын 1-ний өдөр албан ёсоор үйл

ажиллагаагаа эхлүүлсэн. Шүүхийн төв байр нь Нидерландын Хаант Улсын Гааг хотод байрладаг бөгөөд дэлхийн анхны байнгын ажиллагаатай олон улсын эрүүгийн шүүх болсон юм.

ОУЭШ-ийн үндсэн зорилго нь олон улсын хамтын нийгэмлэгийн ашиг сонирхолд хамгийн ноцтой аюул учруулдаг гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд оршино. Ромын дүрмийн 5 дугаар зүйлд зааснаар тус шүүх нь дараах дөрвөн төрлийн гэмт хэрэгт харьяалал хэрэгжүүлдэг. Үүнд:

- Төрлөөр устгах гэмт хэрэг (Genocide);
- Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг (Crimes against Humanity);
- Дайны гэмт хэрэг (War Crimes);
- Түрэмгийллийн гэмт хэрэг (Crime of Aggression).

Олон улсын эрүүгийн шүүхийн онцлог шинж нь нэмэлт буюу complementarity зарчимд оршдог. Энэхүү зарчмын дагуу “шүүх нь үндэсний шүүхийн тогтолцоог орлохгүй бөгөөд зөвхөн тухайн улс өөрөө мөрдөн шалгах, яллах ажиллагаа явуулах боломжгүй, эсхүл хүсэлгүй байгаа тохиолдолд” харьяаллаа хэрэгжүүлдэг. Иймээс ОУЭШ нь үндэсний бүрэн эрхт байдлыг хүндэтгэхийн зэрэгцээ олон улсын гэмт хэрэг ял шийтгэлгүй үлдэхээс урьдчилан сэргийлэх тэнцвэртэй механизмыг бүрдүүлдэг (Rome Statute, Article 17).

Иймээс Олон улсын эрүүгийн шүүх нь Нюрнбергийн шүүхээс эхлэлтэй олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн үр дүн бөгөөд олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хамгийн ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг ял шийтгэлгүй үлдээхгүй байх, хохирогчдын эрхийг хамгаалах, олон улсын энх тайван ба аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилго бүхий байнгын шүүхийн байгууллага мөн гэж дүгнэж болно.

1.4. Олон улсын эрүүгийн шүүхийн бүтэц, зохион байгуулалт

Олон улсын эрүүгийн шүүх нь Ромын дүрмийн 34 дүгээр зүйлд заасны дагуу үндсэн дөрвөн байгууллагаас бүрддэг. Үүнд Ерөнхийлөгчийн газар, Шүүхийн танхимууд, Прокурорын газар болон Бүртгэлийн газар багтана. Эдгээр байгууллагууд нь харилцан уялдаа холбоотой ажиллах замаар шүүхийн бие даасан, хараат бус үйл ажиллагааг хангадаг (Rome Statute, 1998).

Хүснэгт 1. ОУЭШ-ийн байгууллагын бүтэц

Байгууллага	Үндсэн чиг үүрэг
-------------	------------------

Ерөнхийлөгчийн газар	Шүүхийн удирдлага, төлөөлөл, гадаад харилцаа
Урьдчилсан шатны танхим	Мөрдөн шалгах ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих
Шүүх хуралдааны танхим	Хэргийг хэлэлцэж шийдвэрлэх
Давж заалдах шатны танхим	Давж заалдах шатны гомдлыг шийдвэрлэх
Прокурорын газар	Мөрдөн шалгах, яллах ажиллагаа
Бүртгэлийн газар	Захиргаа, орчуулга, гэрч, хохирогчийн хамгаалалт

Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэл

Шүүгчид- Олон улсын эрүүгийн шүүх нь 18 шүүгчээс бүрддэг бөгөөд тэдгээрийг Оролцогч улсуудын Ассамблей сонгодог. Шүүгчдийг сонгохдоо газарзүйн тэнцвэрт байдал, дэлхийн эрх зүйн үндсэн тогтолцоодын төлөөлөл, мөн жендерийн тэнцвэрийг хангах зарчмыг баримталдаг. Шүүгчид есөн жилийн хугацаатай сонгогддог бөгөөд дахин сонгогдох боломжгүй байдаг (Rome Statute, Art. 36).

Прокурорын газар- Прокурорын газар нь ОУЭШ-ийн бие даасан байгууллага бөгөөд мөрдөн шалгах ажиллагааг удирдан явуулж, яллах ажиллагааг хэрэгжүүлдэг. Прокурор нь аль нэг улсын заавар, нөлөөллөөс ангид байх ёстой бөгөөд зөвхөн Ромын дүрэм болон олон улсын эрх зүйн зарчмыг удирдлага болгодог.

2021 оноос хойш ОУЭШ-ийн Ерөнхий прокуророор Их Британийн хуульч Карим А.А. Хан ажиллаж байна. Тэрээр Афганистан, Украин, Судан, Палестин зэрэг олон улсын анхаарал татсан хэргүүдийн мөрдөн шалгах ажиллагааг удирдан ажиллаж байгаа юм (ICC Annual Report, 2025).

Бүртгэлийн газар- Бүртгэлийн газар нь шүүхийн захиргаа, санхүү, орчуулга, архив, мэдээллийн технологи, гэрч болон хохирогчийн хамгаалалтын асуудлыг хариуцдаг. Ялангуяа хохирогчдын оролцоог хангах, гэрчийн аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэг нь ОУЭШ-ийн үйл ажиллагааны онцлогийг илэрхийлдэг.

ОУЭШ-ийн төв байр- Олон улсын эрүүгийн шүүхийн төв байр нь Нидерландын Хаант Улсын Гааг хотод байрладаг. Түүнчлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй улс орнуудад төлөөлөгчийн болон хээрийн оффис ажиллуулдаг бөгөөд энэ нь нотлох баримт цуглуулах, хохирогч, гэрчтэй ажиллах ажиллагааг хөнгөвчилдөг.

Ийнхүү ОУЭШ-ийн бүтэц, зохион байгуулалт нь олон улсын гэмт хэрэгтэй холбоотой хэргийг хараат бусаар, шударгаар шийдвэрлэхэд чиглэсэн институцийн тогтолцоог бүрдүүлдэг

бөгөөд энэ нь үндэсний шүүхийн тогтолцоог нөхөн дэмжих зорилготой үйл ажиллагаа явуулдгаараа онцлог юм.

1.5 Олон улсын эрүүгийн шүүхийн харьяалал

Олон улсын эрүүгийн шүүх (ОУЭШ) нь Ромын дүрмийн дагуу олон улсын хамтын нийгэмлэгийн ашиг сонирхолд хамгийн ноцтой аюул учруулдаг гэмт хэргүүдийг хянан шийдвэрлэх эрх бүхий байнгын олон улсын эрүүгийн шүүх юм. Шүүхийн харьяалал нь Ромын дүрмийн 5-17 дугаар зүйлүүдээр зохицуулагддаг бөгөөд зөвхөн тодорхой төрлийн гэмт хэрэг, тодорхой нөхцөлд хэрэгждэг онцлогтой (Rome Statute, 1998).

ОУЭШ нь дээрх дөрвөн төрлийн гэмт хэргээс бусад эрүүгийн хэргийг шийдвэрлэх эрхгүй. Энэ нь тус шүүхийг ердийн эрүүгийн шүүхээс ялгаатай болгож байгаа бөгөөд зөвхөн олон улсын хэмжээнд хамгийн ноцтой гэж тооцогдох гэмт хэргүүдэд төвлөрдөг.

Нутаг дэвсгэрийн болон иргэний харьяалал

Ромын дүрмийн 12 дугаар зүйлд зааснаар шүүх дараах нөхцөлд харьяаллаа хэрэгжүүлж болно:

- Гэмт хэрэг ОУЭШ-ийн гишүүн улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн;
- Гэмт хэрэг ОУЭШ-ийн гишүүн улсын иргэний үйлдсэн;
- Гишүүн бус улс харьяаллыг түр хугацаагаар хүлээн зөвшөөрсөн;
- НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс хэргийг ОУЭШ-д шилжүүлсэн.

Хүснэгт 2. ОУЭШ-ийн харьяалал үүсэх үндэслэл

Үндэслэл	Тайлбар
Нутаг дэвсгэрийн харьяалал	Гэмт хэрэг гишүүн улсын нутагт үйлдэгдсэн
Иргэний харьяалал	Гэмт хэрэг гишүүн улсын иргэнээр үйлдэгдсэн
Ad hoc зөвшөөрөл	Гишүүн бус улс харьяаллыг зөвшөөрсөн
НҮБ-ын АЗ-ийн шилжүүлэг	Аюулгүйн Зөвлөлөөс хэрэг шилжүүлсэн

Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэл

2026 оны байдлаар Ромын дүрэмд 125 улс нэгдэн орсон байна. Гэсэн хэдий ч АНУ, ОХУ, БНХАУ, Энэтхэг, Израиль зэрэг томоохон улсууд Ромын дүрмийн оролцогч бус хэвээр байгаа бөгөөд дүрмээс үүдэлтэй гэрээний үүрэг хүлээдэггүй. Гэсэн хэдий ч НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэр эсвэл тусгай мэдэгдлээр дамжуулан тэдгээр улсын нутаг дэвсгэртэй холбоотой нөхцөл байдал ОУЭШ-ийн харьяалалд шилжиж болох боломжтой байдаг (Schabas, 2020).

Цаг хугацаагаар

ОУЭШ нь зөвхөн 2002 оны 07 дугаар сарын 01-нээс хойш үйлдэгдсэн гэмт хэрэгт харьяаллаа хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл Нюрнбергийн шүүхийн нэгэн адил өнгөрсөн хугацаанд үйлдэгдсэн гэмт хэрэгт буцаан хэрэглэгдэхгүй бөгөөд энэ нь эрүүгийн эрх зүйн хууль буцаан хэрэглэхгүй байх зарчимтай нийцдэг (Rome Statute, Article 11).

Нөхөх зарчим (Complementarity Principle)

ОУЭШ-ийн харьяаллын нэг онцлог шинж нь нөхөх зарчим юм. Энэхүү зарчмын дагуу үндэсний шүүх нь олон улсын шинжтэй гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүн таслах үндсэн үүргийг хүлээдэг бөгөөд ОУЭШ нь зөвхөн тухайн улс үүргээ хэрэгжүүлэх боломжгүй эсвэл хэрэгжүүлэх хүсэлгүй болсон үед оролцдог.

Ромын дүрмийн 17 дугаар зүйлд зааснаар дараах нөхцөлд ОУЭШ хэрэг хянан шийдвэрлэх боломжтой:

- Тухайн улс мөрдөн шалгах ажиллагааг зориуд явуулахгүй байгаа;
- Гэм буруутай этгээдийг хамгаалах зорилгоор хэрэгсэхгүй болгож байгаа;
- Шүүхийн тогтолцоо нуран унаж, бодитой ажиллагаа явуулах боломжгүй болсон;
- Хэрэг шийдвэрлэх чадваргүй болсон.

Хүснэгт 3. Нөхөх зарчмын хэрэгжилт

Нөхцөл байдал	Хэргийг шийдвэрлэх байгууллага
Үндэсний шүүх хэвийн ажиллаж байгаа	Үндэсний шүүх
Үндэсний шүүх мөрдөн шалгах хүсэлгүй	ОУЭШ
Үндэсний шүүх ажиллагаа явуулах боломжгүй	ОУЭШ
Улсын эрх зүйн тогтолцоо нуран унасан	ОУЭШ

Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэл

Иймээс ОУЭШ нь дэлхийн бүх эрүүгийн хэргийг шийдвэрлэдэг байгууллага бус бөгөөд зөвхөн олон улсын хамгийн ноцтой гэмт хэрэгт хязгаарлагдмал харьяалал хэрэгжүүлдэг. Түүнчлэн үндэсний шүүхийн тогтолцоог орлох бус, харин түүнийг нөхөн дэмжих замаар олон улсын эрүүгийн шударга ёсыг хангах зорилготой байгууллага юм.

1.6. ОУЭШ-ийн шүүн шийдвэрлэх гэмт хэргүүд

ОУЭШ-ийн эрх хэмжээ нь олон улсын хамтын нийгэмлэгийн ашиг сонирхолд хамгийн ноцтой аюул учруулдаг гэмт хэргүүдээр хязгаарлагддаг. Ромын дүрмийн 5 дугаар зүйлд зааснаар тус шүүх нь төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт

хэрэг болон түрэмгийллийн гэмт хэрэг гэсэн дөрвөн төрлийн гэмт хэрэгт харьяаллаа хэрэгжүүлдэг. Эдгээр гэмт хэрэг нь зөвхөн тухайн улсын дотоод асуудалд хамаарахгүй бөгөөд олон улсын энх тайван, аюулгүй байдал, хүний эрхийн нийтлэг үнэт зүйлд ноцтой заналхийлэл учруулдаг онцлогтой (Rome Statute, 1998).

1.6.1 Төрлөөр устгах гэмт хэрэг

Төрлөөр устгах буюу геноцидын гэмт хэрэг нь олон улсын эрүүгийн эрх зүй дэх хамгийн хүнд гэмт хэрэгт тооцогддог. “Геноцид” гэх нэр томъёог Польш гаралтай хуульч Рафаэль Лемкин 1944 онд анх хэрэглэсэн бөгөөд Дэлхийн II дайны үеийн еврей үндэстний эсрэг үйлдэгдсэн харгислалын дараа олон улсын эрх зүйд тусгах шаардлага бий болсон юм. Улмаар НҮБ 1948 онд “Геноцидын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шийтгэх тухай конвенц”-ийг баталж, геноцидыг олон улсын гэмт хэрэг хэмээн албан ёсоор хүлээн зөвшөөрсөн (United Nations, 1948).

Ромын дүрмийн 6 дугаар зүйлд зааснаар үндэсний, угсаатны, арьс өнгөний эсвэл шашны бүлгийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн устгах тусгай зорилгоор үйлдсэн дараах үйлдлийг төрлөөр устгах гэмт хэрэгт тооцдог. Үүнд тухайн бүлгийн гишүүдийг алах, ноцтой бие махбодийн болон сэтгэл санааны хохирол учруулах, бүлгийг устгахад хүргэх амьдралын нөхцөл бүрдүүлэх, төрөлтийг зогсоох арга хэмжээ авах, хүүхдийг хүчээр өөр бүлэгт шилжүүлэх зэрэг үйлдэл багтана.

Геноцидын гэмт хэргийн хамгийн чухал шинж нь тусгай санаа зорилго (*dolus specialis*) байдаг. Өөрөөр хэлбэл зөвхөн олон хүн хөнөөсөн байх нь хангалтгүй бөгөөд тодорхой бүлгийг устгах зорилго нь нотлогдох шаардлагатай. Энэ нь геноцидыг бусад олон улсын гэмт хэргээс ялгадаг гол онцлог юм (Schabas, 2009).

Олон улсын шүүхийн практикт Руандагийн геноцид (1994 он), Сребреницийн аллага (1995 он) зэрэг хэргүүдийг геноцидын гэмт хэрэг гэж хүлээн зөвшөөрсөн нь энэхүү ойлголтыг бодитой хэрэгжүүлсэн чухал жишээ болсон.

1.6.2 Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг

Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг нь энгийн иргэдийн эсрэг өргөн хүрээтэй эсвэл системтэй халдлагын хүрээнд үйлдэгддэгээрээ онцлогтой. Энэхүү ойлголт анх Нюрнбергийн дүрэмд тусгагдсан бөгөөд хожим олон улсын эрүүгийн эрх зүйн бие даасан институт болон хөгжсөн юм.

Ромын дүрмийн 7 дугаар зүйлд зааснаар аллага, устгал, боолчлол, албадан шилжүүлэлт, хууль бусаар хорих, эрүү шүүх, бэлгийн хүчирхийлэл, улс төр, үндэс угсаа, шашин шүтлэгийн үндэслэлээр хавчлага явуулах зэрэг үйлдлийг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцдог.

Энэхүү гэмт хэрэг нь дайны гэмт хэргээс ялгаатай нь заавал зэвсэгт мөргөлдөөний үед үйлдэгдсэн байх шаардлагагүй. Энхийн цагт ч төрөөс эсвэл зохион байгуулалттай бүлгээс иргэдийн эсрэг системтэйгээр үйлдсэн халдлага байж болно. Ийм учраас хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг нь хүний эрхийн ноцтой зөрчилтэй хамгийн ойр холбоотой олон улсын гэмт хэрэгт тооцогддог (Cassese, 2008).

Өмнөд Африкийн апартейдын дэглэм⁶, Камбож дахь Улаан Кхмерийн харгислал, Мьянмар дахь рохинжа үндэстний эсрэг үйл ажиллагаа⁷ зэрэг нь хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн шинжийг агуулсан гэж олон улсын түвшинд үздэг.

1.6.3 Дайны гэмт хэрэг

Дайны гэмт хэрэг нь зэвсэгт мөргөлдөөний үед олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн үйлдлийг хэлнэ. Энэхүү гэмт хэргийн эрх зүйн үндэс нь 1949 оны Женевийн дөрвөн конвенц болон тэдгээрийн нэмэлт протоколуудад агуулагддаг.

Ромын дүрмийн 8 дугаар зүйлд дайны гэмт хэргийн олон хэлбэрийг тодорхойлсон бөгөөд үүнд энгийн иргэдийг санаатайгаар онилон халдах, эрүүдэн шүүх, барьцаалах, хоригдолтой хүнлэг бусаар харьцах, хүүхдийг цэрэгт татан оролцуулах, хүмүүнлэгийн байгууллагын ажилтнуудад халдах зэрэг үйлдэл багтдаг.

Дайны гэмт хэрэг нь хүн төрөлхтний эсрэг гэмт хэргээс ялгаатай нь заавал зэвсэгт мөргөлдөөний хүрээнд үйлдэгдсэн байх шаардлагатай. Түүнчлэн ганц тохиолдлын үйлдэл ч дайны гэмт хэрэгт тооцогдож болох бөгөөд өргөн хүрээтэй эсвэл системтэй байх шаардлагагүй байдаг (Henckaerts & Doswald-Beck, 2005).

Хуучин Югославын олон улсын эрүүгийн трибунал (ICTY)-ын шийдвэрүүд нь дайны гэмт хэргийн ойлголтыг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн бөгөөд бэлгийн хүчирхийллийг дайны гэмт хэрэг гэж хүлээн зөвшөөрсөн анхны шүүхийн практикийг бий болгосон.

⁶ Өмнөд Африкийн апартейдын дэглэм- 1948-1994 оны хооронд Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад (ӨАБНУ) цагаан арьст цөөнх засаглалаа тогтоож, хар арьст болон бусад өнгөт арьст олонхийг арьс өнгөөр тусгаарлан, системтэйгээр мөлжиж, дарангуйлж байсан улс төрийн албан ёсны тогтолцоо.

⁷ Мьянмар дахь рохинжа үндэстний эсрэг явуулсан үйл ажиллагаа- Олон улсын шүүх, НҮБ болон хүний эрхийн байгууллагуудаас XXI зуунд гарсан хамгийн тодорхой "Геноцид"-ийн жишээ.

1.6.4 Түрэмгийллийн гэмт хэрэг

Түрэмгийллийн гэмт хэрэг нь олон улсын энх тайван, аюулгүй байдалд хамгийн ноцтой аюул учруулдаг гэмт хэрэгт тооцогддог. Энэхүү ойлголтын үндэс нь Нюрнбергийн шүүхийн практикт тавигдсан бөгөөд тухайн үед “энх тайвны эсрэг гэмт хэрэг” гэж нэрлэгдэж байв.

Ромын дүрэм батлагдах үед түрэмгийллийн гэмт хэргийн талаар ерөнхий байдлаар тусгасан боловч нарийвчилсан тодорхойлолт байхгүй байсан. Харин 2010 онд Уганда улсын Кампала хотноо болсон Ромын дүрмийн хянан хэлэлцэх бага хурлаар түрэмгийллийн гэмт хэргийн тодорхойлолтыг баталж, 2018 оноос ОУЭШ уг гэмт хэрэгт харьяаллаа хэрэгжүүлэх боломжтой болсон.

Ромын дүрмийн 8 дугаар зүйлд зааснаар түрэмгийллийн гэмт хэрэг нь нэг улсын улс төр, цэргийн удирдлагаас нөгөө улсын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улс төрийн тусгаар тогтнолын эсрэг НҮБ-ын дүрэмд харш хүч хэрэглэх үйл ажиллагааг төлөвлөх, бэлтгэх, эхлүүлэх эсвэл хэрэгжүүлэхийг хэлнэ.

Түрэмгийллийн гэмт хэрэг нь бусад гурван гэмт хэргээс ялгаатай нь зөвхөн төрийн удирдах түвшний албан тушаалтанд хамаардаг бөгөөд жирийн цэрэг, иргэдэд хамаарахгүй онцлогтой байдаг (Kress & Barriga, 2017).

Дүгнэлт

Ийнхүү ОУЭШ нь төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг, дайны болон түрэмгийллийн гэмт хэрэг гэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн ашиг сонирхолд хамгийн ноцтой аюул учруулдаг дөрвөн төрлийн гэмт хэрэгт харьяаллаа хэрэгжүүлдэг. Эдгээр гэмт хэрэг нь олон улсын энх тайван, аюулгүй байдал, хүний эрхийг хамгаалах тогтолцооны цөмийг бүрдүүлдэг бөгөөд Ромын дүрэм нь тэдгээрийн бүрэлдэхүүн, эрх зүйн шинжийг нарийвчлан тодорхойлсон байдаг. ОУЭШ-ийн харьяаллын энэхүү тогтолцоо нь олон улсын хэмжээнд ял шийтгэлгүй үлдэх үзэгдлийг бууруулах, хариуцлагын соёлыг төлөвшүүлэх, олон улсын шударга ёсыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

1.7. ОУЭШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

1.7.1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчмууд

ОУЭШ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа олон улсын эрүүгийн эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн зарчмуудыг удирдлага болгодог. Эдгээр зарчим нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх ажиллагааг хууль ёсны, шударга, хүний эрхийг хүндэтгэсэн

байдлаар хэрэгжүүлэхэд чиглэдэг бөгөөд Ромын дүрмийн 20-33 дугаар зүйлүүдэд тусгагдсан байдаг (Rome Statute, 1998).

Ne bis in idem зарчим

Ne bis in idem буюу нэг гэмт хэрэгт хоёр удаа ял оногдуулахгүй байх зарчим нь эрүүгийн эрх зүйн суурь баталгаа юм. Ромын дүрмийн 20 дугаар зүйлд зааснаар нэгэнт ОУЭШ эсвэл эрх бүхий үндэсний шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт тухайн этгээдийг дахин эрүүгийн хариуцлагад татахыг хориглодог.

Гэсэн хэдий ч үндэсний шүүхийн ажиллагаа нь гэмт этгээдийг олон улсын эрүүгийн хариуцлагаас зориудаар хамгаалах зорилготой байсан, эсхүл шүүх ажиллагаа хараат бус, шударга явагдаагүй гэж үзвэл ОУЭШ тухайн хэргийг дахин авч хэлэлцэх боломжтой байдаг. Энэхүү зохицуулалт нь нөхөх зарчим (complementarity)-тай нягт холбоотой юм.

Nullum crimen sine lege зарчим

Nullum crimen sine lege буюу хуульд заагаагүй бол гэмт хэрэгт тооцохгүй байх зарчим нь эрүүгийн эрх зүйн хууль ёсны байх зарчмын үндсэн илэрхийлэл юм. Ромын дүрмийн 22 дугаар зүйлд зааснаар этгээдийн үйлдэл тухайн үедээ Ромын дүрэмд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангаж байгаагүй бол түүнийг эрүүгийн хариуцлагад татах боломжгүй.

Энэхүү зарчим нь шүүгчийн үзэмжээр хуулийг төсөөтэй хэрэглэх, өргөтгөн тайлбарлах боломжийг хязгаарлаж, эрүүгийн эрх зүйн тодорхой байдлыг хангах ач холбогдолтой байдаг (Cassese, 2008).

Nulla poena sine lege зарчим

Nulla poena sine lege буюу хуульд заагаагүй бол ял оногдуулахгүй байх зарчим нь Ромын дүрмийн 23 дугаар зүйлд тусгагдсан байдаг. Уг зарчмын дагуу ОУЭШ нь зөвхөн Ромын дүрэмд урьдчилан тогтоосон ял шийтгэлийг хэрэглэх эрхтэй бөгөөд дүрэмд заагаагүй шинэ төрлийн ял шийтгэл оногдуулах боломжгүй.

Энэ нь ял шийтгэлийн хууль ёсны байдал, урьдчилан таамаглах боломжийг хангах чухал баталгаа болдог.

Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй байх зарчим

Ромын дүрмийн 24 дүгээр зүйлд зааснаар ОУЭШ нь эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй. Өөрөөр хэлбэл 2002 оны 7 дугаар сарын 1-нээс өмнө үйлдэгдсэн үйлдэлд тус шүүх харьяаллаа хэрэгжүүлэх боломжгүй.

Гэвч хэрэв хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгдэгчийн эрх зүйн байдлыг сайжруулсан шинэ зохицуулалт батлагдсан бол тухайн этгээдэд илүү ашигтай хуулийг хэрэглэх боломжтой байдаг. Энэ нь эрүүгийн эрх зүйн хүмүүнлэг зарчмын илэрхийлэл юм.

Хувь хүний эрүүгийн хариуцлагын зарчим

ОУЭШ нь зөвхөн хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг бөгөөд улс, байгууллага, бүлэглэлд эрүүгийн ял оногдуулдаггүй. Ромын дүрмийн 25 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдсэн, хамтран оролцсон, өдөөн хатгасан, тушаал өгсөн зэрэг хэлбэрээр оролцсон хувь хүн эрүүгийн хариуцлага хүлээнэ.

Энэхүү зарчим нь Нюрнбергийн шүүхээс эхлэлтэй бөгөөд олон улсын гэмт хэрэг үйлдсэн этгээд төрийн албан тушаалтан байсан ч эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөхгүй гэсэн үзэл баримтлалын үндэс болдог.

Хөөн хэлэлцэх хугацааг үл хэрэглэх зарчим

Ромын дүрмийн 29 дүгээр зүйлд зааснаар ОУЭШ-ийн харьяалах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцдоггүй. Төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг, дайны болон түрэмгийллийн гэмт хэрэг нь хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлд халдсан онц ноцтой шинжтэй учир цаг хугацаа өнгөрсөн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх боломжгүй байдаг.

Энэ зарчим нь олон улсын эрүүгийн шударга ёсны тогтолцооны хамгийн онцлог зохицуулалтын нэг юм (Schabas, 2020).

Эрүүгийн хариуцлагыг үгүйсгэх нөхцөл

Ромын дүрмийн 31-33 дугаар зүйлүүдэд эрүүгийн хариуцлагыг үгүйсгэх болон бууруулах үндэслэлүүдийг тодорхойлсон байдаг. Үүнд сэтгэцийн эмгэг, санамсаргүй хордлого, зайлшгүй хамгаалалт, албадлага, бодит байдлын алдаа зэрэг нөхцөл хамаарна.

Гэсэн хэдий ч төрийн албан тушаалтны тушаал биелүүлсэн гэх үндэслэл нь олон улсын хүнд гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд автоматаар эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй бөгөөд энэ нь Нюрнбергийн зарчмын үргэлжлэл юм.

Ийнхүү ОУЭШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчмууд нь хүний эрхийг хамгаалах, эрүүгийн хууль ёсны байдлыг хангах, шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаажуулахад чиглэсэн бөгөөд олон улсын эрүүгийн шударга ёсны тогтолцооны суурийг бүрдүүлдэг.

1.7.2. ОУЭШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат

ОУЭШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэд хэдэн дараалсан үе шаттайгаар явагддаг бөгөөд үндэсний эрүүгийн шүүхийн процессоос ялгаатай нь олон улсын хамтын ажиллагаа, нотлох баримтын нарийн шалгалт шаарддаг.

Урьдчилсан шалгалт (Preliminary Examination)- Прокурорын газар юун түрүүнд тухайн нөхцөл байдал ОУЭШ-ийн харьяалалд хамаарах эсэхийг тогтооно. Энэ шатанд:

- Ромын дүрмийн харьяалах дөрвөн төрлийн гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх;
- Харьяаллын шаардлага хангаж байгаа эсэх;
- Нөхөх зарчим хэрэгжих боломжтой эсэх;
- Хэргийг авч хэлэлцэх нь шударга ёсны ашиг сонирхолд нийцэх эсэхийг үнэлдэг.

Мөрдөн шалгах ажиллагаа (Investigation)- Хангалттай үндэслэл тогтоогдсон тохиолдолд прокурор мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлнэ. Энэ үе шатанд:

- Гэрчээс мэдүүлэг авах;
- Баримт нотолгоо цуглуулах;
- Шинжээчийн дүгнэлт гаргуулах;
- Хохирогчийн мэдүүлэг авах;
- Гэмт хэргийн нөхцөл байдлыг тогтоох ажиллагаа хийгддэг.

Захирамж гаргах- Прокурорын хүсэлтээр Урьдчилсан шатны танхим баривчлах захирамж эсвэл шүүхэд хүрэлцэн ирэх дуудах хуудас гаргаж болно. Энэхүү ажиллагаа нь шүүгдэгчийг шүүхийн өмнө авчрах үндсэн механизм юм.

Яллах үндэслэлийг баталгаажуулах ажиллагаа- Урьдчилсан шатны танхим прокуророос гаргасан яллах үндэслэл хангалттай эсэхийг хянан үздэг. Хэрэв нотлох баримт хангалттай гэж үзвэл хэргийг шүүх хуралдааны шатанд шилжүүлнэ.

Шүүх хуралдаан- Шүүх хуралдааны шатанд прокурор, өмгөөлөгч талууд нотлох баримтаа танилцуулж, гэрчүүдийг асууж, эрх зүйн байр сууриа илэрхийлдэг. Шүүгдэгч нь:

- Өмгөөлөгч авах;

- Өөрийн эсрэг нотлох баримттай танилцах;
- Гэрч асуух;
- Өөрийн байр суурийг хамгаалах зэрэг эрх эдэлдэг.

Давж заалдах ажиллагаа- Шүүхийн шийдвэртэй санал нийлэхгүй тохиолдолд прокурор болон шүүгдэгч Давж заалдах танхимд гомдол гаргах эрхтэй. Давж заалдах шат нь шүүхийн шийдвэрийн хууль ёсны болон үндэслэлтэй байдлыг шалгадаг.

Хүснэгт 4. ОУЭШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат

Үе шат	Үндсэн агуулга
Урьдчилсан шалгалт	Харьяалал болон хүлээн зөвшөөрөгдөх байдлыг тогтоох
Мөрдөн шалгах ажиллагаа	Нотлох баримт цуглуулах
Баривчлах ажиллагаа	Захирамж гаргах, шүүхэд хүргэх
Яллах үндэслэл баталгаажуулах	Хэргийг шүүхэд шилжүүлэх эсэхийг шийдэх
Шүүх хуралдаан	Гэм бурууг тогтоох
Давж заалдах шат	Шийдвэрийг хянах
Ял эдлүүлэх	Эцсийн шийдвэрийг хэрэгжүүлэх

Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэл

1.7.3 Ял шийтгэл ба хохирол барагдуулах тогтолцоо

ОУЭШ-ийн ял шийтгэлийн тогтолцоо нь зөвхөн гэмт этгээдийг шийтгэх бус, мөн хохирогчийн эрхийг сэргээхэд чиглэдэг онцлогтой.

Хорих ял- Ромын дүрмийн 77 дугаар зүйлд зааснаар:

- 30 хүртэл жилийн хугацаатай хорих ял;
- Онцгой хүнд нөхцөлд бүх насаар нь хорих ял оногдуулж болно.

Торгох ял ба эд хөрөнгө хураах- Шүүх нь гэмт хэргийн улмаас олсон хууль бус орлого, эд хөрөнгийг хураах шийдвэр гаргаж болох бөгөөд тодорхой нөхцөлд торгох ял давхар оногдуулдаг.

Нөхөн төлбөр олгох тогтолцоо- Ромын дүрмийн 75 дугаар зүйлд зааснаар хохирогчид дараах хэлбэрээр нөхөн төлбөр олгож болно:

- Нөхөн төлбөр;
- Эд хөрөнгө буцаан олгох;

- Нөхөн сэргээх үйлчилгээ;
- Хамтын нөхөн төлбөр.

Хохирогчдод зориулсан Итгэлцлийн сан- ОУЭШ-ийн дэргэдэх Хохирогчдод зориулсан Итгэлцлийн сан (Trust Fund for Victims) нь шүүхийн практикт шинэлэг тогтолцоо юм. Энэхүү сан нь гэмт этгээдийн хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд хохирогчдод нөхөн төлбөр болон сэргээн босгох тусламж үзүүлдэг.

Хүснэгт 5. ОУЭШ-ийн ял шийтгэлийн үндсэн хэлбэрүүд

Ялын төрөл	Эрх зүйн үндэс
30 хүртэл жилийн хорих ял	Ромын дүрмийн 77(1)(a)
Бүх насаар хорих ял	Ромын дүрмийн 77(1)(b)
Торгох ял	Ромын дүрмийн 77(2)
Эд хөрөнгө хураах	Ромын дүрмийн 77(2)(b)
Нөхөн төлбөр	Ромын дүрмийн 75 дугаар зүйл

Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэл

Ийнхүү ОУЭШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь эрүүгийн эрх зүйн суурь зарчмуудыг баримтлан хэрэгждэг бөгөөд мөрдөн шалгах ажиллагаанаас эхлэн ял эдлүүлэх хүртэлх нарийн тогтолцоотой байдаг. Энэхүү тогтолцоо нь зөвхөн гэмт этгээдэд хариуцлага хүлээлгэхээс гадна хохирогчдын эрхийг хамгаалах, олон улсын шударга ёсыг хэрэгжүүлэхэд чиглэдэг.

1.8 Олон улсын эрүүгийн эрх зүйн хариуцлагын онолын үндэслэл, ач холбогдол

Олон улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоо нь хүн төрөлхтний эсрэг хамгийн ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг эрүүгийн хариуцлагад татах замаар олон улсын энх тайван, аюулгүй байдал, хүний эрхийг хамгаалахад чиглэдэг. Энэхүү тогтолцооны төвд хариуцлага (accountability), шударга ёс (justice), хууль дээдлэх зарчим (rule of law) гэсэн үндсэн үнэт зүйлс оршдог. Иймээс олон улсын эрүүгийн эрх зүйн ач холбогдол нь зөвхөн гэмт этгээдийг шийтгэхэд бус, харин олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн эрх зүйн болон ёс суртахууны үүргийг хэрэгжүүлэхэд оршино.

Урьдчилан сэргийлэх чиг үүрэг- Олон улсын эрүүгийн эрх зүйн хамгийн чухал онолын үндэслэлийн нэг нь урьдчилан сэргийлэх (deterrence) үзэл баримтлал юм. Энэхүү онолын дагуу төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг, дайны болон түрэмгийллийн гэмт хэрэг

үйлдсэн этгээдэд гарцаагүй хариуцлага хүлээлгэх нь ирээдүйд ижил төрлийн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх нөлөөтэй байдаг.

Дэлхийн II дайны дараа Нюрнбергийн шүүхээс эхлэн олон улсын эрүүгийн шүүхийн тогтолцоо нь “ял шийтгэлгүй үлдэх үзэгдэл” (impunity)-тэй тэмцэх үндсэн зорилгыг дэвшүүлсэн. Өмнө нь төрийн удирдагчид болон цэргийн командлагчид улсын бүрэн эрхт байдлын халхавчин дор хариуцлагаас зайлсхийдэг байсан бол орчин үеийн олон улсын эрүүгийн эрх зүй энэ ойлголтыг үндсээр нь өөрчилсөн юм. Өнөөдөр төрийн тэргүүн, сайд, генерал зэрэг өндөр албан тушаалтан байсан ч олон улсын хүнд гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээх боломжтой болсон нь урьдчилан сэргийлэх нөлөөллийн чухал илэрхийлэл болдог (Cassese, 2008).

Гэсэн хэдий ч судлаачид урьдчилан сэргийлэх үр нөлөө нь зөвхөн ял шийтгэлээс бус, харин шүүхийн шийдвэр заавал хэрэгждэг байх нөхцөлөөс ихээхэн шалтгаалдаг гэж үздэг. Хэрэв шүүхийн шийдвэр биелэгдэхгүй, баривчлах захирамж хэрэгжихгүй бол олон улсын эрүүгийн эрх зүйн урьдчилан сэргийлэх үр нөлөө буурах эрсдэлтэй байдаг (Stahn, 2015).

Шударга ёсыг сэргээх үүрэг- Олон улсын эрүүгийн эрх зүйн өөр нэг чухал зорилго нь шударга ёсыг сэргээх явдал юм. Геноцид, дайны гэмт хэрэг зэрэг нь зөвхөн нэг хүний эсрэг бус, бүхэл бүтэн ард түмэн, үндэстэн, нийгмийн бүлгийн эсрэг үйлдэгддэг тул тэдгээрийн үр дагавар олон арван жилээр үргэлжилдэг.

Ийм нөхцөлд шүүхийн шийдвэр нь зөвхөн гэмт этгээдийг шийтгэхээс гадна үнэн зөвийг тогтоох, түүхэн баримтыг баталгаажуулах, хохирогчдын эрхийг хүлээн зөвшөөрөх, нийгмийн эвлэрлийг дэмжих ач холбогдолтой байдаг. Руандагийн Олон улсын эрүүгийн трибунал (ICTR), Хуучин Югославын Олон улсын эрүүгийн трибунал (ICTY)-ын шийдвэрүүд нь мөргөлдөөний дараах нийгэмд үнэн зөвийг тогтоох, иргэдийн итгэлийг сэргээхэд чухал хувь нэмэр оруулсан гэж үздэг (Cryer et al., 2019).

Хохирогч төвтэй шударга ёсны үзэл баримтлал- ОУЭШ-ийн өмнөх олон улсын эрүүгийн шүүхүүд ихэвчлэн гэмт этгээдийг шийтгэхэд төвлөрдөг байсан бол ОУЭШ нь хохирогчийн эрхийг хамгаалах асуудлыг бие даасан чиглэл болгон хөгжүүлсэн. Ромын дүрмийн 68 болон 75 дугаар зүйлд хохирогчид шүүх ажиллагаанд оролцох, өөрийн байр сууриа илэрхийлэх, нөхөн төлбөр шаардах эрхийг баталгаажуулсан байдаг.

Энэхүү зохицуулалт нь сэргээн босгох шударга ёсны (restorative justice) үзэл санаатай холбоотой. Өөрөөр хэлбэл шударга ёс нь зөвхөн гэмт этгээдийг шийтгэх бус, хохирогчийн

эрхийг сэргээх, учирсан хохирлыг нөхөн барагдуулах, нийгмийн харилцааг сэргээхийг мөн хамардаг.

ОУЭШ-ийн дэргэд байгуулагдсан Хохирогчдод зориулсан Итгэлцлийн сан (Trust Fund for Victims) нь олон улсын эрүүгийн эрх зүйн практикт шинэлэг механизм гэж тооцогддог бөгөөд гэмт хэргийн улмаас хохирсон иргэдэд нөхөн сэргээх болон сэргээн босгох тусламж үзүүлдэг (Bassiouni, 2011).

Олон улсын эрх зүйн дэг журмыг хамгаалах ач холбогдол- Олон улсын эрүүгийн эрх зүй нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд суурилсан олон улсын эрх зүйн дэг журмыг хамгаалах чухал хэрэгсэл болдог. Хэрэв хамгийн ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд хариуцлагаас мултарч байвал олон улсын эрх зүйн хэм хэмжээ бодит агуулгаа алдах аюултай. Иймээс ОУЭШ болон бусад олон улсын эрүүгийн шүүхүүд нь зөвхөн хувь хүнийг шийтгэх бус, олон улсын эрх зүйн нийт тогтолцооны хууль ёсны байдлыг хамгаалах институцийн баталгаа болж байдаг. Энэхүү чиг үүрэг нь ялангуяа хүний эрхийг ноцтойгоор зөрчсөн нөхцөл байдалд онцгой ач холбогдолтой юм (Schabas, 2020).

ОУЭШ-ийн хууль ёсны байдал ба орчин үеийн сорилтууд- Хэдийгээр ОУЭШ нь олон улсын шударга ёсны хамгийн том институци боловч түүний үйл ажиллагаанд улс төрийн нөлөөлөл, баривчлах захирамжийн хэрэгжилтийн хүндрэл, томоохон гүрнүүдийн оролцоогүй байдал зэрэг сорилтууд тулгарсаар байна.

АНУ, ОХУ, БНХАУ зэрэг нөлөө бүхий улсууд Ромын дүрэмд нэгдээгүй хэвээр байгаа нь шүүхийн бүх нийтийн шинж чанарт нөлөөлдөг. ОУЭШ нь өөрийн гэсэн цагдаа, албадан хэрэгжүүлэх байгууллагагүй тул баривчлах тогтоол болон бусад шийдвэрийн хэрэгжилт нь оролцогч улсуудын хамтын ажиллагаа, улс төрийн хүсэл зоригоос шууд хамаардаг (Schabas, 2020).

Гэсэн хэдий ч эдгээр хүндрэл нь ОУЭШ-ийн оршин тогтнох ач холбогдлыг үгүйсгэх үндэслэл биш бөгөөд харин ч олон улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоог улам боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна.

Дүгнэлт:

Олон улсын эрүүгийн эрх зүйн хариуцлага нь зөвхөн гэмт этгээдэд ял шийтгэл оногдуулах механизмаар хязгаарлагдахгүй бөгөөд олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хамгаалах, шударга ёсыг сэргээх, хохирогчдын эрхийг хамгаалах, ирээдүйд ижил төрлийн гэмт

хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх зэрэг өргөн хүрээний зорилго, ач холбогдлыг агуулдаг. Энэ утгаараа ОУЭШ нь орчин үеийн олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн хамгийн том ололт бөгөөд олон улсын хамтын нийгэмлэгийн шударга ёсны нийтлэг үнэт зүйлийг хэрэгжүүлэх үндсэн механизмын нэг мөн.

II БҮЛЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2.1 Монгол Улс Ромын дүрэмд нэгдсэн нь ба үндэсний эрх зүйн тогтолцоонд үзүүлсэн нөлөө

Олон улсын эрүүгийн эрх зүйн тогтолцооны үндсэн баримт бичиг болох Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм нь 1998 оны 7 дугаар сарын 17-ны өдөр Италийн Ром хотноо болсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дипломат бага хурлаар батлагдсан бөгөөд 2002 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон байдаг (Rome Statute of the International Criminal Court, 1998). Энэхүү дүрэм нь төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон түрэмгийллийн гэмт хэрэг зэрэг хүн төрөлхтний эсрэг хамгийн ноцтой гэмт хэрэгт хувь хүний эрүүгийн хариуцлага хүлээлгэх байнгын олон улсын шүүхийн эрх зүйн үндсийг бүрдүүлсэн юм.

Монгол Улс Ромын дүрэмд 2000 оны 12 дугаар сарын 29-ний өдөр гарын үсэг зурж, Улсын Их Хурал 2002 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр соёрхон баталсан бөгөөд ингэснээр дүрмийн оролцогч тал болсон анхны улсуудын нэг болсон (Монгол Улсын Их Хурлын 2002 оны 11 дүгээр тогтоол; ICC Assembly of States Parties, 2024). Түүнчлэн Монгол Улс нь Ромын дүрмийг соёрхон баталсан 60 дахь улс болсон бөгөөд энэ нь дүрмийг хүчин төгөлдөр болоход шаардлагатай байсан босгыг хангаж өгснөөрөө олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн түүхэнд онцгой байр суурь эзэлдэг гэж үздэг (Coalition for the International Criminal Court, 2024).

Монгол Улс Ромын дүрэмд нэгдсэн нь зөвхөн олон улсын гэрээнд оролцогч болсон төдий асуудал биш бөгөөд олон улсын эрүүгийн эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, хэм хэмжээг үндэсний эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэх эрх зүйн шинэ шатанд шилжсэнийг илэрхийлсэн үйл явдал байв. Ялангуяа хүн төрөлхтний эсрэг чиглэсэн хамгийн ноцтой гэмт хэрэгтэй тэмцэх, хүний эрхийг хамгаалах, ял шийтгэлгүй үлдэх үзэгдлийг бууруулах олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох Монгол Улсын гадаад бодлогын чиг хандлагатай энэхүү шийдвэр нийцэж байв (Гадаад харилцааны яам, 2023).

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ" гэж заасан бөгөөд мөн зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улсын соёрхон баталсан олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчлэхээр хуульчилсан байдаг (Монгол Улсын

Үндсэн хууль, 1992). Энэхүү зохицуулалт нь Ромын дүрмээр хүлээсэн үүргийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлдэг.

Гэвч олон улсын гэрээг соёрхон батлах нь тухайн гэрээний бүх зохицуулалтыг автоматаар дотоодын эрх зүйн практикт бүрэн хэрэгжүүлдэг гэсэн үг биш юм. Олон улсын эрх зүйн онолд үүнийг "дотоодын хэрэгжилт" (domestic implementation) хэмээн нэрлэдэг бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргийг бодитоор хэрэгжүүлэхийн тулд материаллаг болон процессын эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн боловсронгуй болгох шаардлагатай байдаг (Schabas, 2020).

Ромын дүрмийн хувьд оролцогч улсуудын хүлээх үүрэг нь зөвхөн дүрэмд нэгдэхээр хязгаарлагдахгүй. Харин үндэсний эрүүгийн хууль тогтоомждоо олон улсын гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тусгах, ОУЭШ-тэй хамтран ажиллах эрх зүйн механизмыг бий болгох, баривчлах тогтоол болон эрх зүйн туслалцааны хүсэлтийг хэрэгжүүлэх процессын зохицуулалтыг бүрдүүлэх зэрэг өргөн хүрээний үүргийг хамардаг (Rome Statute, Parts IX–X).

Монгол Улсын хувьд Ромын дүрмийн шаардлагын дагуу тодорхой хэмжээний эрх зүйн шинэчлэл хийгдсэн. Тухайлбал 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг зэрэг олон улсын эрүүгийн эрх зүйн суурь ойлголтуудыг үндэсний хууль тогтоомжид тусгасан нь чухал ахиц болсон юм (Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015).

Гэсэн хэдий ч олон улсын судлаачдын дүгнэж байгаагаар Ромын дүрмийн хэрэгжилт нь зөвхөн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчлахаар хязгаарлагдахгүй бөгөөд ОУЭШ-тэй хамтран ажиллах тусгай процессын тогтолцоо, эрх бүхий байгууллагуудын чиг үүргийн зохицуулалт, сэжигтнийг шилжүүлэн өгөх болон нотлох баримт солилцох механизм зэрэг олон асуудлыг хамардаг (Birkett, 2019). Энэ чиглэлээр Монгол Улсад тодорхой ахиц гарсан боловч хэрэгжилтийн түвшин харьцангуй хязгаарлагдмал хэвээр байна.

Иймээс Монгол Улс Ромын дүрэмд нэгдсэн нь олон улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд идэвхтэй оролцох улс төр, эрх зүйн шийдвэр байсан хэдий ч энэхүү үүргийг үндэсний хэмжээнд бүрэн хэрэгжүүлэх асуудал өнөөдөр ч үргэлжилсэн шинжтэй хэвээр байна. Тиймээс Монгол Улсын дотоод хууль тогтоомж, институцийн тогтолцоо Ромын дүрмийн шаардлагыг ямар хэмжээнд хангаж байгаа асуудлыг дараагийн хэсэгт нарийвчлан авч үзэх шаардлагатай юм.

2.2. ОУЭШ-ийн үүргийг хэрэгжүүлэх Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

2.2.1. Монгол Улсын Үндсэн хууль дахь зохицуулалт

Олон улсын эрүүгийн шүүхийн (ОУЭШ) өмнө Монгол Улсын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс нь юуны өмнө Монгол Улсын Үндсэн хуульд тулгуурладаг. Аливаа олон улсын гэрээ, хэлэлцээр нь дотоодын эрх зүйн тогтолцоонд хэрхэн үйлчлэх, төрийн байгууллагууд олон улсын эрх зүйн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлэх асуудал нь үндсэн хуулийн зохицуулалттай салшгүй холбоотой байдаг. Иймээс Монгол Улсын ОУЭШ-тэй хамтран ажиллах эрх зүйн боломж, хязгаарлалтыг үнэлэхийн тулд Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтыг авч үзэх шаардлагатай.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт:

- “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж заасан байдаг (Монгол Улсын Үндсэн хууль, 1992).

Энэхүү зохицуулалт нь олон улсын эрх зүйн суурь зарчим болох *pacta sunt servanda* буюу “гэрээг шударгаар биелүүлэх” зарчмын үндэсний эрх зүйн илэрхийлэл юм. Улс орон олон улсын гэрээнд нэгдэн орсон тохиолдолд уг гэрээг хэрэгжүүлэх нь сайн дурын сонголт бус, харин эрх зүйн үүрэг болдог бөгөөд Монгол Улс Ромын дүрмийг соёрхон баталснаар энэхүү үүргийг хүлээсэн гэж үзнэ (Vienna Convention on the Law of Treaties, 1969, Article 26).

Мөн Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт:

- “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон батлагдсан бол дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ” хэмээн хуульчилсан байдаг.

Энэхүү зохицуулалт нь Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд олон улсын гэрээ чухал байр суурь эзэлдэг болохыг харуулдаг. Өөрөөр хэлбэл Монгол Улс Ромын дүрмийг соёрхон баталсан үеэс эхлэн уг дүрэм нь үндэсний эрх зүйн орчны нэг хэсэг болсон гэж үзэх боломжтой. Гэсэн хэдий ч олон улсын эрх зүйн онолд гэрээг соёрхон батлах болон гэрээг бодитоор хэрэгжүүлэх нь өөр өөр ойлголт гэж үздэг. Соёрхон баталсан гэрээ автоматаар бүрэн хэрэгждэггүй бөгөөд түүний хэрэгжилтийг хангахын тулд дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх шаардлагатай байдаг (Shaw, 2021).

Ромын дүрмийн хувьд энэ асуудал онцгой ач холбогдолтой байдаг. Учир нь дүрэм нь зөвхөн олон улсын гэмт хэргийн тодорхойлолтыг тогтоогоод зогсохгүй оролцогч улсаас

ОУЭШ-тэй идэвхтэй хамтран ажиллахыг шаарддаг. Тухайлбал сэжигтэн баривчлах, нотлох баримт шилжүүлэх, гэрч хамгаалах, хөрөнгө битүүмжлэх зэрэг олон ажиллагаанд үндэсний байгууллагууд оролцох шаардлагатай байдаг (Rome Statute, Part IX).

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт хүн бүр:

- “хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдвөл шүүхэд гомдол гаргах” эрхтэй гэж заасан байдаг.

Энэхүү зохицуулалт нь шударга шүүхээр шүүлгэх эрхийн үндсэн баталгаа бөгөөд Ромын дүрмийн 55 болон 67 дугаар зүйлд тусгагдсан сэжигтэн, яллагдагчийн эрхийн хамгаалалттай агуулгын хувьд нийцдэг. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хууль болон Ромын дүрэм хоёулаа эрүүгийн процессын явцад хүний үндсэн эрхийг хамгаалах нийтлэг зорилгыг баримталдаг.

Гэвч ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Үндсэн хуулийн түвшинд тодорхой маргаан дагуулж болох асуудлууд мөн бий. Тэдгээрийн нэг нь төрийн өндөр албан тушаалтны дархан эрхийн асуудал юм.

Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд Ерөнхийлөгч болон зарим өндөр албан тушаалтны халдашгүй байдлын талаар тусгай зохицуулалт байдаг. Хэдийгээр эдгээр зохицуулалт нь үндэсний эрх зүйн хүрээнд төрийн тогтвортой ажиллагааг хангах зорилготой боловч олон улсын эрүүгийн эрх зүйн үүднээс авч үзвэл тодорхой тайлбарын асуудал үүсгэх боломжтой. Ялангуяа Ромын дүрмийн 27 дугаар зүйл болон 98 дугаар зүйлтэй холбоотой маргаан нь олон улсын практикт хамгийн их хэлэлцэгддэг асуудлуудын нэг болсон байдаг (Akande, 2017).

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд ОУЭШ-ийн хүсэлтээр этгээдийг шүүхэд шилжүүлэх (surrender) ажиллагааны талаар тусгай зохицуулалт байдаггүй. Олон улсын эрүүгийн эрх зүйн онолд “extradition” буюу шилжүүлэн өгөх болон “surrender” буюу ОУЭШ-д шилжүүлэх гэсэн ойлголтыг ялгаатай гэж үздэг. Шилжүүлэн өгөх нь хоёр улсын хооронд явагддаг бол шилжүүлэх ажиллагаа нь олон улсын шүүхийн өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх ажиллагаа юм (Schabas, 2020). Монгол Улсын хууль тогтоомжид энэхүү ялгаа хангалттай тодорхой тусгагдаагүй байгаа нь практик хэрэгжилтийн түвшинд тодорхой хүндрэл үүсгэх боломжтой.

Иймээс Монгол Улсын Үндсэн хууль нь Ромын дүрмийн өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх ерөнхий эрх зүйн үндсийг бүрдүүлж байгаа боловч ОУЭШ-тэй хамтран ажиллах ажиллагааны нарийвчилсан механизм, төрийн өндөр албан тушаалтны дархан эрх, шүүхэд

шилжүүлэх ажиллагааны зохицуулалт зэрэг асуудлыг бүрэн шийдвэрлээгүй байна. Ийм учраас ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүргийг бодитой хэрэгжүүлэх асуудал нь зөвхөн Үндсэн хуулийн түвшинд бус, эрүүгийн болон эрүүгийн процессын хууль тогтоомжийн түвшинд цаашид нарийвчлан зохицуулах шаардлагатай хэвээр байгаа юм.

2.2.2 Монгол Улсын Эрүүгийн хууль дахь зохицуулалт

Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд нэгдсэн улс орнуудын өмнө тулгардаг хамгийн чухал үүргүүдийн нэг нь олон улсын гэмт хэргийн бүрэлдэхүүнийг үндэсний эрүүгийн хууль тогтоомждоо тусгах явдал байдаг. Энэхүү шаардлага нь Ромын дүрмийн нөхөх зарчим (complementarity principle)-тай шууд холбоотой бөгөөд олон улсын гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүн таслах анхдагч үүргийг үндэсний шүүхүүд хүлээдэг гэсэн үзэл баримтлалд тулгуурладаг (Rome Statute, Preamble; Article 17).

Монгол Улс Ромын дүрэмд нэгдсэний дараа эрүүгийн хууль тогтоомжоо үе шаттайгаар шинэчилж, олон улсын эрүүгийн эрх зүйн зарим суурь ойлголтыг үндэсний эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлсэн. Ялангуяа 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга нь олон улсын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг үндэсний түвшинд нутагшуулахад чухал алхам болсон гэж үздэг (Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015).

Ромын дүрмийн гэмт хэргүүдийг үндэсний хууль тогтоомжид тусгасан байдал

Монгол Улсын Эрүүгийн хуулийн Хорин есдүгээр бүлэгт “Энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” гэсэн бүлгийг тусгайлан зохицуулсан байдаг. Энэ бүлэг нь Ромын дүрмийн үндсэн үзэл баримтлалтай хамгийн ойр зохицуулалт юм.

Хүснэгт 2.1. Ромын дүрэм ба Монгол Улсын Эрүүгийн хуулийн харьцуулалт

Ромын дүрэм	Монгол Улсын Эрүүгийн хууль
Геноцид (Article 6)	29.5 Төрлөөр устгах
Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг (Article 7)	29.3 Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг
Дайны гэмт хэрэг (Article 8)	29.7 Дайны гэмт хэрэг
Түрэмгийллийн гэмт хэрэг (Article 8 bis)	29.1 Түрэмгий дайн өдөөх

Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэл

Энэхүү харьцуулалтаас үзэхэд Монгол Улс Ромын дүрмийн харьяалах дөрвөн үндсэн гэмт хэргийн агуулгыг үндэсний хууль тогтоомжид тодорхой хэмжээнд тусгаж чадсан байна.

Төрлөөр устгах гэмт хэргийн зохицуулалт- Монгол Улсын Эрүүгийн хуулийн 29.5 дугаар зүйлд төрлөөр устгах гэмт хэргийг хуульчилсан байдаг. Энэхүү зохицуулалт нь Ромын дүрмийн 6 дугаар зүйл болон 1948 оны Геноцидын конвенцийн агуулгатай үндсэндээ нийцдэг.

Гэсэн хэдий ч олон улсын судлаачдын үздэгээр геноцидын гэмт хэргийн хамгийн гол шинж болох *dolus specialis* буюу тодорхой бүлгийг устгах тусгай зорилгыг үндэсний түвшинд нотлох ажиллагаа маш төвөгтэй байдаг (Schabas, 2009). Монгол Улсын хууль тогтоомжид энэ ойлголтыг тусгасан боловч практикт хэрхэн тайлбарлах талаар шүүхийн туршлага одоогоор бүрдээгүй байна.

Хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн зохицуулалт- Ромын дүрмийн 7 дугаар зүйлд хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнийг маш дэлгэрэнгүй тодорхойлсон байдаг. Үүнд аллага, устгал, боолчлол, албадан шилжүүлэлт, эрүүдэн шүүх, бэлгийн хүчирхийлэл, хавчлага зэрэг олон үйлдэл багтдаг.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 29.3 дугаар зүйлд хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг тусгасан боловч Ромын дүрэмтэй харьцуулахад зарим ойлголт харьцангуй ерөнхий шинжтэй хэвээр байна. Тухайлбал хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг нь “өргөн хүрээтэй эсхүл системтэй халдлага”-ын хүрээнд үйлдэгдсэн байх шаардлагатай гэсэн олон улсын эрх зүйн гол шалгуур үндэсний хуульд төдийлөн дэлгэрэнгүй тайлбарлагдаагүй байдаг (Cassese, 2008).

Дайны гэмт хэргийн зохицуулалт- Монгол Улсын Эрүүгийн хуулийн 29.7 дугаар зүйл нь дайны гэмт хэргийн асуудлыг зохицуулдаг. Энэхүү зохицуулалт нь Женевийн конвенцууд болон Ромын дүрмийн 8 дугаар зүйлтэй уялдсан байдаг.

Гэсэн хэдий ч Ромын дүрэм дайны гэмт хэргийн 50 гаруй хэлбэрийг нарийвчлан тодорхойлсон байдаг бол Монгол Улсын хууль тогтоомж илүү ерөнхий зохицуулалттай хэвээр байна. Ялангуяа хүүхдийг цэргийн албанд хүчээр татах, хүмүүнлэгийн байгууллагын ажилтанд халдах, соёлын өвд халдах зэрэг орчин үеийн олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зарим ойлголт хангалттай нарийвчлалтай тусгагдаагүй байна (Henckaerts & Doswald-Beck, 2005).

Түрэмгийллийн гэмт хэргийн зохицуулалт- Монгол Улсын Эрүүгийн хуулийн 29.1 дүгээр зүйлд түрэмгий дайн өдөөхтэй холбоотой зохицуулалт бий. Энэ нь агуулгын хувьд Ромын дүрмийн 8 дугаар зүйлтэй ойролцоо боловч бүрэн адил биш юм.

Ромын дүрмийн дагуу түрэмгийллийн гэмт хэрэг нь зөвхөн төрийн улс төр, цэргийн удирдлагын түвшний этгээдэд хамаардаг бөгөөд 2010 оны Кампалын нэмэлт өөрчлөлтөөр нарийвчлан тодорхойлогдсон байдаг (Kampala Amendments, 2010).

Харин Монгол Улсын хууль тогтоомжид түрэмгийллийн гэмт хэргийн субъект, объектив тал, олон улсын шинжийг тодорхойлох асуудал харьцангуй ерөнхий зохицуулалттай байна.

Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үнэлгээ- Монгол Улс Ромын дүрмийн үндсэн гэмт хэргүүдийг Эрүүгийн хуульдаа тусгасан нь олон улсын эрүүгийн эрх зүйн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх чиглэлд гарсан томоохон ахиц гэж үнэлэгддэг. Гэсэн хэдий ч зөвхөн гэмт хэргийн нэр томъёог хуульчлах нь хангалтгүй юм.

Олон улсын практикт Ромын дүрмийн хэрэгжилт дараах гурван түвшинд үнэлэгддэг байна (Bassiouni, 2011):

- Гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчлах;
- Процессын хэрэгжилтийн механизмыг бий болгох;
- ОУЭШ-тэй хамтран ажиллах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх.

Монгол Улс эхний түвшинд тодорхой ахиц гаргасан боловч хоёр болон гурав дахь түвшний хэрэгжилт харьцангуй сул хэвээр байна. Ялангуяа ОУЭШ-ийн хүсэлтээр этгээд шилжүүлэх, хөрөнгө битүүмжлэх, нотлох баримт дамжуулах, гэрч хамгаалах зэрэг ажиллагааг зохицуулсан тусгай процессын хууль тогтоомж өнөөдөр ч бүрэн бүрдээгүй байна.

Иймээс Монгол Улсын Эрүүгийн хууль нь Ромын дүрмийн үндсэн шаардлагыг тодорхой хэмжээнд хангаж байгаа боловч олон улсын эрүүгийн эрх зүйн орчин үеийн стандартад бүрэн нийцсэн гэж үзэхэд эрт байна. Энэхүү нөхцөл байдал нь зөвхөн материаллаг эрх зүйн түвшинд бус, процессын эрх зүйн зохицуулалтын хүрээнд цаашид боловсронгуй болгох шаардлага байгааг харуулж байна.

2.2.3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дахь зохицуулалт

Олон улсын эрүүгийн эрх зүйн хүрээнд хүлээсэн үүргийг бодитоор хэрэгжүүлэхэд материаллаг эрх зүйн зохицуулалт дангаараа хангалтгүй байдаг. Хэдийгээр тухайн улс олон улсын гэмт хэргийн бүрэлдэхүүнийг Эрүүгийн хуульдаа тусгасан байсан ч мөрдөн шалгах ажиллагаа явуулах, нотлох баримт солилцох, сэжигтэн баривчлах, шилжүүлэх, олон улсын эрх зүйн туслалцаа үзүүлэх зэрэг процессын асуудлыг зохицуулсан эрх зүйн механизм байхгүй бол олон улсын эрүүгийн эрх зүйн үүргийг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болдог. Ийм учраас ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг үнэлэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШТХ)-ийн зохицуулалт онцгой ач холбогдолтой юм.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, яллах, шүүхээр шийдвэрлэх ажиллагааны үндсэн журмыг тогтоодог бөгөөд олон улсын хамтын ажиллагаатай холбоотой тодорхой зохицуулалтыг мөн агуулдаг (Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017).

Олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн үндэс

ЭХХШТХ-д олон улсын эрүүгийн эрх зүйн туслалцаа үзүүлэх, хүсэлт гүйцэтгэх, эрүүгийн хэрэгтэй холбоотой мэдээлэл солилцох, мөрдөн шалгах ажиллагаанд харилцан туслалцаа үзүүлэх зэрэг асуудлыг зохицуулсан байдаг.

Хуулийн холбогдох зохицуулалтаар Монгол Улсын эрх бүхий байгууллагууд нь:

- эрүүгийн хэрэгт холбогдох баримт бичиг гардуулах;
- гэрч, хохирогчоос мэдүүлэг авах;
- шинжээч томилох;
- эд мөрийн баримт шилжүүлэх;
- нэгжлэг, хураалт явуулах;
- эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зэрэг ажиллагааг олон улсын гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх боломжтой байдаг.

Эдгээр зохицуулалт нь олон улсын эрх зүйн туслалцааны ерөнхий механизмыг бүрдүүлдэг боловч үндсэндээ улс хоорондын хамтын ажиллагаанд чиглэсэн шинжтэй байдаг.

ОУЭШ-тэй хамтран ажиллах тусгай зохицуулалтын дутагдал

Монгол Улс Ромын дүрэмд 2002 онд нэгдсэн хэдий ч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд ОУЭШ-тэй хамтран ажиллах тусгай бүлэг, тусгай журам өнөөдрийг хүртэл тусгагдаагүй байна.

Ромын дүрмийн IX бүлэг ("Олон улсын хамтын ажиллагаа ба шүүхийн туслалцаа")-т оролцогч улсууд дараах үүргийг хүлээдэг:

- баривчлах захирамжийг биелүүлэх;
- этгээдийг ОУЭШ-д шилжүүлэх;
- нотлох баримт гаргаж өгөх;
- гэрч хамгаалах;
- хөрөнгө царцаах, битүүмжлэх;
- ял эдлүүлэх ажиллагаанд хамтран ажиллах;

- мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх. (Rome Statute, Part IX).

Гэвч эдгээр ажиллагааг Монгол Улсад ямар байгууллага, ямар журмаар хэрэгжүүлэх талаар ЭХХШТХ-д тодорхой зохицуулалт байхгүй байна. Жишээлбэл, ОУЭШ-аас Монгол Улсад оршин байгаа этгээдийг шилжүүлэх хүсэлт ирсэн гэж үзвэл:

- хүсэлтийг ямар байгууллага хүлээн авах вэ?
- Улсын ерөнхий прокурорын газар уу?
- Хууль зүй, дотоод хэргийн яам уу?
- шүүх шийдвэр гаргах уу?
- Засгийн газар шийдвэрлэх үү? гэсэн асуудал хуульд тодорхой тусгагдаагүй байна.

Иймээс практикт эрх бүхий байгууллагуудын чиг үүргийн давхардал, тодорхойгүй байдал үүсэх эрсдэлтэй байдаг (Schabas, 2020).

Шилжүүлэн өгөх ба ОУЭШ-д шилжүүлэх ажиллагааны ялгаа

Монгол Улсын процессын эрх зүйн тогтолцоонд хамгийн их анхаарал татдаг асуудлын нэг нь шилжүүлэн өгөх (extradition) болон ОУЭШ-д шилжүүлэх (surrender) ажиллагааны ялгаа юм.

Олон улсын эрх зүйн онолд:

- **Extradition** гэдэг нь нэг улсаас нөгөө улсад этгээдийг шилжүүлэх ажиллагааг;
- **Surrender** гэдэг нь үндэсний шүүхийн харьяаллаас ОУЭШ-ийн харьяалалд этгээдийг шилжүүлэх ажиллагааг тус тус ойлгодог (Schabas, 2020).

Эдгээр нь эрх зүйн шинжийн хувьд өөр ойлголтууд боловч Монгол Улсын хууль тогтоомжид ийм ялгаа тодорхой тусгагдаагүй байна. Үүний улмаас ОУЭШ-ийн хүсэлтээр этгээдийг шилжүүлэх шаардлага үүсвэл ямар процессын журам хэрэглэх нь тодорхой бус хэвээр байна.

Нотлох баримт солилцох ажиллагааны асуудал

ОУЭШ-ийн мөрдөн шалгах ажиллагаанд оролцогч улсууд нотлох баримт цуглуулах, дамжуулах, хадгалах ажиллагаанд идэвхтэй хамтран ажиллах үүрэгтэй байдаг. Гэвч Монгол Улсын ЭХХШТХ-д:

- ОУЭШ-ийн прокурорт мэдээлэл гаргаж өгөх;
- цахим нотлох баримт шилжүүлэх;

- гэрч хамгаалах олон улсын ажиллагаанд оролцох;
- ОУЭШ-ийн мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; талаарх нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Энэ нь Ромын дүрмийн IX бүлгээр хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж болзошгүй юм.

Гэрч, хохирогч хамгаалах тогтолцоо

ОУЭШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг онцлог нь гэрч, хохирогчийн хамгаалалт байдаг. Ялангуяа хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэргийн үед гэрчүүдийн аюулгүй байдал онцгой ач холбогдолтой болдог.

Монгол Улсын ЭХХШТХ-д гэрч, хохирогч хамгаалах ерөнхий зохицуулалт байгаа боловч олон улсын эрүүгийн хэрэгтэй холбоотой тусгай хамгаалалтын тогтолцоо хараахан бүрдээгүй байна.

ОУЭШ-ийн практикт хэрэглэдэг:

- нэр нууцлах;
- дүрс, дуу хоолой өөрчлөх;
- гуравдагч улсад нүүлгэн шилжүүлэх;
- олон улсын хамгаалалтын хөтөлбөр хэрэгжүүлэх; зэрэг арга хэмжээнүүдийг үндэсний хууль тогтоомжид нарийвчлан тусгаагүй байдаг (ICC Rules of Procedure and Evidence, Rules 87–88).

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь олон улсын эрүүгийн эрх зүйн туслалцааны ерөнхий зохицуулалтыг агуулж байгаа боловч Олон улсын эрүүгийн шүүхтэй хамтран ажиллах тусгай процессын тогтолцоог бүрэн бүрдүүлж чадаагүй байна. Ялангуяа этгээдийг ОУЭШ-д шилжүүлэх, баривчлах захирамж биелүүлэх, нотлох баримт дамжуулах, гэрч хамгаалах болон хөрөнгө битүүмжлэх ажиллагааны нарийвчилсан журам байхгүй байгаа нь Ромын дүрмийн дагуу хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд эрх зүйн тодорхойгүй байдал үүсгэж байна.

Иймээс Монгол Улсын хувьд олон улсын эрүүгийн эрх зүйн материаллаг зохицуулалтыг хуульчилсан хэдий ч, процессын эрх зүйн хэрэгжилтийн механизм харьцангуй сул хэвээр байгаа бөгөөд энэ нь ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд тулгамдсан гол асуудлын нэг болж байна.

2.2.4 Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээний зохицуулалт

Монгол Улс болон Оросын Холбооны Улсын хоорондын эрх зүйн хамтын ажиллагааны үндсэн баримт бичгийн нэг нь 1999 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан “**Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээ**” юм. Энэхүү гэрээ нь хоёр улсын хооронд иргэний, гэр бүлийн болон эрүүгийн хэрэгтэй холбоотой эрх зүйн туслалцаа үзүүлэх харилцааг зохицуулах зорилготой бөгөөд өнөөдөр ч хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн чухал эх сурвалжийн нэг (Монгол Улс, ОХУ-ын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээ, 1999).

Уг гэрээ нь Зөвлөлт Холбоот Улс задран унасны дараах шинэ нөхцөл байдалд Монгол Улс болон ОХУ-ын хоорондын эрх зүйн хамтын ажиллагааг шинэчлэх зорилгоор байгуулагдсан бөгөөд хоёр улсын шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллагуудын хооронд харилцан туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн юм. Гэрээний агуулгаас үзэхэд эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд хамтран ажиллах, баримт бичиг солилцох, гэрчээс мэдүүлэг авах, шинжээч томилох, ял шийтгэгдсэн этгээдийн асуудлыг шийдвэрлэх зэрэг өргөн хүрээний харилцааг зохицуулдаг.

Эрх зүйн туслалцааны үндсэн хэлбэрүүд

Гэрээний дагуу талууд эрүүгийн хэрэгтэй холбоотой дараах үндсэн хэлбэрээр харилцан туслалцаа үзүүлэх үүрэг хүлээдэг. Үүнд:

- шүүхийн болон мөрдөн шалгах ажиллагаанд шаардлагатай баримт бичиг гардуулах;
- гэрч, хохирогч, шинжээчээс мэдүүлэг авах;
- нотлох баримт цуглуулах;
- эд мөрийн баримт шилжүүлэх;
- шинжээчийн дүгнэлт гаргуулах;
- эрүүгийн хэрэгтэй холбоотой мэдээлэл солилцох;
- шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхтэй холбоотой ажиллагаа хэрэгжүүлэх зэрэг асуудлууд багтдаг (Гэрээний 5-14 дүгээр зүйлүүд).

Эдгээр зохицуулалт нь эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд хил дамнасан нотлох баримт цуглуулах, мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй явуулах боломжийг бүрдүүлдэг.

Эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа

Гэрээг хэрэгжүүлэх хүрээнд хоёр улсын төв байгууллагууд хоорондоо шууд харилцах боломжтой байдаг.

Монгол Улсын хувьд:

- Улсын Ерөнхий прокурорын газар;
- Шүүхийн байгууллага;
- Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн байгууллагууд;

Харин ОХУ-ын хувьд:

- ОХУ-ын Ерөнхий прокурорын газар;
- Шүүхийн байгууллагууд;
- Холбогдох мөрдөн шалгах байгууллагууд гэрээний хэрэгжилтийг хангахад оролцдог.

Энэхүү тогтолцоо нь эрүүгийн хэрэгтэй холбоотой хүсэлтүүдийг дипломат сувгийг заавал ашиглахгүйгээр шууд дамжуулах боломж олгодог бөгөөд ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлдэг гэж үздэг (Баттөр, 2018).

Эрүүгийн хэрэгт холбогдсон этгээдтэй холбоотой зохицуулалт

Гэрээний чухал хэсгийн нэг нь эрүүгийн хэрэгт холбогдсон этгээдтэй холбоотой харилцааг зохицуулсан зохицуулалтууд юм. Тухайлбал:

- яллагдагчийн байршлыг тогтоох;
- ял эдэлж буй хүний талаар мэдээлэл солилцох;
- ял шийтгэгдсэн этгээдтэй холбоотой мэдээлэл дамжуулах;
- мөрдөн шалгах ажиллагаанд шаардлагатай этгээдийг түр шилжүүлэх зэрэг ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг гэрээнд тусгасан байдаг.

Энэ нь хоёр улсын хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой юм.

Туслалцаа үзүүлэхээс татгалзах үндэслэл

Гэрээ нь харилцан туслалцаа үзүүлэх ерөнхий үүргийг тогтоосон хэдий ч тодорхой нөхцөлд хүсэлтийг биелүүлэхээс татгалзах боломжийг мөн олгосон байдаг. Тухайлбал хүсэлтийг биелүүлэх нь:

- улсын бүрэн эрхт байдалд харшлах;
- үндэсний аюулгүй байдалд хохирол учруулах;

- нийтийн дэг журамд ноцтой нөлөөлөх;
- улсын үндсэн ашиг сонирхолд харшлах тохиолдолд хүсэлтийг биелүүлэхээс татгалзаж болохоор зохицуулсан байдаг (Гэрээний холбогдох зүйлүүд).

Энэ төрлийн зохицуулалт нь олон улсын эрх зүйн туслалцааны гэрээнүүдэд нийтлэг байдаг бөгөөд улсын бүрэн эрхт байдлыг хамгаалах зорилготой (Bassiouni, 2014).

Монгол Улсын ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүрэгтэй уялдах асуудал

Энэхүү гэрээ нь 1999 онд буюу Олон улсын эрүүгийн шүүх албан ёсоор байгуулагдахаас өмнө батлагдсан онцлогтой. Тиймээс гэрээний аль ч хэсэгт ОУЭШ, Ромын дүрэм, олон улсын эрүүгийн шүүхэд этгээд шилжүүлэх асуудлыг тусгайлан зохицуулаагүй байдаг.

Өөрөөр хэлбэл уг гэрээний зохицуулалт нь үндсэндээ хоёр улсын хоорондын эрүүгийн эрх зүйн туслалцааны уламжлалт механизмыг бүрдүүлдэг бөгөөд олон улсын эрүүгийн шүүхтэй хамтран ажиллах харилцааг хамардаггүй байна.

Гэсэн хэдий ч Монгол Улс 2002 онд Ромын дүрэмд нэгдсэнээр ОУЭШ-тэй хамтран ажиллах олон улсын эрх зүйн нэмэлт үүрэг хүлээсэн. Иймээс Монгол Улсын өмнө нэг талаас ОУЭШ-ийн өмнө хүлээсэн олон талт гэрээний үүрэг, нөгөө талаас ОХУ-тай байгуулсан хоёр талт гэрээгээр хүлээсэн үүрэг зэрэгцэн оршин байгаа нөхцөл бүрдсэн гэж үзэж болно.

Энэ асуудал нь зөвхөн онолын бус, практик ач холбогдолтой бөгөөд ялангуяа төрийн өндөр албан тушаалтан, олон улсын эрүүгийн эрх зүйн харьяалалтай холбоотой нөхцөл байдал үүсэх үед эрх зүйн тайлбарын төвөгтэй асуудал бий болгож болзошгүй юм. Иймээс Монгол Улс ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд энэхүү гэрээ ямар нөлөө үзүүлж болох талаар дараагийн хэсэгт нарийвчлан авч үзэх шаардлагатай.

Дүгнэлт

Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд байгуулсан 1999 оны эрх зүйн туслалцааны гэрээ нь хоёр улсын эрүүгийн эрх зүйн хамтын ажиллагааны үндсэн эрх зүйн суурийг бүрдүүлж байна. Тус гэрээ нь нотлох баримт солилцох, гэрчээс мэдүүлэг авах, мөрдөн шалгах ажиллагаанд харилцан туслалцаа үзүүлэх зэрэг олон чухал асуудлыг зохицуулсан боловч ОУЭШ байгуулагдахаас өмнө батлагдсан тул олон улсын эрүүгийн шүүхтэй хамтран ажиллах асуудлыг тусгаагүй байна. Иймээс энэхүү гэрээ болон Ромын дүрмийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүргийн уялдаа холбоо нь орчин үеийн олон улсын эрүүгийн эрх зүйн хүрээнд онцгой анхаарал татах асуудлын нэг болж байна.

Хүснэгт 2.2. ОУЭЭ-н үндсэн баримт бичгүүд

Эрх зүйн баримт бичиг	Батлагдсан он	Зорилго
Ромын дүрэм	1998	ОУЭШ-ийн эрх зүйн үндэс
Монгол-Оросын эрх зүйн туслалцааны гэрээ	1999	Хоёр улсын эрүүгийн хамтын ажиллагаа
Монгол Улсын Эрүүгийн хууль	2015	Олон улсын гэмт хэргийг дотооддоо хуульчлах
ЭХХШТХ	2017	Эрүүгийн процессын зохицуулалт

Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэл

2.3. Монгол Улсад тулгарч буй эрх зүйн болон институцийн хүндрэлүүд

Монгол Улс Ромын дүрэмд нэгдэн орж, олон улсын эрүүгийн эрх зүйн үндсэн зарчим, хэм хэмжээг дотоодын хууль тогтоомждоо тодорхой хэмжээнд тусгасан хэдий ч Олон улсын эрүүгийн шүүхийн өмнө хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд эрх зүйн болон институцийн шинжтэй хэд хэдэн хүндрэл тулгарсаар байна. Эдгээр хүндрэл нь зөвхөн хууль тогтоомжийн агуулгаар хязгаарлагдахгүй бөгөөд хэрэгжилтийн механизм, байгууллагын уялдаа холбоо, олон улсын гэрээний үүргийн зөрчил зэрэг өргөн хүрээний асуудлыг хамардаг.

2.3.1. Материаллаг эрх зүйн зохицуулалтын хүндрэл

Монгол Улсын Эрүүгийн хуульд Ромын дүрмийн харьяалах төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон түрэмгийллийн гэмт хэрэгтэй холбоотой зохицуулалтыг тусгасан нь чухал ахиц болсон (Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015). Гэсэн хэдий ч эдгээр зохицуулалт нь Ромын дүрмийн агуулгыг бүрэн хэмжээгээр тусгасан гэж үзэхэд хүндрэлтэй байна.

Тухайлбал, Ромын дүрмийн 7 дугаар зүйлд хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнийг өргөн хүрээтэй болон системтэй халдлагын хүрээнд үйлдэгдсэн үйлдэл гэж тодорхойлдог бөгөөд албадан алга болгох, апартеид, бэлгийн боолчлол зэрэг олон төрлийн үйлдлийг нарийвчлан хуульчилсан байдаг (Rome Statute, Article 7). Харин Монгол Улсын Эрүүгийн хуульд эдгээр ойлголтын зарим нь ерөнхий байдлаар тусгагдсан бөгөөд олон улсын шүүхийн практикт хэрэглэгддэг тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн агуулаагүй байна.

Мөн түрэмгийллийн гэмт хэргийн хувьд Ромын дүрмийн Кампалын нэмэлт өөрчлөлтөөр (2010) боловсронгуй болсон орчин үеийн ойлголтыг үндэсний хууль тогтоомжид бүрэн тусгах шаардлага хэвээр байгаа гэж судлаачид үздэг (Kreß & Barriga, 2017).

Түүнчлэн олон улсын эрүүгийн эрх зүйн зарим онцгой зарчим болох командын хариуцлага (command responsibility), хамтын гэмт хэрэг үйлдэх хэлбэрүүд, удирдах түвшний оролцогчийн хариуцлага зэрэг асуудал үндэсний хууль тогтоомжид харьцангуй хязгаарлагдмал тусгагдсан хэвээр байна (Cassese, 2008).

2.3.2. Процессын эрх зүйн зохицуулалтын хүндрэл

Монгол Улсын хувьд хамгийн том хүндрэл нь материаллаг бус, харин процессын эрх зүйн зохицуулалтын түвшинд оршиж байна.

Ромын дүрмийн IX бүлэгт оролцогч улсууд ОУЭШ-тэй бүрэн хамтран ажиллах үүрэгтэй гэж заасан байдаг (Rome Statute, Part IX). Үүнд:

- сэжигтэнг баривчлах;
- ОУЭШ-д шилжүүлэх;
- нотлох баримт гаргаж өгөх;
- хөрөнгө битүүмжлэх;
- гэрчийг хамгаалах;
- мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зэрэг олон төрлийн ажиллагаа хамаардаг.

Гэвч Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эдгээр ажиллагааг хэрэгжүүлэх тусгай журам байхгүй байна. Ялангуяа ОУЭШ-ийн хүсэлтээр этгээдийг шилжүүлэх ажиллагаа ямар байгууллагын эрх хэмжээнд хамаарах, ямар шат дарааллаар шийдвэрлэх талаар тодорхой зохицуулалт дутмаг байгаа нь эрх зүйн тодорхойгүй байдал үүсгэж байна.

Олон улсын туршлагаас үзэхэд Ромын дүрэмд нэгдсэн олон улс тусгай хэрэгжилтийн хууль (ICC Implementation Act) баталсан байдаг. Харин Монгол Улсад ийм бие даасан хууль өнөөдөр байхгүй байна (International Criminal Court, 2024).

2.3.3. Институцийн болон хэрэгжилтийн хүндрэл

ОУЭШ-тэй үр дүнтэй хамтран ажиллахын тулд зөвхөн хууль тогтоомж хангалтгүй бөгөөд хэрэгжилтийг хангах институцийн чадавх шаардлагатай байдаг. Монгол Улсад ОУЭШ-тэй хамтран ажиллах асуудалд:

- Гадаад харилцааны яам;
- Хууль зүй, дотоод хэргийн яам;
- Улсын Ерөнхий прокурорын газар;
- Цагдаагийн байгууллага;
- Шүүхийн байгууллага; оролцох боломжтой боловч эдгээр байгууллагын чиг үүрэг, харилцан ажиллагааны механизмыг тусгайлан зохицуулсан эрх зүйн акт байхгүй байна.

Үүнээс гадна Монгол Улсад өнөөг хүртэл ОУЭШ-тэй холбоотой эрүүгийн хэрэг практикт үүсэж байгаагүй тул шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллагуудын туршлага хязгаарлагдмал хэвээр байна. Энэ нь бодит нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэрэгжилтийн хүндрэл бий болгох эрсдэлтэй юм.

Түүнчлэн гэрч хамгаалах тогтолцоо, олон улсын мөрдөн шалгах ажиллагаанд оролцох хүний нөөцийн бэлтгэл, олон улсын эрүүгийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй байгаа нь практик түвшний томоохон сорилт болж байна (Bassiouni, 2011).

2.3.4. ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүрэг ба Монгол–Оросын гэрээний хүрээн дэх эрх зүйн дилемма

Монгол Улсад тулгарч буй хамгийн төвөгтэй асуудлын нэг нь ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүрэг болон хоёр талт олон улсын гэрээний хүрээнд хүлээсэн үүргийн хоорондын уялдаа, хэрэгжилтийн асуудал юм.

Монгол Улс 2002 онд Ромын дүрэмд нэгдсэнээр ОУЭШ-тэй хамтран ажиллах, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн. Харин үүнээс өмнө буюу 1999 онд Монгол Улс, ОХУ-ын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулсан бөгөөд энэхүү гэрээ нь эрүүгийн хэрэгтэй холбоотой хамтын ажиллагааны үндсэн эрх зүйн орчныг бүрдүүлж ирсэн.

Асуудал нь Ромын дүрмийн 27 дугаар зүйлд төрийн өндөр албан тушаалтан эрүүгийн хариуцлагаас ангид байхгүй гэж заасан байдаг бол олон улсын эрх зүйн уламжлалт практикт төрийн тэргүүний дархан эрхийн асуудал үргэлж маргаантай хэвээр байсаар ирсэнд оршино (Akande, 2017).

Энэхүү асуудал 2024 онд ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин Монгол Улсад айлчилсан нөхцөл байдалтай холбоотойгоор олон улсын хэмжээнд өргөн хэлэлцэгдсэн. ОУЭШ 2023 онд Путинд холбогдуулан баривчлах тогтоол гаргасан байсан боловч Монгол Улс түүнийг баривчлаагүй. Үүний дараа олон улсын түвшинд Монгол Улс Ромын дүрмийн өмнө

хүлээсэн үүргээ зөрчсөн эсэх асуудал идэвхтэй хэлэлцэгдсэн юм (ICC, 2023; Amnesty International, 2024).

Нөгөө талаас Монгол Улсын эрх баригчид тухайн асуудал нь үндэсний аюулгүй байдал, гадаад харилцаа болон бүс нутгийн тогтвортой байдалтай холбоотой нарийн төвөгтэй нөхцөл байдлыг үүсгэсэн болохыг онцолж байсан. Энэ нь олон улсын эрүүгийн эрх зүй болон олон улсын улс төрийн бодит нөхцөл байдлын хоорондын зөрчлийг тод харуулсан тохиолдол болсон гэж үзэж болно.

Иймээс Монгол Улсын хувьд ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүрэг, хоёр талт гэрээний үүрэг, үндэсний ашиг сонирхлын хоорондын тэнцвэрийг хэрхэн хангах асуудал нь цаашид эрх зүйн болон бодлогын түвшинд онцгой ач холбогдолтой хэвээр байна.

Дүгнэлт

Монгол Улс Ромын дүрмийн шаардлагын дагуу эрх зүйн тодорхой шинэчлэл хийсэн хэдий ч материаллаг эрх зүй, процессын эрх зүй, институцийн чадавх болон олон улсын гэрээний үүргийн уялдаа холбооны түвшинд шийдвэрлэх шаардлагатай асуудлууд байсаар байна. Ялангуяа ОУЭШ-тэй хамтран ажиллах тусгай эрх зүйн механизм бүрдээгүй байгаа нь хамгийн том хүндрэл бөгөөд энэ нь олон улсын эрүүгийн эрх зүйн өмнө хүлээсэн үүргийг бодитоор хэрэгжүүлэхэд саад болж байна.

III БҮЛЭГ. МОНГОЛ УЛСАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ БА ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

3.1. ОУЭШ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд тулгардаг олон улсын эрх зүйн асуудлууд

Олон улсын эрүүгийн шүүх байгуулагдсан цагаасаа эхлэн төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон түрэмгийллийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн. Гэвч шүүхийн үйл ажиллагаа зөвхөн эрх зүйн асуудлаар хязгаарлагддаггүй бөгөөд олон улсын харилцаа, төрийн бүрэн эрхт байдал, дархан эрх, үндэсний аюулгүй байдал болон улс төрийн хүчин зүйлүүдтэй нягт холбоотой байдаг (Cassese, 2013).

Ромын дүрмийн зорилго нь хамгийн хүнд олон улсын гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг ял шийтгэлгүй үлдээх явдлыг таслан зогсоох явдал боловч практик хэрэгжилтийн явцад хэд хэдэн эрх зүйн маргаантай асуудал үүссээр ирсэн. Ялангуяа төрийн өндөр албан тушаалтны дархан эрхийн асуудал, Ромын дүрмийн 27 болон 98 дугаар зүйлүүдийн харилцан хамаарал, нөхөх зарчмын хэрэгжилт зэрэг нь ОУЭШ-ийн практикт хамгийн их хэлэлцэгддэг асуудлуудын нэг болсон байна (Schabas, 2020).

Эдгээр асуудал нь зөвхөн онолын ач холбогдолтой бус бөгөөд Омар Аль-Башир, Владимир Путин зэрэг төрийн тэргүүнүүдтэй холбоотой нөхцөл байдал үүсэх үед бодит эрх зүйн маргаан болж хувирдаг. Монгол Улсын хувьд ч мөн адил Ромын дүрмийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх асуудал нь олон улсын болон хоёр талт гэрээний үүргийн уялдаа холбоотой салшгүй холбогдож байгаа тул эдгээр эрх зүйн асуудлыг судлах шаардлага үүсч байна.

3.1.1. Төрийн өндөр албан тушаалтны дархан эрхийн асуудал

Олон улсын эрх зүйн уламжлалт онолд төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн, гадаад хэргийн сайд зэрэг өндөр албан тушаалтнуудыг гадаад улсын эрүүгийн шүүхийн харьяаллаас хамгаалдаг дархан эрх (*immunity ratione personae*) үйлчилдэг гэж үздэг. Энэхүү ойлголт нь улсуудын бүрэн эрхт тэгш байдал (*sovereign equality*) болон нэг улсын шүүх нөгөө улсын төрийн тэргүүнд эрх мэдлээ хэрэгжүүлэх ёсгүй гэсэн зарчимд тулгуурладаг (Brownlie, 2008).

Гэвч Дэлхийн II дайны дараа байгуулагдсан Нюрнбергийн Олон улсын цэргийн шүүхээс анх удаа төрийн өндөр албан тушаалтнуудыг олон улсын гэмт хэрэгт хувь хүний хувьд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой гэсэн зарчмыг тогтоосон юм. Нюрнбергийн

дүрмийн 7 дугаар зүйлд төрийн албан тушаал нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэж заасан бөгөөд энэхүү зарчим хожим олон улсын эрүүгийн эрх зүйн суурь зарчим болж хөгжсөн (United Nations, 1950).

Энэхүү үзэл санаа Ромын дүрмийн 27 дугаар зүйлд бүрэн тусгагдсан байдаг. Уг зүйлд төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн, парламентын гишүүн болон бусад төрийн албан тушаалтан байх нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй бөгөөд үндэсний хууль тогтоомжийн дагуу олгогдсон аливаа дархан эрх нь ОУЭШ-ийн харьяаллыг хэрэгжүүлэхэд саад болохгүй гэж тодорхой заасан байдаг (Rome Statute, Article 27).

Энэхүү зохицуулалтын үндсэн зорилго нь төрийн эрх мэдлийг ашиглан олон улсын хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг хариуцлагаас зайлсхийх боломжгүй болгоход оршино. Учир нь төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг зэрэг нь бүх хүн төрөлхтний нийтлэг ашиг сонирхолд халддаг тул ийм гэмт хэрэг үйлдсэн этгээдэд албан тушаалын үндэслэлээр тусгай хамгаалалт олгох нь шударга ёсны зарчимтай нийцэхгүй гэж үздэг (Cassese, 2013).

Гэсэн хэдий ч энэхүү зарчим нь олон улсын нийтийн эрх зүйн өөр нэг уламжлалт зарчим болох төрийн өндөр албан тушаалтны халдашгүй байдлын ойлголттой мөргөлдөж эхэлсэн. Ялангуяа Ромын дүрэмд нэгдээгүй улсын төрийн тэргүүнд ОУЭШ-ийн баривчлах тогтоол үйлчлэх эсэх асуудал нь өнөөдөр ч олон улсын эрх зүйн хүрээнд бүрэн шийдвэрлэгдээгүй маргаантай асуудал хэвээр байна (Akande, 2017).

Энэ асуудал практикт хамгийн тод илэрсэн тохиолдол нь Суданы Ерөнхийлөгч асан Омар Аль-Баширын хэрэг юм. ОУЭШ 2009 болон 2010 онд түүнд төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэлээр баривчлах тогтоол гаргасан боловч тэрээр олон улсын айлчлалуудаа үргэлжлүүлэн хийж байсан бөгөөд зарим гишүүн улсууд түүнийг баривчлахаас татгалзсан байдаг. Ялангуяа Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс 2015 онд Аль-Баширыг баривчлаагүй нь олон улсын хэмжээнд томоохон маргаан үүсгэж, ОУЭШ тус улсыг Ромын дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж үзсэн (ICC Appeals Chamber, 2019).

Үүнтэй төстэй нөхцөл байдал 2023 онд ОУЭШ ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путинд холбогдуулан баривчлах тогтоол гаргасны дараа дахин бий болсон. Путин нь Ромын дүрэмд нэгдээгүй улсын төрийн тэргүүн бөгөөд түүний дархан эрхийн асуудал, Ромын дүрмийн

хүрээнд хүлээх үүргийн асуудал олон улсын хэмжээнд өргөн хэлэлцэгдэж байна (Schabas, 2023).

Монгол Улсын хувьд энэхүү асуудал онцгой ач холбогдолтой юм. Учир нь Монгол Улс Ромын дүрэмд нэгдсэн улсын хувьд ОУЭШ-тэй хамтран ажиллах үүрэг хүлээдэг боловч нөгөө талаас хөрш орнуудтай байгуулсан олон улсын гэрээ, дипломат харилцаа, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлыг мөн харгалзан үзэх шаардлагатай болдог. Иймээс төрийн өндөр албан тушаалтны дархан эрхийн асуудал нь зөвхөн онолын бус, Монгол Улсын хувьд бодит ач холбогдолтой эрх зүйн асуудал болж байна.

3.1.2. Ромын дүрмийн 27 ба 98 дугаар зүйлийн зөрчилдөөн

Олон улсын эрүүгийн эрх зүйн онол болон практикт хамгийн их маргаан дагуулдаг асуудлын нэг нь Ромын дүрмийн 27 дугаар зүйл болон 98 дугаар зүйлийн харилцан хамаарал юм. Эдгээр хоёр зохицуулалт нь тус тусдаа тодорхой зорилготой боловч практикт хэрэгжихдээ төрийн өндөр албан тушаалтны дархан эрхийн асуудалтай холбогдон эрх зүйн тайлбарын төвөгтэй нөхцөл байдлыг бий болгодог. Ромын дүрмийн 27 дугаар зүйлд төрийн албан тушаал нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэж заасан байдаг. Тус зүйлд:

- “Энэхүү дүрэм нь аливаа этгээдэд албан тушаалын байдлаас үл хамааран адил тэгш үйлчилнэ” хэмээн заасан бөгөөд төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн, парламентын гишүүн болон төрийн бусад албан тушаалтанд ч ялгаагүй үйлчилнэ гэж тодорхойлсон байдаг (Rome Statute, Article 27).

Энэхүү зохицуулалтын үндсэн зорилго нь төрийн эрх мэдэл бүхий этгээдүүд олон улсын хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд албан тушаалын халдашгүй байдлаа ашиглан эрүүгийн хариуцлагаас зайлсхийх боломжийг хаахад оршино. Нюрнбергийн шүүхээс эхлэлтэй энэхүү зарчим нь өнөөдөр олон улсын эрүүгийн эрх зүйн суурь зарчмуудын нэг болсон бөгөөд хувь хүний эрүүгийн хариуцлагын үзэл баримтлалд тулгуурладаг (Cassese, 2013).

Гэвч Ромын дүрмийн 98 дугаар зүйл нь өөр агуулгатай зохицуулалтыг агуулдаг. Тус зүйлд хэрэв ОУЭШ-ийн хүсэлтийг биелүүлэх нь тухайн улсын олон улсын эрх зүйн хүрээнд хүлээсэн дархан эрхийн үүргийг зөрчихөд хүргэх бол тухайн улсын зөвшөөрөлгүйгээр уг хүсэлтийг хэрэгжүүлэхийг шаардах ёсгүй гэж заасан байдаг (Rome Statute, Article 98).

Өөрөөр хэлбэл 27 дугаар зүйл нь “дархан эрх хамаарахгүй” гэж үздэг бол 98 дугаар зүйл нь “зарим тохиолдолд дархан эрхийг харгалзан үзэх шаардлагатай” гэсэн агуулгыг

илэрхийлдэг. Иймээс эдгээр хоёр зүйл нь анх харахад хоорондоо зөрчилдөж байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг бөгөөд олон улсын эрх зүйн хүрээнд өргөн хэлэлцүүлэг өрнүүлэх болсон юм.

Эрдэмтдийн дунд энэ асуудлаар үндсэндээ хоёр чиглэлийн байр суурь бий болсон. Нэгдүгээр байр суурийг баримтлагчид Ромын дүрэмд нэгдсэн улс орнуудын хувьд 27 дугаар зүйл давамгай үйлчлэх ёстой гэж үздэг. Тэдний тайлбарласнаар Ромын дүрэмд нэгдсэнээр тухайн улс төрийн өндөр албан тушаалтны дархан эрхийг ОУЭШ-ийн өмнө хэрэглэхгүй байхыг зөвшөөрсөн гэж үзэх үндэслэлтэй байдаг (Schabas, 2020).

Харин хоёр дахь байр суурийг баримтлагчид 98 дугаар зүйл нь олон улсын эрх зүйн уламжлалт дархан эрхийн тогтолцоог хамгаалах зорилготой бөгөөд ялангуяа Ромын дүрэмд нэгдээгүй улсын төрийн тэргүүнтэй холбоотой асуудалд онцгой ач холбогдолтой гэж үздэг. Тэдний үзэж байгаагаар Ромын дүрэмд нэгдээгүй улс өөрийн төрийн тэргүүний дархан эрхээс татгалзаагүй учир түүний дархан эрх олон улсын эрх зүйн дагуу хадгалагдсаар байдаг (Akande, 2017).

Энэхүү онолын маргаан практикт хамгийн тодорхой илэрсэн тохиолдол нь Суданы Ерөнхийлөгч асан Омар Аль-Баширын хэрэг юм. Судан улс Ромын дүрэмд нэгдээгүй байсан боловч НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл Дарфурын нөхцөл байдлыг ОУЭШ-д шилжүүлсний үндсэн дээр шүүх 2009 болон 2010 онд Аль-Баширт холбогдуулан баривчлах тогтоол гаргасан. Үүний дараа Аль-Башир хэд хэдэн Ромын дүрмийн гишүүн улсад айлчилсан боловч зарим улс түүнийг баривчлахаас татгалзсан байдаг.

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс 2015 онд Аль-Баширыг өөрийн нутаг дэвсгэрт байхад нь баривчлаагүй бөгөөд үүнийг төрийн тэргүүний дархан эрхтэй холбон тайлбарласан. Харин ОУЭШ-ийн Давж заалдах танхим 2019 онд гаргасан шийдвэрээр Ромын дүрмийн гишүүн улсууд ОУЭШ-ийн баривчлах тогтоолыг биелүүлэх үүрэгтэй бөгөөд Аль-Баширын хувьд дархан эрхийг үндэслэн татгалзах боломжгүй гэсэн байр суурийг илэрхийлсэн байдаг (ICC Appeals Chamber Judgment, 2019).

Энэхүү шийдвэр нь олон улсын эрүүгийн эрх зүйн практикт чухал жишиг тогтоосон хэдий ч эрдэм шинжилгээний хүрээнд маргаан үргэлжилсээр байна. Зарим судлаачид уг шийдвэрийг ОУЭШ-ийн эрх мэдлийг өргөжүүлсэн гэж үздэг бол нөгөө хэсэг нь олон улсын нийтийн эрх зүйн уламжлалт дархан эрхийн зарчимд нийцэхгүй гэж шүүмжилдэг (Gaeta, 2021).

Сүүлийн жилүүдэд энэхүү асуудал дахин хурцаар тавигдах болсон нь ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путинтэй холбоотой юм. ОУЭШ 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Путиныг Украины эзлэгдсэн нутаг дэвсгэрээс хүүхдүүдийг хууль бусаар албадан шилжүүлсэн гэх үндэслэлээр баривчлах тогтоол гаргасан (ИСС, 2023). Гэвч ОХУ нь Ромын дүрэмд нэгдээгүй улс тул Путины дархан эрхийн асуудал дахин олон улсын эрх зүйн маргааны төвд орсон.

Монгол Улсын хувьд энэхүү асуудал онцгой ач холбогдолтой. Учир нь Монгол Улс Ромын дүрмийн оролцогч улсын хувьд ОУЭШ-тэй хамтран ажиллах үүрэг хүлээдэг. Нөгөө талаас Монгол Улс ОХУ-тай урт хугацааны стратегийн харилцаатай бөгөөд 1999 оны Монгол–Оросын эрх зүйн туслалцааны гэрээ зэрэг олон улсын хоёр талт үүргийг мөн хэрэгжүүлдэг. Ийм нөхцөлд ОУЭШ-ийн хүсэлт болон төрийн тэргүүний дархан эрхийн асуудал зэрэгцэн гарч ирэхэд эрх зүйн болон улс төрийн шинжтэй төвөгтэй нөхцөл байдал үүсэх боломжтой юм.

2024 онд ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин Монгол Улсад албан ёсны айлчлал хийх үеэр энэхүү асуудал бодит ач холбогдолтой болсон. Монгол Улс түүнийг баривчлаагүй бөгөөд үүний дараа олон улсын байгууллагууд болон хүний эрхийн зарим байгууллага Монгол Улс Ромын дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж шүүмжилсэн. Харин нөгөө талаас Монгол Улсын хувьд бүс нутгийн аюулгүй байдал, хөрш оронтой харилцах харилцаа, эрчим хүч болон эдийн засгийн хамаарал зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай байсан гэж тайлбарлагдсан (Human Rights Watch, 2024; Amnesty International, 2024).

Иймээс Ромын дүрмийн 27 болон 98 дугаар зүйлүүдийн харилцан хамаарал нь зөвхөн онолын маргаан биш бөгөөд олон улсын эрүүгийн эрх зүйн практикт шууд нөлөөлдөг асуудал хэвээр байна. Монгол Улсын хувьд ч энэхүү асуудал нь ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүрэг, хоёр талт олон улсын гэрээ, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын тэнцвэрийг хэрхэн хангах вэ гэсэн төвөгтэй асуудалтай шууд холбогдож байгаа юм.

3.1.3. Нөхөх зарчмын (Complementarity Principle) практик хүндрэл

Олон улсын эрүүгийн шүүхийн үйл ажиллагааны хамгийн онцлог шинжүүдийн нэг нь нөхөх зарчим (complementarity principle) юм. Энэхүү зарчим нь Ромын дүрмийн оршил хэсэг болон 1, 17 дугаар зүйлүүдэд тусгагдсан бөгөөд ОУЭШ нь үндэсний эрүүгийн шүүхүүдийг орлох бус, харин тэдгээрийг нөхөх үүрэгтэй болохыг илэрхийлдэг (Rome Statute, Articles 1, 17).

Өөрөөр хэлбэл олон улсын шинжтэй хүнд гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд тухайн улсын үндэсний шүүх анхдагч харьяаллыг хэрэгжүүлэх бөгөөд зөвхөн тухайн улс мөрдөн шалгах, яллах, шүүн таслах ажиллагааг бодитоор хэрэгжүүлэх боломжгүй эсвэл хүсэлгүй

байгаа нөхцөлд ОУЭШ оролцох эрхтэй байдаг. Иймээс ОУЭШ-ийг олон улсын эрүүгийн эрх зүйн тогтолцооны “эцсийн шатны шүүх” (court of last resort) гэж нэрлэх нь бий (Schabas, 2020).

Нөхөх зарчим нь улсын бүрэн эрхт байдлыг хүндэтгэх болон олон улсын эрүүгийн хариуцлагыг хангах гэсэн хоёр зорилгыг тэнцвэржүүлэхэд чиглэдэг. Нэг талаас тухайн улсын шүүх эрх мэдлийг хамгаалж, үндэсний түвшинд шударга ёсыг тогтоох боломж олгодог бол нөгөө талаас олон улсын хамгийн ноцтой гэмт хэрэгтнүүдийг ял шийтгэлгүй үлдээхээс сэргийлэх механизм болдог (Burke-White, 2008).

Ромын дүрмийн 17 дугаар зүйлд хэрэг дараах нөхцөлд ОУЭШ-ийн харьяалалд хамаарна гэж заасан байдаг.

- Нэгдүгээрт, тухайн улс мөрдөн шалгах ажиллагаа явуулахаас санаатайгаар татгалзсан буюу “хүсэлгүй” (unwilling) байгаа тохиолдолд.
- Хоёрдугаарт, тухайн улсын шүүхийн тогтолцоо нуран унасан, дотоодын зэвсэгт мөргөлдөөн, иргэний дайн, улс төрийн тогтворгүй байдал зэрэг шалтгаанаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бодит боломжгүй буюу “чадамжгүй” (unable) болсон тохиолдолд.
- Гуравдугаарт, үндэсний түвшинд явагдсан ажиллагаа нь бодитой биш, зөвхөн тухайн этгээдийг эрүүгийн хариуцлагаас хамгаалах зорилготой байсан нь тогтоогдсон тохиолдолд ОУЭШ хэрэгт оролцох боломжтой байдаг (Rome Statute, Article 17).

Эдгээр шалгуур нь онолын хувьд тодорхой мэт боловч практикт хэрэглэхэд олон хүндрэл үүсгэдэг. Ялангуяа тухайн улс үнэхээр “хүсэлгүй” байсан уу, эсвэл зөвхөн мөрдөн шалгах ажиллагаа удааширсан уу гэдгийг ялгаж тогтоох нь төвөгтэй байдаг. Үүний улмаас ОУЭШ болон үндэсний засгийн газруудын хооронд харилцан үл ойлголцол үүсэх нь цөөнгүй байдаг (El Zeidy, 2008).

Нөхөх зарчимтай холбоотой хамгийн алдартай маргаануудын нэг нь Ливи улсын Абдулла Аль-Сенуссигийн хэрэг юм. Ливи улс өөрийн үндэсний шүүхээр хэргийг шийдвэрлэх боломжтой гэж мэдэгдэж байсан бол ОУЭШ тухайн ажиллагааны бодит байдлыг үнэлэх шаардлагатай болсон. Улмаар шүүх тухайн нөхцөлд Ливи улс хэрэг хянан шийдвэрлэх тодорхой чадамжтай гэж үзэн үндэсний шүүхэд шилжүүлсэн байдаг (ICC, Prosecutor v. Abdullah Al-Senussi, 2014).

Үүнтэй төстэй нөхцөл байдал Кени улсын сонгуулийн дараах хүчирхийлэлтэй холбоотой хэрэг дээр мөн үүссэн. Кени улс үндэсний түвшинд мөрдөн шалгах ажиллагаа

явуулж байгаа гэж мэдэгдсэн боловч ОУЭШ тухайн ажиллагааг хангалтгүй гэж үзэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлсэн байдаг (Prosecutor v. Ruto and Sang, ICC, 2012).

Эдгээр жишээнээс харахад нөхөх зарчим нь зөвхөн эрх зүйн бус улс төрийн шинжтэй асуудал болж хувирдаг. Учир нь ОУЭШ тухайн улсын шүүхийн тогтолцоог үнэлж, “чадвартай эсэх”, “хүсэлтэй эсэх”-ийг тогтоох шаардлагатай болдог бөгөөд энэ нь зарим улсын хувьд дотоод хэрэгт нь хөндлөнгөөс оролцож байгаа мэт ойлгогдох тохиолдол байдаг (Mégret, 2011).

Монгол Улсын хувьд нөхөх зарчим онцгой ач холбогдолтой. Учир нь Монгол Улс Ромын дүрэмд нэгдсэн боловч өнөөдрийг хүртэл ОУЭШ-ийн харьяалах төрлийн хэрэг үндэсний хэмжээнд үүсч байгаагүй байна. Гэсэн хэдий ч цаашид ийм нөхцөл байдал үүссэн тохиолдолд үндэсний шүүх болон мөрдөн шалгах байгууллагууд тухайн хэрэгт үр нөлөөтэй ажиллагаа явуулах чадвартай байх шаардлага тавигдана.

Өмнөх бүлэгт авч үзсэнчлэн Монгол Улсын Эрүүгийн хуульд олон улсын гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тусгасан боловч ОУЭШ-тэй хамтран ажиллах процессын нарийвчилсан зохицуулалт хангалтгүй хэвээр байна. Үүний улмаас онолын хувьд Монгол Улс нөхөх зарчмын хүрээнд анхдагч харьяаллаа хэрэгжүүлэх боломжтой боловч практик хэрэгжилтийн түвшинд тодорхой хүндрэлүүд үүсэх эрсдэлтэй гэж үзэж болно.

Түүнчлэн нөхөх зарчим нь Монгол Улсын хувьд зөвхөн эрүүгийн эрх зүйн асуудал биш бөгөөд үндэсний бүрэн эрхт байдал, шүүхийн хараат бус байдал, олон улсын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийн асуудалтай шууд холбоотой юм. Иймээс Монгол Улс Ромын дүрмийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэхийн тулд үндэсний шүүхийн тогтолцооны чадавхыг нэмэгдүүлэх, олон улсын эрүүгийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, процессын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Дүгнэлт

Нөхөх зарчим нь ОУЭШ-ийн эрх мэдлийн үндсэн тулгуур бөгөөд үндэсний шүүхийн бүрэн эрх болон олон улсын эрүүгийн шударга ёсны хоорондын тэнцвэрийг хангах зорилготой. Гэвч “хүсэлгүй” болон “чадамжгүй” гэх ойлголтыг тодорхойлох хүндрэл, улс төрийн нөлөөлөл, үндэсний шүүхийн тогтолцооны ялгаатай байдал зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан энэхүү зарчим практикт хэрэгжихдээ олон маргаан дагуулсаар байна. Монгол Улсын хувьд нөхөх зарчмын шаардлагыг бүрэн хангахын тулд зөвхөн материаллаг эрх зүйн зохицуулалт бус, процессын болон институцийн шинэчлэлийг цаашид хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.2. ОУЭШ-ийн практик кейсүүдийн харьцуулсан шинжилгээ

Олон улсын эрүүгийн шүүхийн үйл ажиллагааны үр нөлөөг үнэлэхэд онолын зохицуулалтаас гадна практикт шийдвэрлэсэн хэргүүдийг судлах шаардлагатай байдаг. ОУЭШ байгуулагдсанаас хойш төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэгтэй холбоотой олон хэрэг хянан шийдвэрлэсэн бөгөөд эдгээр нь олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлага, тулгамдсан асуудлыг тодорхой харуулдаг.

Энэхүү судалгаанд Доминик Онгвен, Омар Аль-Башир, Жан-Пьер Бемба болон Ахмад Аль-Махдийн хэргүүдийг сонгон авч үзэв. Эдгээр хэрэг нь ОУЭШ-ийн практикт ял шийтгэл оногдуулсан, цагаатгасан, дархан эрхийн асуудал үүсгэсэн, соёлын өвийн эсрэг гэмт хэрэгт хариуцлага тооцсон зэрэг өөр өөр төрлийн онцлогийг агуулж байгаа бөгөөд Монгол Улсын хувьд олон улсын эрүүгийн эрх зүйн сургамж болох ач холбогдолтой юм.

3.2.1. Доминик Онгвены хэрэг

Доминик Онгвен нь Уганда улсын иргэн бөгөөд Лордын Эсэргүүцлийн Арми (Lord's Resistance Army – LRA) хэмээх зэвсэгт бүлэглэлийн удирдах бүрэлдэхүүний гишүүн байсан. Тэрээр бага насандаа өөрөө хүчээр хулгайлагдан хүүхэд цэрэг болсон боловч хожим уг байгууллагын ахлах командлагч болж, Уганда улсын хойд бүс нутагт олон тооны дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгагдсан байдаг (ICC, Prosecutor v. Dominic Ongwen, 2021). ОУЭШ түүнд нийт 61 зүйл ангиар ял тулгасан бөгөөд үүнд:

- аллага,
- эрүүдэн шүүх,
- боолчлол,
- хүчингийн хэрэг,
- албадан гэрлэлт,
- хүүхэд цэрэг ашиглах,
- иргэний хүн амд халдах зэрэг гэмт хэргүүд багтаж байсан.

2021 оны 2 дугаар сарын 4-ний өдөр ОУЭШ Доминик Онгвеныг 61 зүйл ангийн 61-д нь буруутай гэж үзэн шийдвэр гаргасан бөгөөд 2021 оны 5 дугаар сарын 6-ны өдөр 25 жилийн хорих ял оноосон (ICC Trial Chamber IX, 2021).

Энэхүү хэрэг нь хэд хэдэн шалтгаанаар онцгой ач холбогдолтой болсон. Нэгдүгээрт, ОУЭШ хүүхэд цэрэг ашиглах, бэлгийн боолчлол, албадан жирэмслүүлэх зэрэг хүйсэд

суурилсан гэмт хэргүүдийг маш дэлгэрэнгүй авч үзсэн. Хоёрдугаарт, өөрөө хүүхэд насандаа хохирогч байсан этгээд насанд хүрсний дараа үйлдсэн гэмт хэрэгтээ хариуцлага хүлээж болох эсэх асуудлыг шүүх авч үзсэн. Шүүхээс хохирогч байсан нөхцөл байдал нь ял хөнгөрүүлэх нөхцөл байж болох ч эрүүгийн хариуцлагаас бүрэн чөлөөлөх үндэслэл болохгүй гэж дүгнэсэн (Schabas, 2022).

Мөн шүүхээс 49,000 гаруй хохирогчид нөхөн төлбөр олгох шийдвэр гаргасан нь ОУЭШ-ийн хохирогч төвтэй шударга ёсны тогтолцооны тод жишээ болсон юм. Монгол Улсын хувьд уг хэргээс олон улсын гэмт хэрэгт хувь хүний эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчим, хүүхэд цэрэг ашиглахын эсрэг олон улсын стандартыг судлах ач холбогдолтой гэж үзэж болно.

3.2.2. Омар Аль-Баширын хэрэг

Омар Хасан Ахмад Аль-Башир нь 1989–2019 онд Судан улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан бөгөөд Дарфур мужид үйлдэгдсэн хүний эрхийн ноцтой зөрчилтэй холбоотойгоор ОУЭШ-ийн мөрдөн шалгах ажиллагаанд хамрагдсан анхны төрийн тэргүүн болсон.

Дарфурын мөргөлдөөний үеэр олон зуун мянган хүн амь үрэгдэж, хоёр сая гаруй хүн дүрвэсэн гэж НҮБ мэдээлсэн байдаг (United Nations Security Council, 2005). НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл 2005 онд Дарфурын нөхцөл байдлыг ОУЭШ-д шилжүүлсний дараа шүүх Аль-Баширт холбогдуулан:

- төрлөөр устгах гэмт хэрэг,
- хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг,
- дайны гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэлээр 2009 болон 2010 онд баривчлах тогтоол гаргасан (ICC, 2009; 2010).

Энэхүү хэрэг нь төрийн тэргүүний дархан эрх болон Ромын дүрмийн 27 ба 98 дугаар зүйлүүдийн тайлбартай холбоотой олон улсын хамгийн том маргааныг үүсгэсэн. Аль-Башир ОУЭШ-ийн баривчлах тогтоол хүчин төгөлдөр байх хугацаанд хэд хэдэн гишүүн улсад айлчилсан боловч баривчлагдаагүй.

Ялангуяа Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс 2015 онд Аль-Баширыг баривчлаагүй нь олон улсын хэмжээнд өргөн хэлэлцэгдсэн бөгөөд улмаар ОУЭШ тус улсыг Ромын дүрмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж үзсэн (ICC Appeals Chamber, 2019).

Энэхүү хэрэг нь Монгол Улсад онцгой ач холбогдолтой. Учир нь төрийн тэргүүний дархан эрх болон ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүргийн хооронд үүсдэг зөрчлийг бодит жишээгээр харуулсан бөгөөд 2024 онд Владимир Путинтай холбоотой нөхцөл байдалтай тодорхой хэмжээгээр адилтган авч үзэх боломжтой юм.

3.2.3. Жан-Пьер Бембагийн хэрэг

Жан-Пьер Бемба Гомбо нь Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсын улс төрч, зэвсэгт бүлэглэлийн удирдагч бөгөөд Конгогийн Чөлөөлөх Хөдөлгөөн (Movement for the Liberation of Congo - MLC)-ийг удирдаж байсан. Түүний удирдсан хүчнүүд 2002-2003 онд Төв Африкийн Бүгд Найрамдах Улсад үйл ажиллагаа явуулахдаа хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгагдсан байдаг (ICC, Prosecutor v. Jean-Pierre Bemba Gombo, 2016).

ОУЭШ-ийн Прокурорын газраас Бембад шууд үйлдсэн гэмт хэрэг бус, харин командын хариуцлагын (command responsibility) үндсэн дээр ял тулгасан нь уг хэргийн онцлог байв. Өөрөөр хэлбэл Бемба өөрөө гэмт хэргийг биечлэн үйлдээгүй боловч өөрийн удирдлага дор ажиллаж байсан цэргүүдийн үйлдсэн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хангалттай арга хэмжээ аваагүй гэж үзсэн юм (Rome Statute, Article 28).

2016 онд Анхан шатны танхим Бембаг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэрэгт буруутай гэж үзэн 18 жилийн хорих ял оноосон. Гэвч 2018 онд Давж заалдах шатны танхим уг шийдвэрийг хүчингүй болгож, нотлох баримтын үнэлгээ хангалтгүй байсан гэсэн үндэслэлээр Бембаг цагаатгасан байна (ICC Appeals Chamber, 2018).

Энэхүү хэрэг нь ОУЭШ-ийн түүхэнд хамгийн их хэлэлцэгдсэн шийдвэрүүдийн нэг болсон бөгөөд командын хариуцлагын хүрээг тодорхойлох, цэргийн болон улс төрийн удирдагчдын эрүүгийн хариуцлагыг тогтоох шалгуурыг боловсронгуй болгоход чухал нөлөө үзүүлсэн гэж үздэг (Cassese, 2013).

Мөн уг хэрэг нь эрүүгийн шүүх ажиллагаанд нотлох баримтын чанар, шүүхийн хараат бус байдал, давж заалдах шатны хяналтын ач холбогдлыг харуулсан томоохон жишээ болсон юм.

Монгол Улсын хувьд энэхүү хэргээс удирдах албан тушаалтан өөрөө гэмт хэрэг үйлдээгүй байсан ч өөрийн захирагдагчдын үйлдэлд тодорхой нөхцөлд эрүүгийн хариуцлага хүлээж болох зарчмыг судлах ач холбогдолтой.

3.2.4. Ахмад Аль-Махдийн хэрэг

Ахмад Аль-Факи Аль-Махди нь Малийн иргэн бөгөөд 2012 онд Мали улсын Тимбукту хотод үйл ажиллагаа явуулж байсан зэвсэгт бүлэглэлтэй холбоотойгоор ОУЭШ-ийн өмнө шилжүүлэгдсэн юм. Түүнийг Тимбукту дахь түүх, соёл, шашны онцгой ач холбогдол бүхий дурсгалт байгууламжуудыг санаатайгаар устгасан хэрэгт буруутгасан байдаг (ICC, Prosecutor v. Ahmad Al Faqi Al Mahdi, 2016).

Уг хэрэг нь ОУЭШ-ийн практикт хэд хэдэн шалтгаанаар онцгой байр суурь эзэлдэг:

- Нэгдүгээрт, энэ нь зөвхөн соёлын өвийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгт төвлөрсөн анхны хэрэг болсон.
- Хоёрдугаарт, Аль-Махди гэм буруугаа бүрэн хүлээн зөвшөөрсөн анхны шүүгдэгч болсон.
- Гуравдугаарт, дэлхийн соёлын өвийг хамгаалах асуудлыг олон улсын эрүүгийн эрх зүйн хүрээнд авч үзсэн анхны томоохон шийдвэр болсон юм.

ОУЭШ 2016 онд Аль-Махдийг буруутай гэж үзэн 9 жилийн хорих ял оноосон бөгөөд дараа нь 2.7 сая еврогийн нөхөн төлбөр олгох шийдвэр гаргасан байна (ICC Reparations Order, 2017).

Шүүхээс Тимбукту дахь бунхан, сүм хийд зэрэг объектууд нь зөвхөн Мали улсын төдийгүй бүх хүн төрөлхтний соёлын өв болохыг онцлон тэмдэглэсэн. Иймээс эдгээрийг санаатайгаар устгасан үйлдэл нь зөвхөн өмчийн эсрэг гэмт хэрэг бус, олон улсын хамтын нийгэмлэгийн нийтлэг үнэт зүйлд халдсан үйлдэл гэж үзсэн байдаг (UNESCO, 2017).

Энэхүү хэрэг нь ОУЭШ зөвхөн хүний амь нас, бие махбодын халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэгт бус, мөн хүн төрөлхтний соёлын өвийг хамгаалах чиглэлээр чухал үүрэг гүйцэтгэж болохыг харуулсан.

Монгол Улсын хувьд энэхүү хэргээс соёлын өвийг хамгаалах олон улсын эрх зүйн механизмын ач холбогдлыг ойлгох боломжтой. Монгол Улс дэлхийн соёлын өвийн олон объектод бөгөөд зэвсэгт мөргөлдөөн болон олон улсын гэмт хэргийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд соёлын өвийг хамгаалах асуудал олон улсын эрүүгийн эрх зүйн хүрээнд авч үзэгдэх боломжтойг уг хэрэг харуулж байна.

Дэд бүлгийн дүгнэлт

Доминик Онгвен, Омар Аль-Башир, Жан-Пьер Бемба болон Ахмад Аль-Махдийн хэргүүд нь ОУЭШ-ийн үйл ажиллагааны өөр өөр чиглэлийг төлөөлж байна. Доминик Онгвены хэрэг нь хохирогч төвтэй шударга ёс, хүүхэд цэрэг ашиглахтай тэмцэх асуудлыг; Омар Аль-Баширын хэрэг нь төрийн тэргүүний дархан эрх болон ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүргийн зөрчлийг; Жан-Пьер Бембагийн хэрэг нь командын хариуцлагын зарчмыг; Ахмад Аль-Махдийн хэрэг нь соёлын өвийг хамгаалах асуудлыг тус тус тодорхой харуулсан юм.

3.3. Монгол Улсын нөхцөл байдал

3.3.1. Монгол Улсын эрх зүйн орчны үнэлгээ

Монгол Улс 2002 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр Ромын дүрэмд нэгдэн орж, 2002 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн Олон улсын эрүүгийн шүүхийн оролцогч улсын статустай болсон. Ингэснээр төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон түрэмгийллийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд албан ёсоор нэгдсэн бөгөөд ОУЭШ-тэй хамтран ажиллах, Ромын дүрмийн шаардлагыг дотоодын хууль тогтоомжид хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн юм (Rome Statute, 1998).

Сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд Монгол Улс олон улсын эрүүгийн эрх зүйн зарим үндсэн шаардлагыг үндэсний хууль тогтоомжид тусгах чиглэлээр тодорхой ахиц гаргасан байна. Ялангуяа 2015 оны Эрүүгийн хуульд олон улсын гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдийг тусгайлан хуульчилж, төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэгтэй холбоотой зохицуулалтыг тусгасан нь Ромын дүрмийн хэрэгжилтийн хүрээнд чухал алхам болсон гэж үздэг (Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015).

Гэсэн хэдий ч Монгол Улсын эрх зүйн орчныг бүхэлд нь авч үзвэл Ромын дүрмийн өмнө хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх хэмжээнд хүрсэн гэж дүгнэхэд хүндрэлтэй байна. Учир нь материаллаг эрх зүйн зохицуулалт тодорхой хэмжээнд бүрдсэн боловч процессын болон институцийн хэрэгжилтийн механизм харьцангуй сул хэвээр байна.

Нэгдүгээрт, Монгол Улсад Ромын дүрмийн хэрэгжилтийг хангах бие даасан хэрэгжилтийн хууль (ICC Implementation Act) батлагдаагүй байна. Ромын дүрмийн оролцогч олон улс, тухайлбал Герман, Канад, Австрали, Өмнөд Африк зэрэг улсууд үндэсний хууль тогтоомждоо ОУЭШ-тэй хамтран ажиллах тусгай журам бүхий хэрэгжилтийн хууль баталсан байдаг. Эдгээр хуулиар баривчлах тогтоол биелүүлэх, этгээд шилжүүлэх, нотлох баримт гаргаж өгөх, хөрөнгө битүүмжлэх, гэрч хамгаалах зэрэг ажиллагааны нарийвчилсан механизмыг тогтоосон байдаг (Werle & Jeßberger, 2020).

Харин Монгол Улсад ийм тусгай хууль байхгүй байгаа нь ОУЭШ-ийн хүсэлт ирсэн нөхцөлд ямар байгууллага ямар журмаар шийдвэр гаргах нь тодорхойгүй байх эрсдэлийг бий болгож байна.

Хоёрдугаарт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд ОУЭШ-тэй хамтран ажиллах асуудлыг тусгайлан зохицуулаагүй байна. Хэдийгээр олон улсын эрх зүйн туслалцаатай холбоотой ерөнхий зохицуулалт байгаа боловч ОУЭШ-ийн баривчлах тогтоолыг биелүүлэх, этгээдийг шилжүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлыг нарийвчлан тусгаагүй байдаг. Энэ нь Ромын дүрмийн IX бүлгээр Монгол Улсын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд тодорхой бэрхшээл үүсгэж болзошгүй юм (Rome Statute, Part IX).

Гуравдугаарт, Монгол Улсын хууль тогтоомжид төрийн өндөр албан тушаалтны дархан эрх болон ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүргийн харилцан хамаарлыг тодорхой зохицуулсан эрх зүйн механизм байхгүй байна. Ялангуяа Ромын дүрмийн 27 болон 98 дугаар зүйлүүдийн тайлбар, хэрэгжилттэй холбоотой асуудал дотоодын хууль тогтоомжид нарийвчлан тусгаагүй байгаа нь практикт эрх зүйн тодорхойгүй байдал үүсгэх эрсдэлтэй юм (Akande, 2017).

Дөрөвдүгээрт, институцийн түвшний бэлтгэл хангалтгүй байгаа нь анхаарал татаж байна. ОУЭШ-тэй хамтран ажиллах асуудалд Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын Ерөнхий прокурорын газар, цагдаа болон шүүхийн байгууллага оролцох шаардлагатай байдаг. Гэвч эдгээр байгууллагын чиг үүргийн уялдаа холбоо, харилцан ажиллагааны механизм, онцгой нөхцөлд мөрдөх журам хангалттай боловсруулагдаагүй байна.

Түүнчлэн Монгол Улсад өнөөдрийг хүртэл ОУЭШ-ийн харьяалах төрлийн хэрэг бодитоор үүсч байгаагүй тул шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллагуудын практик туршлага хязгаарлагдмал хэвээр байна. Энэ нь онолын түвшинд бэлтгэлтэй боловч бодит нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэрэгжилтийн хүндрэл бий болох эрсдэлийг нэмэгдүүлдэг (Bassiouni, 2011).

Гэсэн хэдий ч Монгол Улсын эрх зүйн орчинд эерэг талууд мөн бий. Монгол Улс Ромын дүрэмд нэгдсэнээс хойш ОУЭШ-ийн үйл ажиллагааг тууштай дэмжиж ирсэн бөгөөд НҮБ болон олон улсын байгууллагуудын хүрээнд олон улсын эрүүгийн шударга ёсны зарчмыг дэмжсэн байр суурь илэрхийлж байсан. Мөн Монгол Улсын шүүгч Д.Эрдэнэбалсүрэн 2023 онд ОУЭШ-ийн шүүгчээр сонгогдсон нь Монгол Улсын олон улсын эрүүгийн эрх зүйн салбар дахь

оролцоо нэмэгдэж байгааг харуулсан чухал үйл явдал болсон юм (Assembly of States Parties, 2023).

Иймээс Монгол Улсын эрх зүйн орчныг ерөнхийд нь үнэлбэл Ромын дүрмийн материаллаг шаардлагыг тодорхой хэмжээнд хангасан боловч процессын зохицуулалт, институцийн чадавх, хэрэгжилтийн механизмын хувьд цаашид боловсронгуй болгох шаардлагатай хэвээр байна гэж дүгнэж болно. Ялангуяа ОУЭШ-тэй хамтран ажиллах тусгай хууль тогтоомж батлах, эрх бүхий байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгох, олон улсын эрүүгийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх нь цаашдын шинэчлэлийн гол чиглэл болох шаардлагатай байна.

3.3.2. В.В.Путинтай холбоотой 2024 оны тохиолдол

Олон улсын эрүүгийн эрх зүйн хүрээнд төрийн өндөр албан тушаалтны дархан эрх, ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүрэг болон улсын бүрэн эрхт байдлын харилцан хамаарлыг бодит нөхцөл байдал дээр хамгийн тод харуулсан тохиолдлуудын нэг нь ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путинтай холбоотой асуудал. Энэхүү тохиолдол нь Ромын дүрмийн гишүүн улсын хувьд Монгол Улсын өмнө тулгарч болох эрх зүйн болон улс төрийн шинжтэй хүндрэлүүдийг тодорхой харуулсан гэж үзэж болно.

ОУЭШ-ийн Урьдчилсан шатны танхим 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдөр ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин болон ОХУ-ын Хүүхдийн эрхийн асуудал эрхэлсэн комиссар Мария Львова-Белова нарт холбогдуулан баривчлах тогтоол гаргасан. Уг тогтоолд Украины эзлэгдсэн нутаг дэвсгэрээс хүүхдүүдийг ОХУ-ын нутаг дэвсгэрт хууль бусаар албадан шилжүүлсэн байж болзошгүй үйлдэлд холбогдуулан дайны гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх хангалттай үндэслэл байгаа гэж дүгнэсэн байдаг (ICC, 2023).

Ромын дүрмийн 89 дүгээр зүйлд оролцогч улсууд ОУЭШ-ийн баривчлах тогтоолыг хэрэгжүүлэх талаар шүүхтэй хамтран ажиллах үүрэгтэй гэж заасан байдаг. Мөн Ромын дүрмийн 27 дугаар зүйлд төрийн тэргүүний албан тушаал нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэж тодорхой заасан байдаг (Rome Statute, Articles 27, 89).

Гэсэн хэдий ч энэхүү асуудал нь олон улсын эрх зүйн хүрээнд бүрэн шийдвэрлэгдээгүй маргаантай хэвээр байна. Учир нь ОХУ нь Ромын дүрэмд нэгдээгүй улс бөгөөд төрийн тэргүүний дархан эрхийн талаарх уламжлалт олон улсын эрх зүйн зарчим өнөөдөр ч хүчин төгөлдөр үйлчилсээр байгаа талаар зарим судлаачид үздэг. Иймээс Ромын дүрмийн 27 дугаар

зүйл болон 98 дугаар зүйлийн харилцан хамаарлын талаарх маргаан энэ тохиолдолд дахин хүчтэй яригдах болсон юм (Akande, 2017).

Энэхүү асуудал Монгол Улстай шууд холбогдсон нь 2024 оны 9 дүгээр сард болсон үйл явдалтай холбоотой. Владимир Путин Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн бөгөөд энэ нь ОУЭШ-ийн баривчлах тогтоол гарснаас хойш Ромын дүрмийн гишүүн улсад хийсэн өндөр түвшний айлчлалуудын нэг болсон юм. Үүний дараа олон улсын хэвлэл мэдээлэл, хүний эрхийн байгууллагууд болон зарим оролцогч улсууд Монгол Улсыг Ромын дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой байсан гэж мэдэгдэж байв (Human Rights Watch, 2024; Amnesty International, 2024).

Нөгөө талаас Монгол Улсын төрийн байгууллагууд уг асуудалд албан ёсны тайлбар өгөхдөө Монгол Улсын гадаад бодлого, бүс нутгийн аюулгүй байдал, эрчим хүчний хангамж болон хөрш орнуудтай харилцах харилцааны онцлог нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай байсан талаар дурдсан байдаг. Ялангуяа Монгол Улс газарзүйн байрлалын хувьд ОХУ болон БНХАУ гэсэн хоёр хөршөөс эдийн засаг, тээвэр, эрчим хүчний тодорхой хэмжээнд хамааралтай байдаг нь энэхүү асуудлыг зөвхөн эрх зүйн хүрээнд авч үзэх боломжгүй болгож байна.

Энэ тохиолдол нь олон улсын эрүүгийн эрх зүйн онол болон бодит улс төрийн харилцааны хоорондын зөрчлийг тодорхой харуулсан гэж үздэг. Нэг талаас ОУЭШ-ийн үндсэн зорилго нь олон улсын хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг ял шийтгэлгүй үлдээхгүй байх явдал юм. Нөгөө талаас оролцогч улсууд үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого, олон улсын харилцааны бусад хүчин зүйлсийг мөн харгалзан үзэх шаардлагатай байдаг (Schabas, 2023).

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Аль-Баширтай холбоотой хэрэг болон Монгол Улсын Путинтай холбоотой нөхцөл байдлыг харьцуулан үзвэл тодорхой ижил төстэй шинж ажиглагддаг. Аль аль тохиолдолд Ромын дүрмийн гишүүн улс өөрийн нутаг дэвсгэрт ОУЭШ-ийн баривчлах тогтоолтой төрийн тэргүүнийг хүлээн авсан бөгөөд ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүрэг болон гадаад харилцааны бодит нөхцөл байдлын хооронд сонголт хийх шаардлагатай болсон байна.

Гэхдээ эдгээр хоёр тохиолдлыг бүрэн адилтган үзэх боломжгүй юм. Аль-Баширын хэрэг нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолоор ОУЭШ-д шилжүүлэгдсэн нөхцөл байдалтай холбоотой байсан бол Путины хэрэг нь ОХУ болон Украины нөхцөл байдалтай холбоотой

бөгөөд олон улсын эрх зүйн өөр өөр үндэслэлтэй юм. Иймээс тус бүрийг өөрийн эрх зүйн нөхцөл байдлын хүрээнд үнэлэх шаардлагатай байдаг.

Монгол Улсын хувьд энэхүү тохиолдол нь Ромын дүрмийн хэрэгжилттэй холбоотой хэд хэдэн асуудлыг ил болгосон гэж үзэж болно. Нэгдүгээрт, ОУЭШ-ийн баривчлах тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой дотоодын процессын эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа асуудал дахин анхаарал татсан. Хоёрдугаарт, төрийн өндөр албан тушаалтны дархан эрх болон ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүргийн харилцан хамаарлыг үндэсний түвшинд илүү тодорхой зохицуулах шаардлагатай болох нь харагдсан. Гуравдугаарт, олон улсын эрүүгийн эрх зүйн үүрэг болон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын хоорондын тэнцвэрийг хэрхэн хангах асуудал цаашид ч Монгол Улсын өмнө тулгарах боломжтой болохыг харуулсан юм.

Иймээс Владимир Путинтай холбоотой 2024 оны нөхцөл байдал нь зөвхөн нэг удаагийн дипломат үйл явдал биш бөгөөд Монгол Улсын олон улсын эрүүгийн эрх зүйн үүргийн хэрэгжилт, үндэсний эрх зүйн тогтолцооны бэлэн байдал, гадаад бодлогын шийдвэр гаргалтын уялдаа холбоог үнэлэх бодит жишээ болсон гэж дүгнэж болно.

3.3.3. Монгол-Оросын эрх зүйн туслалцааны гэрээ ба Ромын дүрмийн үүргийн харьцуулалт

Монгол Улс нь нэг талаас Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн оролцогч улсын хувьд ОУЭШ-тэй хамтран ажиллах, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх олон улсын эрх зүйн үүрэг хүлээдэг. Нөгөө талаас Монгол Улс Оросын Холбооны Улстай 1999 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан “Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээ”-гээр мөн тодорхой үүрэг хүлээсэн байдаг. Иймээс эдгээр хоёр эрх зүйн эх сурвалжийн хоорондын харилцан хамаарал, уялдаа холбоог судлах нь Монгол Улсын хувьд онолын төдийгүй практик ач холбогдолтой юм.

Ромын дүрмийн үндсэн зорилго нь төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон түрэмгийллийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг ял шийтгэлгүй үлдээхгүй байх явдал бөгөөд гишүүн улсуудыг ОУЭШ-тэй бүрэн хамтран ажиллах үүрэгтэй гэж үздэг (Rome Statute, Articles 86-89). Харин Монгол-Оросын эрх зүйн туслалцааны гэрээ нь хоёр улсын хооронд эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд харилцан туслалцаа үзүүлэх, нотлох баримт солилцох, шүүхийн баримт бичиг гардуулах зэрэг уламжлалт эрүүгийн эрх зүйн хамтын ажиллагааг зохицуулах зорилготой.

Эдгээр хоёр эрх зүйн баримт бичгийн зорилго өөр боловч тодорхой нөхцөлд тэдгээрийн хэрэгжилт давхардах боломжтой. Ялангуяа ОУЭШ-ийн баривчлах тогтоол гарсан этгээд ОХУ-ын иргэн эсвэл төрийн өндөр албан тушаалтан байх тохиолдолд Монгол Улсын өмнө эрх зүйн төвөгтэй нөхцөл байдал үүсч болзошгүй юм.

Ромын дүрмийн хүрээнд хүлээсэн үүрэг

Ромын дүрмийн 86 дугаар зүйлд:

- “Оролцогч улсууд энэхүү дүрмийн хүрээнд шүүхтэй бүрэн хамтран ажиллана” гэж заасан байдаг (Rome Statute, Article 86).

Мөн 89 дүгээр зүйлд ОУЭШ-ийн баривчлах тогтоол гарсан этгээдийг баривчлах болон шүүхэд шилжүүлэх асуудлыг зохицуулсан байдаг.

Үүнээс үзэхэд Монгол Улс Ромын дүрмийн оролцогч улсын хувьд ОУЭШ-ийн хууль ёсны хүсэлтийг хэрэгжүүлэх олон улсын гэрээний үүрэг хүлээж байна.

Монгол-Оросын гэрээний хүрээнд хүлээсэн үүрэг

1999 оны гэрээ нь үндсэндээ хоёр улсын шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулдаг. Гэрээнд:

- эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд туслалцаа үзүүлэх;
- баримт бичиг дамжуулах;
- гэрчээс мэдүүлэг авах;
- нотлох баримт гаргаж өгөх;
- эрүүгийн шийдвэрийн талаарх мэдээлэл солилцох зэрэг асуудлыг зохицуулсан байдаг.

Гэвч уг гэрээнд ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүрэгтэй холбоотой ямар нэгэн тусгай зохицуулалт байхгүй. Учир нь уг гэрээ 1999 онд буюу ОУЭШ албан ёсоор байгуулагдахаас өмнө байгуулагдсан бөгөөд ОУЭШ-тэй холбоотой асуудлыг зохицуулах шаардлага тухайн үед үүсээгүй байсан юм.

Иймээс уг гэрээ нь ОУЭШ-ийн баривчлах тогтоолыг хэрэгжүүлэхээс шууд татгалзах үндэслэл болж байгаа эсэх асуудал эрх зүйн тайлбар шаардсан асуудал хэвээр байна.

Эрх зүйн зөрчил үүсэх боломжтой нөхцөл байдал- Онолын хувьд дараах нөхцөл байдал үүсч болно: ОУЭШ нь ОХУ-ын иргэн эсвэл өндөр албан тушаалтанд холбогдуулан баривчлах тогтоол гаргана.

Энэ нөхцөлд Монгол Улс:

- Ромын дүрмийн дагуу ОУЭШ-тэй хамтран ажиллах үүрэгтэй;
- нөгөө талаас ОХУ-тай байгуулсан олон улсын гэрээ болон хоёр улсын харилцааг харгалзан үзэх шаардлагатай болно.

Энэ нь олон улсын эрх зүйн онолд “**competing treaty obligations**” буюу олон улсын гэрээний үүргүүдийн өрсөлдөөн гэж нэрлэгддэг асуудалтай холбоотой юм (Vienna Convention on the Law of Treaties, 1969).

Гэхдээ эрх зүйн үүднээс авч үзвэл Монгол–Оросын гэрээнд ОУЭШ-ийн баривчлах тогтоолыг хэрэгжүүлэхийг хориглосон заалт байхгүй. Өөрөөр хэлбэл хоёр гэрээний хооронд шууд текстэн зөрчил байхгүй гэж үзэх үндэслэлтэй.

Харин практикт улс төр, дипломат харилцааны хүчин зүйлс эрх зүйн асуудалтай хавсарч гарч ирдэг нь хүндрэл үүсгэдэг.

Путинтай холбоотой нөхцөл байдал дахь эрх зүйн асуудал

2024 онд ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин Монгол Улсад айлчлах үед дээр дурдсан асуудал бодит ач холбогдолтой болсон.

ОУЭШ 2023 онд түүнд холбогдуулан баривчлах тогтоол гаргасан байсан бөгөөд Монгол Улс Ромын дүрмийн оролцогч улсын хувьд олон улсын хэмжээнд анхаарлын төвд орсон юм.

Энэ үед зарим судлаач Монгол Улс Ромын дүрмийн дагуу баривчлах үүрэгтэй байсан гэж үзсэн бол нөгөө хэсэг нь төрийн тэргүүний дархан эрх, олон улсын харилцааны онцгой нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай байсан гэж тайлбарласан байдаг (Akande, 2017; Schabas, 2023).

Үүнээс харахад бодит асуудал нь зөвхөн Монгол–Оросын гэрээнээс бус, харин Ромын дүрмийн 27 болон 98 дугаар зүйлүүдийн тайлбар, төрийн тэргүүний дархан эрхийн асуудалтай илүү холбоотой болох нь харагдаж байна.

Хүснэгт 3.1. ОУЭШ-ийн практик кейсүүдийн харьцуулсан шинжилгээ

Шалгуур	Ромын дүрэм	Монгол- Оросын гэрээ
Батлагдсан он	1998	1999

Зорилго	ОУЭШ-ийн үйл ажиллагааг зохицуулах	Хоёр улсын эрх зүйн туслалцааг зохицуулах
Субъект	ОУЭШ ба гишүүн улсууд	Монгол Улс ба ОХУ
Хамрах хүрээ	Олон улсын хүнд гэмт хэрэг	Иргэний болон эрүүгийн хэрэг
Баривчлах асуудал	ОУЭШ-д шилжүүлэх боломжтой	Шууд зохицуулаагүй
Төрийн тэргүүний дархан эрх	27-р зүйлээр хязгаарлана	Тусгай зохицуулалтгүй
ОУЭШ-тэй хамтын ажиллагаа	Тийм	Үгүй

Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэл

Хүснэгтээс харахад эдгээр хоёр эрх зүйн баримт бичгийн зорилго, зохицуулах харилцаа харилцан адилгүй бөгөөд шууд эрх зүйн зөрчил үүсгэдэггүй байна. Харин практик хэрэгжилтийн түвшинд олон улсын эрүүгийн эрх зүйн үүрэг болон гадаад бодлогын ашиг сонирхлын хооронд тэнцвэр олох шаардлага үүсдэг.

Дүгнэлт

Монгол Улс Ромын дүрэм болон Монгол–Оросын эрх зүйн туслалцааны гэрээний аль алинд нь оролцогч тал боловч эдгээр гэрээ нь өөр өөр зорилго, өөр өөр харилцааг зохицуулдаг. Иймээс тэдгээрийн хооронд шууд эрх зүйн зөрчил бий гэж үзэх үндэслэл хангалтгүй байна. Харин төрийн өндөр албан тушаалтантай холбоотой нөхцөл байдал үүсэх үед Ромын дүрмийн өмнө хүлээсэн үүрэг, олон улсын нийтийн эрх зүйн дархан эрхийн зарчим болон хоёр талт харилцааны ашиг сонирхлыг хэрхэн уялдуулах асуудал Монгол Улсын өмнө тулгарч болох эрх зүйн томоохон сорилт хэвээр байна.

3.4. Харьцуулсан дүгнэлт

Энэхүү бүлгийн хүрээнд Олон улсын эрүүгийн шүүхийн үйл ажиллагаанд тулгарч буй эрх зүйн асуудлууд, шүүхийн практикт шийдвэрлэсэн томоохон хэргүүд болон Монгол Улсын эрх зүйн орчныг харьцуулан шинжиллээ. Судалгааны үр дүнгээс үзэхэд ОУЭШ нь олон улсын эрүүгийн эрх зүйн тогтолцооны төв байгууллага болж хөгжсөн хэдий ч түүний шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь зөвхөн эрх зүйн зохицуулалтаас бус улс төр, дипломат харилцаа, үндэсний аюулгүй байдал болон улсын бүрэн эрхт байдлын асуудалтай нягт холбоотой байдаг нь харагдаж байна.

Нэгдүгээрт, төрийн өндөр албан тушаалтны дархан эрхийн асуудал ОУЭШ-ийн практикт хамгийн их маргаан дагуулдаг асуудлын нэг хэвээр байна. Ромын дүрмийн 27 дугаар зүйлд төрийн албан тушаал эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэж заасан боловч 98 дугаар зүйл нь олон улсын эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн дархан эрхийн зарчмыг тодорхой хэмжээнд хадгалж үлдсэн байдаг. Үүнээс шалтгаалан төрийн тэргүүнтэй холбоотой асуудал үүсэх үед ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүрэг болон олон улсын нийтийн эрх зүйн уламжлалт зарчмуудын хооронд тайлбарын зөрүү үүсдэг болох нь Аль-Башир болон Путинтай холбоотой нөхцөл байдлаас тодорхой харагдсан (Rome Statute, Articles 27, 98; Akande, 2017).

Хоёрдугаарт, нөхөх зарчим (complementarity principle) нь ОУЭШ-ийн үйл ажиллагааны суурь зарчим хэвээр байгаа боловч түүнийг практикт хэрэгжүүлэх явцад хүндрэл үүсдэг байна. Тухайн улс хэрэг мөрдөн шалгах “хүсэлтэй” эсэх, эсхүл “чадамжтай” эсэхийг үнэлэх асуудал нь зөвхөн эрх зүйн бус улс төрийн шинжтэй маргаан болж хувирдаг. Ливи, Кени зэрэг улсуудын туршлагаас үзэхэд үндэсний шүүхийн тогтолцооны үр нөлөө, хараат бус байдал нь ОУЭШ-ийн оролцоог тодорхойлох гол хүчин зүйл болж байна (Burke-White, 2008; El Zeidy, 2008).

Гуравдугаарт, ОУЭШ-ийн практикт шийдвэрлэсэн томоохон хэргүүд нь олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхой харуулж байна. Доминик Онгвены хэрэг нь хүүхэд цэрэг ашиглах, бэлгийн хүчирхийлэл болон хохирогч төвтэй шударга ёсны тогтолцооны ач холбогдлыг тодорхойлсон. Жан-Пьер Бембагийн хэрэг нь командын хариуцлагын хүрээ, нотлох баримтын үнэлгээний асуудлыг тодруулсан. Ахмад Аль-Махдийн хэрэг нь соёлын өвийг хамгаалах асуудлыг олон улсын эрүүгийн эрх зүйн хамгаалалтын хүрээнд авч үзсэн анхны томоохон жишээ болсон. Харин Аль-Баширын хэрэг нь төрийн тэргүүний дархан эрх болон ОУЭШ-ийн шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой эрх зүйн маргааны сонгодог жишээ болж үлдсэн байна (ICC, 2016; ICC, 2021).

Дөрөвдүгээрт, Монгол Улсын эрх зүйн орчныг үнэлэхэд Ромын дүрмийн шаардлагыг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ахиц гарсан хэдий ч цаашид боловсронгуй болгох шаардлагатай асуудлууд байсаар байна. Монгол Улс олон улсын гэмт хэргүүдийг Эрүүгийн хуульдаа тусгаж, Ромын дүрмийн үндсэн үзэл баримтлалыг тодорхой хэмжээнд нутагшуулсан боловч ОУЭШ-тэй хамтран ажиллах тусгай хэрэгжилтийн хууль батлаагүй, процессын зохицуулалт хангалтгүй, эрх бүхий байгууллагуудын чиг үүргийн уялдаа бүрэн тодорхой болоогүй байгаа нь гол сул тал болж байна.

Тавдугаарт, 2024 онд ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин Монгол Улсад айлчилсан тохиолдол нь Монгол Улсын өмнө тулгарч болох эрх зүйн бодит сорилтыг харуулсан. Энэхүү нөхцөл байдал нь ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүрэг, төрийн тэргүүний дархан эрх, үндэсний аюулгүй байдал болон хоёр хөрштэй харилцах стратегийн харилцааны асуудлуудыг нэгэн зэрэг хөндсөнөөрөө онцлог байв. Үүнээс харахад олон улсын эрүүгийн эрх зүйн үүргийг хэрэгжүүлэх асуудал нь дан ганц хууль зүйн хүрээнд шийдвэрлэгдэхгүй бөгөөд гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын бодлоготой нягт уялдах шаардлагатай байна.

Зургаадугаарт, Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд байгуулсан эрх зүйн туслалцааны гэрээ болон Ромын дүрмийн зохицуулалтыг харьцуулан үзэхэд шууд эрх зүйн зөрчил илрээгүй боловч практик хэрэгжилтийн түвшинд тодорхой хүндрэл үүсэх боломжтой байна. Ялангуяа төрийн өндөр албан тушаалтан, ОУЭШ-ийн баривчлах тогтоол, олон улсын хамтын ажиллагааны асуудал зэрэгцэн үүсэх үед хоёр талт болон олон талт гэрээний үүргийг хэрхэн уялдуулах асуудал Монгол Улсын хувьд онцгой ач холбогдолтой болох нь тогтоогдлоо.

Иймээс Монгол Улсын хувьд ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүргийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхийн тулд зөвхөн материаллаг эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоос гадна процессын эрх зүйн механизмыг боловсронгуй болгох, эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, олон улсын эрүүгийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх шаардлагатай байна. Мөн төрийн өндөр албан тушаалтны дархан эрх, олон улсын гэрээний үүргийн уялдаа холбоо зэрэг асуудлаар үндэсний хэмжээнд тодорхой эрх зүйн бодлого боловсруулах хэрэгцээ байгааг энэхүү судалгаа харуулж байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Олон улсын эрүүгийн шүүхийн эрх зүйн үндэс, харьяалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, эрүүгийн хариуцлагын тогтолцоог судалж, Монгол Улсын эрх зүйн орчин болон олон улсын гэрээний үүрэгтэй харьцуулан шинжилсний үндсэн дээр дараах дүгнэлтэд хүрэв.

Нэгдүгээрт, Олон улсын эрүүгийн шүүх нь төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон түрэмгийллийн гэмт хэрэг зэрэг олон улсын хамтын нийгэмлэгийн ашиг сонирхолд хамгийн ноцтой хохирол учруулдаг гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүн таслах чиг үүрэг бүхий анхны байнгын олон улсын эрүүгийн шүүх болох нь тогтоогдлоо. Нюрнбергийн болон Токиогийн шүүхүүд, хуучин Югослав болон Руандагийн олон улсын эрүүгийн трибуналуудын туршлагад тулгуурлан байгуулагдсан ОУЭШ нь олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн чухал үе шат болжээ.

Хоёрдугаарт, ОУЭШ-ийн үйл ажиллагааны үндэс болсон нөхөх зарчим нь улсын бүрэн эрхт байдал болон олон улсын эрүүгийн шударга ёсны хоорондын тэнцвэрийг хангах үндсэн механизм болох нь тогтоогдов. Энэхүү зарчмын дагуу үндэсний шүүх анхдагч харьяаллыг хэрэгжүүлж, зөвхөн тухайн улс мөрдөн шалгах болон шүүх ажиллагааг бодитоор хэрэгжүүлэх боломжгүй эсвэл хүсэлгүй байгаа нөхцөлд ОУЭШ харьяаллаа хэрэгжүүлдэг байна.

Гуравдугаарт, Ромын дүрмийн 27 болон 98 дугаар зүйлүүдийн харилцан хамаарал нь өнөөдөр ч олон улсын эрүүгийн эрх зүйн хамгийн маргаантай асуудлын нэг хэвээр байна. Аль-Башир болон Владимир Путинтай холбоотой нөхцөл байдал нь төрийн өндөр албан тушаалтны дархан эрх болон ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүргийн хооронд бодит зөрчил үүсэх боломжтойг харуулж байна.

Дөрөвдүгээрт, Монгол Улс Ромын дүрэмд нэгдсэнээс хойш олон улсын эрүүгийн эрх зүйн зарим шаардлагыг дотоодын хууль тогтоомждоо тусгасан бөгөөд 2015 оны Эрүүгийн хуульд олон улсын гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнүүдийг хуульчилсан нь чухал ахиц болсон байна. Гэвч ОУЭШ-тэй хамтран ажиллах тусгай хэрэгжилтийн хууль батлагдаагүй, эрүүгийн процессын зохицуулалт хангалтгүй байгаа нь эрх зүйн орчны гол сул тал хэвээр байна.

Тавдугаарт, Монгол Улс болон Оросын Холбооны Улсын хооронд байгуулсан 1999 оны эрх зүйн туслалцааны гэрээ нь Ромын дүрэмтэй шууд зөрчилдөж байна гэж үзэх үндэслэл хангалтгүй боловч төрийн өндөр албан тушаалтныг шилжүүлэх, баривчлахтай холбоотой

нөхцөл байдал үүсэх үед олон улсын болон хоёр талт гэрээний үүргийг хэрхэн уялдуулах асуудал тодорхой бус хэвээр байна.

Зургаадугаарт, 2024 онд ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин Монгол Улсад айлчилсан үйл явдал нь Монгол Улсын өмнө тулгарч болох эрх зүйн болон гадаад бодлогын бодит сорилтыг тодорхой харуулсан. Энэхүү нөхцөл байдал нь ОУЭШ-ийн өмнө хүлээсэн үүрэг, төрийн тэргүүний дархан эрх, үндэсний аюулгүй байдал болон гадаад бодлогын ашиг сонирхлыг зэрэг авч үзэх шаардлагатайг харуулсан юм.

Долоодугаарт, Монгол Улс олон улсын эрүүгийн эрх зүйн өмнө хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэхийн тулд материаллаг эрх зүйн зохицуулалтаас гадна процессын эрх зүйн механизм, институцийн чадавх, олон улсын хамтын ажиллагааны тогтолцоог цаашид боловсронгуй болгох шаардлагатай байна.

САНАЛ

Судалгааны үр дүнд үндэслэн Монгол Улсын эрх зүйн орчин болон институцийн чадавхыг боловсронгуй болгох зорилгоор дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

Нэгдүгээрт, ОУЭШ-тэй хамтран ажиллах асуудлыг иж бүрнээр зохицуулсан бие даасан хэрэгжилтийн хууль батлах шаардлагатай. Уг хуулиар ОУЭШ-ийн хүсэлт хүлээн авах, баривчлах тогтоол биелүүлэх, этгээд шилжүүлэх, нотлох баримт дамжуулах, хөрөнгө битүүмжлэх, царцаах болон гэрч, хохирогч хамгаалах ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхой болгох нь зүйтэй.

Хоёрдугаарт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд ОУЭШ-тэй хамтран ажиллахтай холбоотой тусгай бүлэг нэмж, ОУЭШ-ийн хүсэлтийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, ажиллагааны үе шат, шүүхийн хяналтын асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай.

Гуравдугаарт, олон улсын эрүүгийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн шүүгч, прокурор, мөрдөгч, хуульчдыг бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог хөгжүүлэх нь зүйтэй. Ингэснээр ОУЭШ-ийн харьяалах гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг үндэсний түвшинд үр дүнтэй шийдвэрлэх боломж нэмэгдэнэ.

Дөрөвдүгээрт, Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын Ерөнхий прокурорын газар болон шүүхийн байгууллагын хоорондын хамтын ажиллагааны механизмыг боловсронгуй болгож, байгууллагуудын уялдаа холбоог бэхжүүлэх шаардлагатай.

Тавдугаарт, төрийн өндөр албан тушаалтны дархан эрх, Ромын дүрмийн 27 болон 98 дугаар зүйлүүдийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар үндэсний хэмжээнд нэгдсэн бодлого, албан ёсны тайлбар боловсруулах шаардлагатай.

Зургаадугаарт, Эрүүгийн хуульд командын хариуцлага, албадан алга болгох, бэлгийн боолчлол зэрэг Ромын дүрэмд тусгагдсан олон улсын гэмт хэргийн бүрэлдэхүүн, ойлголтуудыг илүү нарийвчлан тусгах боломжийг судлах нь зүйтэй.

Долоодугаарт, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүд болон Ромын дүрмийн хэрэгжилтийн уялдаа холбоог тогтмол үнэлэх эрх зүйн механизм бүрдүүлж, олон улсын өмнө хүлээсэн үүргийг үндэсний эрх зүйн тогтолцоотой үр ашигтай уялдуулах шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм (Rome Statute of the International Criminal Court), 1998 он.
3. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015 он.
4. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он.
5. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 2021 он.
6. Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хууль, 1993 он.
7. Монгол Улсын Гадаад харилцааны тухай хууль, 2016 он.
8. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээ, 1999 оны 04 дүгээр сарын 20.
9. Convention on the Prevention and Punishment of the Crime of Genocide, United Nations, 1948.
10. Geneva Conventions of 1949 and Additional Protocols.
11. United Nations Security Council Resolution 827 (1993) – Establishment of the International Criminal Tribunal for the Former Yugoslavia (ICTY).
12. United Nations Security Council Resolution 955 (1994) – Establishment of the International Criminal Tribunal for Rwanda (ICTR).

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Д.Мөнхтуяа, *Олон улсын эрүүгийн эрх зүйн зарим асуудал*, Улаанбаатар, 2000 он.
2. В.Оюумаа, “Олон улсын эрүүгийн шүүх байгуулах түүхэн асуудал”, *Хууль зүйн сэтгүүл*, №2, 2002 он.
3. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, *Олон улсын эрүүгийн эрх зүйн зарим асуудал*, Улаанбаатар, 1999 он.
4. Наумов А.В., Кибальник А.Г., Орлов В.Н., *Олон улсын эрүүгийн эрх зүй*, Улаанбаатар, 2015 он.
5. Монгол Улсын Гадаад харилцааны яам, *Монгол Улсын шүүгч Олон улсын эрүүгийн шүүхийн шүүгчээр сонгогдлоо*, Улаанбаатар, 2023 он.
6. Монгол Улсын Гадаад харилцааны яам, *Олон улсын эрүүгийн шүүхтэй хамтын ажиллагааны талаарх мэдээлэл, тайлан*, Улаанбаатар, 2024 он.

7. Шүүхийн ерөнхий зөвлөл, *Монгол Улсын шүүхийн 2022 оны шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ*, Улаанбаатар, 2023 он.
8. Оюунболд Б., *Олон улсын эрүүгийн эрх зүйн зарим асуудал*, Улаанбаатар, 2014 он.

3. Гадаад хэл оээрх эх сурвалж:

А. Англи хэл дээр

1. Akande, D. International Law Immunities and the International Criminal Court. *American Journal of International Law*, 2017.
2. Burke-White, W. Proactive Complementarity: The International Criminal Court and National Courts in the Rome System of International Justice. *Harvard International Law Journal*, Vol. 49, No. 1, 2008.
3. Cassese, A. *International Criminal Law* (3rd ed.). Oxford University Press, 2013.
4. Cryer, R., Friman, H., Robinson, D., & Wilmshurst, E. *An Introduction to International Criminal Law and Procedure* (2nd ed.). Cambridge University Press, 2010.
5. El Zeidy, M. M. *The Principle of Complementarity in International Criminal Law*. Martinus Nijhoff Publishers, 2008.
6. Guilfoyle, D. *International Criminal Law*. Oxford University Press, 2016.
7. Hall, C. K. "The First Proposal for a Permanent International Criminal Court." *International Review of the Red Cross*, No. 322, 1998.
8. Schabas, W. A. *The International Criminal Court: A Commentary on the Rome Statute* (2nd ed.). Oxford University Press, 2016.
9. Schabas, W. A. *An Introduction to the International Criminal Court* (6th ed.). Cambridge University Press, 2020.
10. Stahn, C. *The Law and Practice of the International Criminal Court*. Oxford University Press, 2015.
11. Werle, G., & Jeßberger, F. *Principles of International Criminal Law* (4th ed.). Oxford University Press, 2020.
12. Bassiouni, M. Cherif. *Introduction to International Criminal Law* (2nd ed.). Brill Nijhoff, 2013.
13. International Criminal Court. *Prosecutor v. Dominic Ongwen, Judgment*, ICC-02/04-01/15, 2021.
14. International Criminal Court. *Prosecutor v. Ahmad Al Faqi Al Mahdi, Judgment and Sentence*, ICC-01/12-01/15, 2016.

15. International Criminal Court. Prosecutor v. Jean-Pierre Bemba Gombo, Appeals Judgment, ICC-01/05-01/08, 2018.
16. International Criminal Court. Jordan Referral re Al-Bashir Appeal Judgment, ICC-02/05-01/09 OA2, (2019).
17. International Criminal Court. Situation in Ukraine: Arrest Warrants against Vladimir Putin and Maria Lvova-Belova, (2023).
18. de Hoon, M. "The ICC's Al Mahdi Case: Cultural Destruction as a War Crime." Journal of International Criminal Justice, (2016).
19. Roffér, J. Nuremberg: The Last Battle. (2020).
20. Dempsey, G. "Reasonable Doubt: The Case against the Proposed International Criminal Court." Cato Institute Policy Analysis, (1998).

Б. Орос хэл дээр

1. Заявление Министерства иностранных дел Российской Федерации о позиции Российской Федерации в отношении Римского статута Международного уголовного суда. Москва, (2016).
2. Лукашук И.И., Наумов А.В. Международное уголовное право. Москва: Спарк, (1999).
3. Кибальник А.Г. Международное уголовное право. Москва: Юрайт, (2017).

4. Цахим эх сурвалж

1. International Criminal Court. Official Website. <https://www.icc-cpi.int/>
2. Assembly of States Parties to the Rome Statute. <https://asp.icc-cpi.int/>
3. United Nations Treaty Collection. <https://treaties.un.org/>
4. United Nations International Law Commission. <https://legal.un.org/ilc/>
5. United Nations. Official Website. <https://www.un.org/>
6. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://legalinfo.mn/>
7. Монгол Улсын Гадаад харилцааны яам. <https://mfa.gov.mn/>
8. Шүүхийн ерөнхий зөвлөл. <https://judcouncil.mn/>
9. Human Rights Watch. <https://www.hrw.org/>